

Бага, дунд сургуулиудад зориулсан практик үйл ажиллагаа





НҮБ-ын Хүний Эрхийн
Дээд комиссарын газар

Нэгдсэн Үндэстний Байгууллага
Хүний Эрхийн Боловсролын Арван Жил (1995–2004)
№4



ХҮНИЙ ЭРХИЙГ ЗААХ НЬ

Бага, дунд сургуулиудад
зориулсан практик
үйл ажиллагаа



НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ
БАЙГУУЛЛАГА

ТЭМДЭГЛЭЛ

Энэ цувралд агуулагдаж буй материалыг чөлөөтэй эш татаж, дахин хэвлэж болох бөгөөд дахин хэвлэсэн материалын хэвлэлийн хувийг НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газар, Швейцарь, 1211 Женев 10 хаягаар илгээнэ үү.

HR/PUB/DECADE/2003/1

UNITED NATIONS PUBLICATION

Sales No. E.03.XIV.3

ISBN 92-1-154149-2

Энэхүү хэвлэлд ашигласан тэмдэглэгээ, танилцуулга нь НҮБ-ын Нарийн бичгийн дарга нарын газраас аливаа улс орон, нутаг дэвсгэр, хот, бүс нутаг, түүний эрх бүхий байгууллагын эрх зүйн байдлын талаар, эсвэл түүний хил, хил хязгаарыг тогтоохтой холбоотой аливаа санал бодлыг илэрхийлэхгүй.

Хүний эрхийн боловсролын үндэсний чадавхыг дээшлүүлэх, сайн туршлага солилцож, бодлогын зөвлөмж боловсруулах зорилгоор Монголын Эмнести Интернэшнлээс санаачлан ХЭҮК, Боловсролын яам, МУИС - Хууль зүйн сургууль, Отгонтэнгэр их сургууль, Монголын хуульчдын холбоо, Хууль зүйн клиник сургалтын Ахиц нийгэмлэг зэрэг байгууллагуудтай хамтран 5 дахь удаагаа зохион байгуулж буй "Хүний эрхийн боловсролын симпозиум 2025"-д зориулж хэвлэв.

ӨМНӨХ ҮГ

“АБВ: Хүний эрхийг заах нь – Бага, дунд сургуулиудад зориулсан практик үйл ажиллагаа” товхимол нь хүн төрөлхтөн бидний тухай, “дэлхийн эрх чөлөө, шударга ёс, энх тайвны үндэс” (Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Оршил хэсэг) болох “хүний нэр төр, үнэ цэн”-ийн ач холбогдлыг сургах, суралцах үйл явцын тухай авч үзэх болно. Энэхүү цуврал нь бид бүгдэд хамаатай эрхийн тухай юм.

Энэ бол зөвхөн танхимын сургалтад зориулсан хичээл биш, харин бидний өдөр тутмын амьдрал, туршлагатай шууд хамааралтай амьдралын хичээлүүд юм. Энэ утгаараа хүний эрхийн боловсрол гэдэг нь хүний эрхийн талаар сургах, суралцах үйл явц төдийгүй, хүний эрхийн төлөөх үйл ажиллагаа бөгөөд үндсэн үүрэг нь хувь хүмүүст өөрсдийн болон бусдын эрхийг хамгаалах боломжийг олгох явдал юм. Үүнийг бодит үйл хэрэг болгох нь хүн бүрийн эрхийг дээдэлж, хүндэтгэдэг шударга нийгэмд хүрэхэд чиглэсэн ирээдүйн төлөөх чухал хөрөнгө оруулалт билээ.

Засгийн газар, олон улсын байгууллага, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо, иргэний нийгмийн бүхий л салбарууд, хувь хүмүүсийг хүний эрхийн боловсролыг дээшлүүлэхэд хамтран ажиллаж, хүчин чармайлтаа төвлөрүүлэхийг онцгойлон дэмжиж байгаа энэ цаг үед энэхүү товхимол нь НҮБ-ын Хүний эрхийн боловсролыг дэмжих арван (1995-2004)-д Хүний эрхийн дээд комиссарын газрын оруулж буй бодит хувь нэмэр болно. Энэхүү арван нь бидний хамтран ажиллах хүрээг тодорхойлж, хувь нэмрээ оруулах хүсэл тэмүүлэлтэй хэн бүхний хичээл зүтгэлээс хэрэгжилт нь бүрэн хамаарна. Энэ товхимол, үүнд үндэслэсэн бусад санаачилгууд нь дэлхийн өнцөг булан бүрд байгаа багш болон сургагчдыг эерэг өөрчлөлтийг түүчээлэгч чиглүүлнэ хэмээн найдаж байна.

Товхимлыг бэлтгэхэд НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газарт дэмжлэг үзүүлсэн хувь хүн, байгууллагууд, ялангуяа 1989 оны анхны эхийг боловсруулсан Ральф Петтман, тэрхүү хэвлэлийг засварлан, шинэчилсэн Нэнси Флоуэрс; болон сайжруулах санал, зөвлөмжийг өгсөн Маргот Браун, Фелиса Тиббиттс болон ЮНЕСКО-гийн Чанартай Боловсролыг Дэмжих Хэлтсийн хамт олонд талархал илэрхийлье.

Сержио Виейра де Мелло
НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссар

АГУУЛГА

Танилцуулга: АБВ: Хүний эрхийг заах нь	6
Нэгдүгээр бүлэг: Хүний эрхийн боловсролын үндэс	9
Хүний эрхийн хөгжил	10
Хүний эрхийг хангах	13
НҮБ-ын Хүний эрхийн боловсролын арван (1995-2004)	15
Сургууль дахь хүний эрхийн боловсролын үйл явц	16
Хүний эрхийн боловсролын агуулга	18
Хүний эрхийн төлөө хүний эрхийг заах нь	20
Эрх, хариуцлага	21
Сургахуй, заахуй - үйлдэл үгнээс илүү хүчтэй	22
Хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх нь	24
Хүний эрхийн боловсролын заах арга зүй	25
Үнэлгээ	29
Хоёрдугаар бүлэг: Сургуулийн өмнөх болон бага боловсролын сургууль дахь хүний эрхийн сэдвүүд	31
Өөртөө итгэх итгэл ба нийгмийн хүндлэл	32
Зөрчилдөөнийг шийдвэрлэх	32
Ялгаварлан гадуурхалттай тэмцэх	33
Ижил болон ялгаатай байдлыг хүндэтгэх	34
Өөртөө итгэх илтгэлийг нэмэгдүүлэх	35
Итгэлцлийг бий болгох	40
Ангийн дүрмийг бий болгох	41
Хүний эрхийн ойлголт	43
Хүүхдийн эрхийг танилцуулах	44
Гуравдугаар бүлэг: Бага, дунд, болон ахлах сургууль дахь хүний эрхийн сэдвүүд	49
Нийгэм дэх хувь хүн - Хүний амьдралыг хамгаалах	50
Дайн, энх тайван ба хүний эрх	52
Төр ба эрх зүй	57
Бодож сэтгэх, үзэл санаа, шашин шүтлэг, үзэл бодол болон түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө	63

Хувийн халдашгүй байх эрх	65
Зөвлөлдөх, нийтийн үйл хэрэгт оролцох эрх чөлөө	66
Нийгэм болон соёлын сайн сайхан байдал	68
Ялгаварлан гадуурхалт	69
1. Ялгаварлан гадуурхалт - хэвшмэл ойлголт	70
2. Ялгаварлан гадуурхалт - арьсны өнгө, үндэс угсаа	71
3. Ялгаварлан гадуурхалт - цөөнхийн эрх зүйн байдал	72
4. Ялгаварлан гадуурхалт - жендэр	75
5. Ялгаварлан гадуурхалт - хөгжлийн бэрхшээлтэй байдал	79
Сурч боловсрох эрх	79
Хөгжил ба байгаль орчин	82
Эдийн засгийн хөгжил ба харилцан хамаарал	89
Бизнес ба хүний эрх	92
НҮБ-ын талаарх ойлголт	94
Хүний эрхэд ээлтэй орчныг бий болгох	96
Сургуулийнхаа хүний эрхийг хэмжих	97
Дөнгөж эхлэл	99

АБВ:

Хүний эрхийг заах нь

АБВ: Хүний эрхийг заах нь товхимол нь суралцагч нарт ээлтэйгээр хүний эрхийн боловсрол олгоход ашиглах хялбар хэрэгсэл бөгөөд хүний эрхийн хэд хэдэн үндсэн хүрээг хамарсан. Товхимол нь бага, дунд сургуулийн суралцагчдад хүний эрхийн мэдлэг, үйл ажиллагааг төлөвшүүлэх хүсэлтэй багш, бусад сургагч нарт практик зөвлөгөө, тэр дундаа сургалтын ажиллагааг хөгжүүлэх зөвлөмжийг санал болгож байгаа бөгөөд сургалтын хөтөлбөрт нэмэлт ачаалал өгөх зорилгогүй, харин сургуулиудад нэгэнт зааж байгаа хичээлүүдэд хүний эрхийн асуудлыг тусгахад туслах зорилготой юм.

Хүүхэд, залуучууд өсөж томрохын хэрээр аливаа асуудалд үнэлэлт, дүгнэлт өгөх чадвар хэрхэн хөгждөг талаар олон судалгаа байдаг. Ангид байгаа суралцагч бүр хүний эрхийн бүх зарчмыг бүрэн ойлгож чадахгүй байж магадгүй. Суралцагчдыг анхнаас нь хүний эрхийг ойлгохыг шахах нь тэдний бодож, мэдэрч байгаа зүйлээ шударгаар илэрхийлэхэд тус нэмэр болохоос илүүтэй цаашид гаргах ахиц дэвшилд хаалт болохыг ч үгүйсгэхгүй. Хүний эрхийг судалснаар хүн бүр ямар нэгэн байдлаар үр шим хүртэх боломжтой бөгөөд арван нас хүрэхээсээ өмнө ийм боломжийг хүртсэн хүүхдүүд ердийнхөөсөө хавь илүү амьд, гүн гүнзгий эргэцүүлэн бодох чадвартай болно гэдэгт бид итгэж байна. Товхимолд санал болгож буй үйл ажиллагаа нь цөөн хэдэн нэмэлт материал шаардана. Гэвч үүнээс илүүтэйгээр бүх багш нартай хамтран ажиллах хамгийн баялаг нөөц болох суралцагч нар болон тэдний өдөр тутмын амьдралын туршлагад илүүтэй үндэслэх болно.

Нэгдүгээр бүлэгт хүний эрхийн үндсэн ойлголтууд болон хүний эрхийн боловсролын үндэс, суурийн талаар тусгасан. Энэ бүлэгт үндсэн агуулга, арга зүйн асуудлыг хөндөж, оролцооны арга техникийг нарийвчлан боловсруулсан.

Хоёрдугаар бүлэг нь бага ангийн багш нарт чиглэсэн бөгөөд хүний нэр төр, тэгш байдлын тухай хүний эрхийн зарчмуудын талаарх материалаар дамжуулан бага насны хүүхдүүдэд өөрийнхөө болон бусдын үнэ цэнийн талаарх ойлголтыг төлөвшүүлэх зөвлөмжийг санал болгоно.

Гуравдугаар бүлэгт дунд ангийн суралцагчдад зориулсан өнөөгийн тулгамдсан асуудлыг хөндсөн арай илүү нарийвчилсан үйл ажиллагаануудыг тусгасан.

Хоёр, Гуравдугаар бүлгийн үйл ажиллагаа нь суралцагчдад дэлхий даяарх болон өөрсдийн анги, нийгэм дэх хүний эрхийн асуудлын талаар илүү гүнзгий ойлголт, хандлага өгөх зорилготой. Эдгээр үйл ажиллагаа нь бие даасан бодол, судалгаа шинжилгээг идэвхжүүлж, ардчилсан нийгэмд идэвхтэй иргэнийг төлөвшүүлэх ур чадварыг бий болгох зорилготой бөгөөд суралцагчдын сэтгэл ханамж мөн чухал

юм. Суралцагчид хэт их эсэргүүцэл үзүүлбэл үйл ажиллагаагаа орхих эсвэл зогсоохыг зөвлөж байна.

Үйл ажиллагаа бүрийн дараа нэгдүгээр бүлгийн I, II хавсралтад тус тус хавсаргасан Нэгдсэн Үндэстний Байгууллагын хоёр чухал баримт бичиг болох Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, Хүүхдийн эрхийн тухай конвенцын холбогдох заалтыг дурдсан. Эдгээр хавсралууд нь үйл ажиллагааг сэдэлжүүлэн дэмжих зорилготой; Гэхдээ үйл ажиллагаа нь олон улсын эрх зүйгээр хүлээн зөвшөөрсөн дээр дурдсан баримт бичигт агуулагдах эрхийн хамрах хүрээ, хэм, хэмжээг бүрэн илэрхийлэх албагүй.. Хавсралт 3-т эдгээр хүний эрхийн баримт бичигт ашигласан нэр томъёоны товч тайлбарыг тусгасан.

“АБВ: Хүний эрхийг заах нь” товхимол сургуулийн суралцагчдад хүний эрхийн боловсрол олгох дэлхийн хэмжээний эх сурвалжийн нэг юм. Энэ нь бүх шатны боловсролын түвшинд соёлын онцлогт нийцсэн сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулахад чиглэсэн цаашдын судалгаа, шижилгээний эхлэл бөгөөд багш сурган хүмүүжүүлэгч, хэрэглэгчдид тусламж, дэмжлэг авах зорилгоор ханддаг орон нутгийн оролцогчдын (төрийн байгууллагууд, хүний эрхийн үндэсний байгууллага, төрийн бус байгууллага болон иргэний нийгмийн бусад байгууллагууд) боловсруулсан бусад материалтай хамтатган эсвэл нэмэлт болгон баяжуулах боломжтой. Мөн дээрх байгууллагуудад

Олон улсын болон бүс нутгийн түвшинд боловсруулсан бусад хичээлийн материалуудыг Хавсралт 5-д оруулсан; бичвэрт дурдсан төрөл бүрийн баримт бичгүүд болон бусад материалыг Хавсралт 4-т дурдсан байгууллагууд болон тэдгээрийн тухайн улс дахь салбараас авч болно.



Хүний эрхийн боловсролын үндэс

Хүний эрх гэдгийг ерөнхийд нь бидний төрөлх мөн чанарт агуулагдах, түүнгүйгээр хүн шиг амьдарч чадахгүй эрх гэж тодорхойлж болно. Хүний эрх, үндсэн эрх чөлөө нь бид өөрсдийн мөн чанар, оюун ухаан, авьяас чадвар, үзэл санааг бүрэн хөгжүүлэх, ашиглах, оюун санааны болон бусад хэрэгцээгээ хангах боломжийг олгодог. Хүний эрх нь хүн төрөлхтний угаас заяасан нэр төр, үнэ цэнийг хүндэтгэж, хамгаалах талаарх өсөн нэмэгдэж байгаа амьдралын хэрэгцээ шаардлагад тулгуурладаг. Тэдгээрийг үгүйсгэх нь бие хүн болон хувь хүний эмгэнэл төдийгүй нийгэм, улс төрийн эмх замбараагүй байдлыг нөхцөлдүүлж, нийгэм, үндэстэн хоорондын хүчирхийлэл, зөрчилдөөний үрийг тарьж байна.

Хүний эрхийн хөгжил

Хүний эрхийн түүхийг дэлхийн бүхий л томоохон үйл явдлууд, хүний нэр төр, эрх чөлөө, тэгш байдлын төлөөх тэмцэл бүрдүүлсээр ирсэн. Гэвч НҮБ байгуулагдсанаар хүний эрх албан ёсоор, түгээмэл байдлаар хүлээн зөвшөөрөгдсөн юм.

Дэлхийн хоёрдугаар дайны үймээн, харгислал болон тусгаар тогтнолын төлөөх колониололын эсрэг үндэстнүүдийн тэмцэл нь дэлхийн улс орнуудыг дайны зарим үр дагаврыг арилгах, ялангуяа ийм аймшигт үйл явдлууд дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх хурал, чуулганыг бий болгох түлхэц болсон. Энэхүү хурал, чуулганы үр дүн НҮБ юм.

1945 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагыг үүсгэн байгуулахдаа оролцогч бүх ард түмнүүдийн хүний эрхийн төлөөх итгэлийг дахин баталгаажуулсан. НҮБ-ыг үүсгэн байгуулах дүрэмд хүний эрх нь тэдний санаа зовнилын гол цөм болохыг дурдсан бөгөөд тэр цагаас хойш энэхүү байр суурь хэвээр байна.

Шинээр байгуулагдсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын анхны томоохон ололт, амжилтын нэг нь 1948 оны 12 дугаар сарын 10-нд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталсан Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал¹ юм. Энэхүү хүчирхэг баримт бичиг нь дэлхийн өнцөг булан бүрд хүмүүсийн амьдралд асар их нөлөө үзүүлсээр байна. Энэ бол түүхэнд анх удаа түгээмэл үнэт баримт бичгийг олон улсын байгууллагаас баталсан үйл явдал болсон юм. Түүнчлэн хүний эрх, үндсэн эрх чөлөөг нарийн тодорхой тусгаж өгсөн анхны тохиолдол байлаа.

Тунхаглалыг батлах үед олон улсын дэмжлэг үзүүлсэн. Тухайн үед Нэгдсэн Үндэстний Байгууллагыг бүрдүүлж байсан тавин найман гишүүн улс үзэл суртал, улс төрийн тогтолцоо, шашин шүтлэг болон соёлын гарал үүсэл, нийгэм-эдийн засгийн хөгжлийн хэв маягийн хувьд харилцан адилгүй байсан хэдий ч Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал нь хамтын зорилго, хүсэл тэмүүллийн нийтлэг байр суурь буюу олон улсын хамтын нийгэмлэгийн хүсэж буй дэ лхий ертөнцийн алсын харааг илэрхийлсэн юм.

Тунхаглалд «хүн төрөлхтөн гэх нэг гэр бүлийн гишүүн бүрийн угаас заяасан нэр төр нь дэлхий дээрх эрх чөлөө, шударга ёс, энх тайвны үндэс» болохыг хүлээн зөвшөөрсөн бөгөөд хүн бүрийн хүсэн тэмүүлж буй үндсэн эрх болох амьд явах, эрх чөлөөтэй байх, аюулгүй байдлыг хүлээн зөвшөөрөх; амьжиргааны зохих түвшинд

¹ For the full text and simplified version of the *Universal Declaration of Human Rights*, see annex 1.



аж төрөх; хавчигдан мөшгөгдөж байгаа улс орноос өөр бусад улс оронд хандан орогнол хүсэх эрх; хөрөнгө өмчлөх эрх; үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө; сурч боловсрох эрх; итгэл үнэмшил, үзэл санаа, шашин шүтэх эрх чөлөө; эрүүдэн шүүх, доромжлон харьцахаас ангид байх эрхтэй холбон авч үзсэн. Эдгээр нь дэлхийн даяар тархан оршин сууж байгаа хүн бүр (эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, хүүхдүүд, нийгмийн бүх бүлэг, нийгмийн эмзэг бүлэг эсэхээс үл хамааран) эдлэх угаас заяасан эрх бөгөөд хэн нэгний хүслээр олгодог, эсхүл хүчингүй болгож, саатуулдаг "бэлэг" биш.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Хорооны анхны даргаар ажиллаж байсан Элеонор Рузвельт эдгээр эрхийн нийтлэг шинж чанар болон үүрэг хариуцлагын аль алиныг нь онцлохдоо:

Хүний түгээмэл эрх хаанаас эхлэдэг вэ? Дэлхийн газрын зураг дээр тэмдэглэгдээгүй, дэндүү жижигхэн гэр, гэр оронтой маш ойрхон газруудаас буюу хувь хүний ертөнц; хүний амьдардаг орчин; сурдаг сургууль эсвэл коллеж; ажилладаг үйлдвэр, ферм эсвэл албан газраас эхэлдэг. Энд л эрэгтэй, эмэгтэй хүмүүс, хүүхдүүдшударга ёс, эрх тэгш боломж, ялгаварлан гадуурхахгүйгээр нэр төрийг эрэлхийлдэг юм. Хэрэв дээрх газруудад хүний эрхийг үл тоомсорловол дэлхийн хаана ч хүний эрх үнэ цэнгүйдэх болно. Хүний эрхийг эдгээр жижиг газруудад орон гэрт нь хангаж чадахгүй бол илүү том ертөнцөд ахиц дэвшил гаргах нь мөрөөдөл төдий болно.²
ХЭМЭЭСЭН ЮМ.

² Eleanor Roosevelt, "In Our Hands" (1958 speech delivered on the tenth anniversary of the Universal Declaration of Human Rights).

1998 онд Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал батлагдсаны тавин жилийн ойг тохиолдуулан Хүний эрхийн дээд комиссар Мэри Робинсон уг баримт бичгийг «хүн төрөлхтний түүхийн агуу их хүсэл эрмэлзлийн баримт бичгийн нэг» хэмээн нэрлэсэн. Энэ нь улс орнуудын Үндсэн хуулиудын загвар болж, дэлхийн хамгийн олон хэлээр орчуулагдсан нь үнэхээр бүхий л хүний эрхийн баримт бичгээс хамгийн түгээмэл байж чадсан юм.³

Тунхаглал нь хүний эрхийн олон улсын эрх зүйг бүрдүүлдэг дараа дараагийн хүний эрхийн баримт бичгүүдэд чухал нөлөө үзүүлсэн.⁴ Эдгээр баримт бичигт Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт (1966) болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (1966), тэдгээрт оролцогч улс орнуудын заавал даган биелүүлэх үүрэг хүлээсэн гэрээнүүд орно. Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал болон дээрх хоёр Пактууд нь хамтдаа Олон улсын Хүний Эрхийн Биллийг бүрдүүлдэг.

Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал болон дээрх хоёр Пактад тусгагдсан эрхүүдийг Арьс үндсээр алагчлах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц (1966) зэрэг бусад гэрээнд илүү нарийвчлан тусгаж, арьс үндэст үндэслэн хүнийг дээрд үзэх, эсхүл үзэн ядах үзэл санааг түгээн дэлгэрүүлэх нь хуулиар шийтгэгдэх үйлдэл хэмээн тунхагласан бол Эмэгтэйчүүдийн ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцод (1979) улс төр, нийгмийн амьдрал, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэнд, гэрлэлт, гэр бүл дэх эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах явдлыг арилгах арга хэмжээг тодорхойлсон.

Сургуультай холбогдох хэн бүхэнд онцгой ач холбогдолтой баримт бичиг бол хүүхдийн хүний эрхийн баталгааг тодорхойлсон Хүүхдийн эрхийн тухай конвенц юм.⁵ 1989 онд Ерөнхий Ассамблейгаас баталсан энэхүү конвенцыг хүний эрхийн бусад гэрээтэй харьцуулахад илүү олон тооны улс орон соёрхон баталсан байдаг. Энэ нь хүүхдийг хор хөнөөл, хүчирхийллээс хамгаалах, эрүүл мэнд, боловсрол, гэр бүлээр дамжуулан тэдний эсэн мэнд амьдрах, сайн сайхан байдлыг хангах явдлыг тусгайлан баталгаажуулснаас гадна нийгмийн харилцаанд оролцох, өөртэй нь холбоотой асуудлаар шийдвэр гаргахад оролцох эрхийг авч үзсэн. Саяхан тус конвенцын нэмэлт хоёр протокол болох Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлах тухай Нэмэлт протокол, Хүнийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг Нэмэлт протокол (2000)-ыг баталсан.

³ For more information on the Universal Declaration, including the text of the UDHR in more than 330 languages and dialects, see <http://www.ohchr.org> or contact the Office of the United Nations High Commissioner for Human Rights

⁴ For a brief introduction to international human rights law terminology, including some words used in this chapter such as “treaty”, “convention”, “protocol” and “ratification”, see annex 3. For a full overview of international human rights instruments, see <http://www.ohchr.org> or contact the Office of the United Nations High Commissioner for Human Rights.

⁵ For the full text and summarized version of the Convention on the Rights of the Child, see annex 2.

НҮБ-ын Хүний эрхийн үндсэн баримт бичгийг талаарх хүснэгт

Олон улсын эрхийн билл Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал (ХЭТТ), 1948				
Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт (ИУТЭОУП), 1966		Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт (ЭЗНСЭОУП), 1966		
Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай конвенц, 1951	Арьс үндсээр алагчлах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц, 1966	Эмэгтэйчүүдийн ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцод (1979)	Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, 1984	Хүүхдийн эрхийн тухай конвенц, 1989

Хүний эрхийг хангах

Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал батлагдсанаас хойш хүний эрх нь НҮБ-ын үйл ажиллагааны гол төв болсон. Ерөнхий нарийн бичгийн дарга Кофи Аннан Тунхаглал батлагдсаны 15 жилийн ойн үеэр хүний эрхийн түгээмэл шинжийг онцлон тэмдэглэн хэлсэн үгэндээ “Хүний эрх нь ямар ч улсад харь зүйл биш бөгөөд бүх үндэстний хувьд уугуул ойлголт байх ёстой”, “Хүний эрхгүйгээр энх тайван, хөгжил цэцэглэлт хэзээ ч үргэлжлэхгүй” хэмээжээ.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын тогтолцооны хүрээнд хүний эрхийг олон янзын механизм, процедур тухайлбал, ажлын хэсэг, хороод; тайлан, судалгаа, мэдэгдэл; бага хурал, төлөвлөгөө, хөтөлбөр; хэдэн арван жилийн үйл ажиллагаа; судалгаа, сургалтаар; сайн дурын болон итгэлцлийн сан; дэлхийн, бүс нутгийн болон орон нутгийн түвшинд олон төрлийн тусламж; авч хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээ; мөрдөн шалгах үйл ажиллагаа; мөн хүний эрхийг хангах, хамгаалах зорилгоор боловсруулсан олон тооны процедураар хэрэгжүүлэг.

Хүний эрхийн соёлыг төлөвшүүлэх үйл ажиллагааг НҮБ-ын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллага (ЮНЕСКО), НҮБ-ын Хүүхдийн сан (ЮНИСЕФ), НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Олон улсын хөдөлмөрийн байгууллага зэрэг НҮБ-ын төрөлжсөн байгууллага, хөтөлбөр, сангууд, түүнчлэн Хүний эрхийн дээд



комиссарын газар (ХЭДКГ) зэрэг НҮБ-ын Нарийн бичгийн дарга нарын газрын байгууллагууд дэмжиж байна. Түүнчлэн төрийн болон төрийн бусбусад олон улсын, бүс нутгийн болон үндэсний байгууллагууд хүний эрхийг хангах чиглэлээр ажиллаж байна.

1993 онд Австри улсын Вена хотод зохион байгуулагдсан Хүний эрхийн дэлхийн бага хурлаар дэлхийн 171 улс хүний эрхийн түгээмэл, салшгүй, харилцан хамааралтай байдлыг дахин баталгаажуулж, Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалыг тууштай баримтлахаа дахин нотолсон. Улмаар тэд хүний эрхийг хангах нэгдмэл хандлагыг бий болгохыг дэмжих, орон нутаг, үндэсний болон олон улсын түвшинд оролцогчдыг татан оролцуулах зорилгоор “Төлөвлөлт, Яриа хэлэлцээ, Хамтын ажиллагааны хүрээ”-г шинээр бүрдүүлж Венийн Тунхаглал, Үйл ажиллагааны Хөтөлбөрийг баталсан.

НҮБ-ын Хүний эрхийн боловсролын арван (1995–2004)

Хүний эрхийг хангах үйл ажиллагааны чухал бүрэлдэхүүн хэсэг нь хүний эрхийн боловсрол юм. Түгээмэл тунхаглал батлагдсанаас хойш Ерөнхий Ассамблей нь гишүүн улс орнууд болон нийгмийн бүхий л бүлгүүдэд хандан энэхүү үндсэн баримт бичгийг түгээн дэлгэрүүлж, түүний агуулгыг хүмүүст таниулан суралцуулахад уриалсан. Мөн 1993 онд зохион байгуулагдсан Хүний эрхийн Дэлхийн чуулганаар боловсрол, сургалт, олон нийтийн мэдээллийн чухлыг дахин баталгаажуулсан.

Дэлхийн чуулганаас гаргасан уриалгын дагуу 1994 онд Ерөнхий Ассамблей 1995-2004 оныг НҮБ-ын Хүний эрхийн боловсролын арван болгон зарласан. Ассамблей “Хүний эрхийн боловсрол нь мэдээллээр хангахаас илүү өргөн агуулгатай бөгөөд хөгжлийн бүх түвшинд, нийгмийн бүхий л давхаргын хүмүүст бусдын нэр төрийг хүндэтгэх, бүхий л нийгэмд энэхүү хүндлэлийг хангах арга хэрэгсэл, арга хэлбэрт суралцах насан туршийн цогц үйл явц байх ёстой” хэмээн баталгаажуулсан.

Арван жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд олон улсын хамтын нийгэмлэгийн зөвшилцсөн хүний эрхийн боловсролын үзэл баримтлалын тодорхойлолтыг хүний эрхийн олон улсын баримт бичгийн заалтуудад үндэслэн тодорхойлсон.⁶ Эдгээр заалтын дагуу хүний эрхийн боловсрол гэдгийг “дараах мэдлэг, ур чадвар олгох замаар хүний эрхийн нийтлэг соёлыг бий болгоход чиглэсэн сургалт, түгээн дэлгэрүүлэх, мэдээллийн хүчин чармайлт хэмээн тодорхойлж болно. Үүнд:

- (a) Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүндэтгэх явдлыг бэхжүүлэх;
- (b) Хүний хувийн шинж эрхэм чанарын, утга учрыг бүрэн хөгжүүлэх;
- (c) Бүх үндэстэн, уугуул ард түмэн, арьс үндэс, үндэстэн, угсаатны, шашин шүтлэг, хэлний бүлгүүдийн хоорондын ойлголцол, хүлцэл, жендэрийн тэгш байдал, нөхөрлөлийг дэмжих;
- (d) чөлөөт нийгэмд үр дүнтэй оролцох боломжийг бүх хүнд олгох;
- (e) энх тайвныг сахиулах НҮБ-ын үйл ажиллагааг ахиулах багтана.”⁷

⁶ Including the Universal Declaration of Human Rights (art. 26.2), the International Covenant on Economic, Social and Cultural Rights (art. 13.1), the Convention on the Rights of the Child (art. 29.1) and the Vienna Declaration and Programme of Action (sect. D, paras. 78-82).

⁷ See United Nations document A/51/506/Add.1, appendix, para. 2 – available at <http://www.ohchr.org> or by contacting the Office of the United Nations High Commissioner for Human Rights.

Арван жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө нь хэрэгцээ шаардлагыг үнэлэх, үр дүнтэй стратеги боловсруулах; олон улсын, бүс нутгийн, үндэсний болон орон нутгийн түвшинд хөтөлбөр, чадавхыг бий болгох, бэхжүүлэх; материалыг уялдуулан хөгжүүлэх; олон нийтийн мэдээллийн хэрэгслийн үүргийг бэхжүүлэх; Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалыг дэлхий нийтэд түгээн дэлгэрүүлэх замаар хүний эрхийн боловсролыг дээшлүүлэх стратегийг тусгасан.

Сургууль дахь хүний эрхийн боловсролын үйл явц

Хүний эрхийн боловсролыг боловсролын тогтолцоонд нэвтрүүлэх тогтвортой (урт хугацаанд), иж бүрэн, үр дүнтэй үндэсний стратеги нь дараах олон төрлийн үйл ажиллагааны чиглэлийг агуулж болно.

- Сургуулиудын боловсролын харилцааг зохицуулах үндэсний хууль тогтоомжид хүний эрхийн боловсролыг тусгах;
- Хичээлийн хөтөлбөр, сурах бичгийг шинэчлэх;
- Хүний эрх, хүний эрхийн боловсролын арга зүйн талаарх сургалтыг багтаасан багш нарт зориулсан сургалт багш бэлтгэх болон мэргэжил дээшлүүлэх сургалт;
- Сургууль болон гэр бүл, олон нийтэд үндэслэсэн хичээлээс гадуурх үйл ажиллагаа;
- Боловсролын материал боловсруулах;
- Багш нар болон бусад мэргэжилтнүүдийг (хүний эрхийн бүлгүүд, багш нарын холбоо, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод) дэмжих сүлжээг бий болгох.

Эдгээр үйл явцыг улс орнуудад хэрэгжүүлэх тодорхой арга зам нь орон нутгийн боловсролын тогтолцоо, тэр дундаа багш нар өөрсдийн заах зорилгоо хэрхэн тодорхойлж, түүндээ хэрхэн хүрэх үйл ажиллагааны эрх чөлөөнөөс ихээхэн хамаарна. Багш нар үйл ажиллагаандаа үргэлж шинийг санаачлагч гол хүмүүс байсаар ирсэн. Тиймээс тэд хүний эрхийн талаарх ойлголтын харилцаанд томоохон үүрэг гүйцэтгэдэг. Харин үүнийг хэрхэн хийх боломжууд нь янз бүр байж болно. Тухайлбал, хүний эрхийн сэдвүүдийг түүх, иргэншил, уран зохиол, урлаг, газарзүй, хэл, шинжлэх ухааны хичээл гэх мэт сургуулиудын одоо байгаа хичээлүүдийн агуулгад суулгах, эсвэл хүний эрхийн тусгай хичээлтэй байж болохын зэрэгцээ хүний эрхийн боловсролыг сургуулиас гадуурх үйл ажиллагаа, клуб, залуучуудын бүлэг зэрэг сургууль доторх болон гаднах албан бус боловсролын талбаруудаар дамжуулан олгож болно.

Хүүхдэд хүний эрхийн ойлголтыг алхам алхмаар таниулах хандлага

Түвшин	Зорилго	Үндсэн ойлголт	Практик	Хүний эрхийн тухайлсан асуудлууд	Хүний эрхийн хэм хэмжээ, тогтолцоо, баримт бичгүүд
Балчир нас					
Сургуулийн өмнөх болон бага анги 3-7 нас	Өөрийгөө хүндэтгэх Эцэг эх, багш нарыг хүндэтгэх Бусдыг хүндэтгэх	Өөрөө Нийгмийн бүлэг Хувийн үүрэг хариуцлага Үүрэг	Шударга байдал Өөрийгөө илэрхийлэх/сонсох Хамтран ажиллах/хуваалцах Жижиг бүлгийн ажил Дангаар хийх ажил Шалтгаан, үр дагаврыг ойлгох Бусдыг өрөвдөх Ардчилал Зөрчилдөөнийг шийдвэрлэх	Арьс үндсээр ялгаварлах үзэл Хүйсээр алагчлах, ялгаварлан гадуурхах Шударга бус байдал Бусдыг өвтгөх (сэтгэл зүй болон биеийн)	Ангийн дүрэм Гэр бүлийн харилцаа Нийгмийн хэм хэмжээ Хүний эрхийн түгээмэл тунхаглал Хүүхдийн эрхийн тухай конвенц
Бага нас	Дээрх бүгд дээр нэмээд:				
Ахлах бага анги 8-11 нас	Нийгмийн хариуцлага Иргэн Хүслийг хэрэгцээ болон эрхээс ялгаж ойлгох нь	Хувь хүний эрх Бүлгийн эрх Эрх чөлөө Тэгш байдал Шударга ёс Хууль дээдлэх ёс Төр Аюулгүй байдал	Олон янз байдлын үнэ цэнэ Шударга ёс Бодит факт болон бодол санааг ялгах нь Сургууль болон нийгмийн үйлчилгээг хэрэгжүүлэх Иргэний оролцоо	Ялгаварлан гадуурхалт/алагчлал Ядуурал/өлсгөлөн Шударга бус байдал Үндэстнээ голчлох үзэл Эго төвт үзэл буюу Би-гийн үзэл Идэвхгүй байдлаар хүлээн зөвшөөрөх	Хүний эрхийн түүх Орон нутгийн, үндэсний эрх зүйн систем Орон нутгийн болон үндэсний түүх хүний эрхийн агуулгаар ЮНЕСКО, ЮНИСЕФ Төрийн бус байгууллага
Өсвөр нас	Дээрх бүгд дээр нэмээд:				
Бага дунд анги 12-14 нас	Тухайлсан хүний эрхийн мэдлэг	Олон улсын эрх зүй Дэлхийн энх тайван Дэлхийн хөгжил Дэлхийн улс төрийн эдийн засаг Дэлхийн экологи	Үзэл хандлагын бусад ойлголтууд Үзэл санаагаа дэмжих эх сурвалжийг эшлэх Судалгаа хийх/мэдээлэл цуглуулах Мэдээллийн түгээх	Үгүйсгэх Үл тоомсорлох Цинизм Улс төрийн дарангуйлал Колончлол/империализм Эдийн засгийн даяарчлал Байгаль орчны доройтол	НҮБ-ын Пактууд Арьс үндсээр ялгаварлах үзлийг устгах Хүйсээр ялгаварлах үзлийг устгах НҮБ-ын дүрвэгсдийн асуудал эрхэлсэн комиссар Бүс нутгийн хүний эрхийн конвенц
Залуучууд	Дээрх бүгд дээр нэмээд:				
Анхлан анги 15-17 нас	Хүний эрхийн түгээмэл стандартын талаарх мэдлэг Хүний эрхийг хувь хүний ухамсар, зан үйлд нэгтгэх	Ёс суртахууны оролцоо/хасалт	Иргэний нийгмийн байгууллагын оролцоо Иргэний үүргээ биелүүлэх Иргэний үл захирагдахуй	Төрлөөр утгах Эрүү шүүлт Дайны гэмт хэрэг гэх мэт	Женевийн конвенц Тухайлсан конвенц Хүний эрхийг стандартыг хөгжүүлэх


Болж өгвөл хүний эрхийн соёлыг иж бүрэн сургалтын хөтөлбөрт тусгах шаардлагатай (гэхдээ практикт, ялангуяа дунд боловсролын түвшинд нийгэм, эдийн засаг, хүмүүнлэгийн шинжлэх ухааны сургалтын хөтөлбөрийн нэг хэсэг болгон ихэвчлэн авч үздэг).

Сургалтын анги танхимд хүний эрхийн зарчмуудыг хүүхдүүдэд утга учиртай, сонирхолтой таниулахын тулд хүний эрхийн боловсролыг хүүхдийн хөгжлийн үе шат, нийгэм, соёлын нөхцөл байдлыг зохих ёсоор анхаарч хөгжүүлэх хэрэгтэй. Тухайлбал, балчир насны хүүхдүүдэд хүний эрхийн боловсрол олгох нь өөртөө итгэх, өрөвдөх нинжин сэтгэлийг хөгжүүлэх, хүний эрхийн зарчмуудыг дэмжсэн сургуулийн соёлыг чухалчилж болох юм. Хэдийгээр бага насны хүүхдүүд хүний эрхийн суурь баримт бичгийн үндсэн зарчмуудыг ойлгох чадвартай ч хүний эрхийн баримт бичгийн илүү нарийн агуулга нь үзэл баримтлалыг хөгжүүлэх, дүн шинжилгээ хийх чадвар сайтай ахлан ангийн хүүхдүүдэд илүү тохиромжтой байж болох юм. Дараах хүснэгтэд хүүхдийн наснаас хамааран хүний эрхийн тухай ойлголтыг аажмаар нэвтрүүлэх санал болгож буй матрицыг тусгасан болно. Энэ нь зааварчилгаа биш бөгөөд харин 1997 онд Женевт цугларсан хүний эрхийн боловсролын мэргэжилтнүүд боловсруулж, хэлэлцсэн асуудлыг жишээ болгох харуулах зорилготой юм.

Хүний эрхийн боловсролын агуулга

Хүний эрхийн түүх нь хүний нэр төр, үнэ цэн, тэдгээрийн хамгийн суурь эрхийг тодорхойлох хүчин чармайлтын талаарх дэлгэрэнгүй түүхийг өгүүлдэг. Энэхүү хүчин чармайлт өнөөг хүртэл үргэлжилсээр байна. Хэрэв багш нар энэхүү түүхийг хүний эрхийн сургалтын чухал хэсэг болгон оруулахыг хүсэх аваас энэ нь суралцагчдыг өсөж төлөвших тусам аажмаар цогц болгон хөгжих болно. Иргэний болон улс төрийн эрхийн төлөөх тэмцэл, боолчлолыг устгах кампанит ажил, эдийн засаг, нийгмийн шударга ёсны төлөөх тэмцэл, Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал болон хүний эрхийн үндсэн хоёр Пактын хэрэгжилт, тэдгээрийг дагаж гарсан бүх конвенц, тунхаглал, ялангуяа Хүүхдийн эрхийн тухай конвенц зэрэг сэдвүүд нь хууль эрх зүйн болон норматив ойлголтын үндсэн суурийг бүрдүүлдэг.

Сургууль дахь хүний эрхийн боловсролын үндсэн агуулга нь Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, Хүүхдийн эрхийн тухай конвенц юм. Дээр дурдсанчлан түгээмэл байдлаар хүлээн зөвшөөрөгдсөн эдгээр баримт бичиг нь хүний эрхийг дээдэлсэн сургуулиудын соёлыг төлөвшүүлэх, туршлагыг үнэлэх зарчим, үзэл санааг агуулдаг. Тэдгээрт хамгаалагдсан эрхүүд нь түгээмэл шинж чанартай бөгөөд



энэ нь бүх хүн эрх тэгш байдлаар эдлэх эрхтэй гэсэн үг юм; Эдгээр нь хуваагдашгүй, эрхийн шатлалгүй, өөрөөр хэлбэл ямар ч эрхийг нэг нь нөгөөгөөсөө «чухал биш» эсвэл «чухал» гэж ангилж болохгүй. Харин хүний эрх нь бие биенээсээ хамааралтай, харилцан бие биенээ нөхдөг хэмээн үзэх хэрэгтэй. Тухайлбал, төрийн үйл хэрэгт оролцох эрх нь үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, сурч боловсрох, цаашлаад амьдралын хэрэгцээг хангах эрхтэй шууд хамааралтай. Хүний эрх бүр зайлшгүй шаардлагатай бөгөөд харилцан хамааралтай байдаг.

Гэхдээ хамгийн чадварлаг, няхуур байдлаар хичээлийг заасан ч гэсэн хүний эрхийн баримт бичгүүд, хүний эрхийн түүх нь дангаараа хүний эрхийг сургуулийн анги танхимд ойлгомжтой үр дүнтэй амьдруулахад хангалттай байж чадахгүй. Түгээмэл Тунхаглал эсвэл Хүүхдийн эрхийн тухай конвенцын зүйл заалт нэг бүрийн үндэслэлийг зааж өгөх нь хүмүүсийн амьдралд эдгээр зүйлийн утга учрыг ойлгуулж буй хэрэг огтхон ч биш. Хүний эрхийн соёлыг төлөвшүүлэхэд “бодит үйл баримт”, “үндэс суурь”, тэр ч байтугай сонгон авсан хамгийн шилдэг нь ч хангалтгүй. Эдгээр баримт бичиг нь оюун санааны ач холбогдолтой байхын тулд суралцагчид өөрсдийн бодит амьдралын туршлагаасаа хандаж, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдлын талаарх өөрсдийн ойлголтын үүднээс тэдэнтэй бодитоор холбогдох нь чухал юм.

Хүний эрхийн төлөө хүний эрхийг заах нь

Судалгаанаас харахад ахлах болон дунд сургуулийн зарим суралцагч заримдаа өөртөө итгэлгүй байдлаас болж нийгэм буюу бусадтай харилцах чадвараа хязгаарладаг. Өөрийнхөө эрхийг мэдэхгүйгээр бусдын эрхийн төлөө санаа тавих нь хэцүү байдаг. Ийм тохиолдолд энэхүү товхимлын хоёрдугаар бүлэгт тусгасан эхний суурь агуулга болох өөртөө итгэх итгэл, хүлээцтэй байдлын талаар зааж сургах шаардлагатай. Хоёрдугаар бүлэгт байгаа Итгэлцлийн дасгалуудыг ямар ч бүлгийн суралцагчдад ашиглаж болох бөгөөд эдгээр нь хүний эрхийн боловсролд чухал ач холбогдолтой ангийн уур амьсгалыг бий болгоход тусалдаг. Суралцагчдыг бүлгээр ажиллуулахыг шаарддаг үйл ажиллагаанд хамруулахын тулд эдгээр үйл ажиллагааг дахин давтан хийж (тохиромжтой хувилбараар) болно. Тэдгээр нь хүний эмзэг, тохиолдлын бөгөөд өөрийгөө бусдын байр сууринд тавих буюу өрөвдөх сэтгэлийг дэмжиж, хэн ч бусдаас илүү биш, хэн ч дутуу байдаггүй гэдгийг батлахад тусална.

Дан ганц хүний эрхийн тухай зааж сургах нь хангалтгүй гэдгийг ойлгуулах нь энэхүү товхимлын гол утга санаа юм. Багш нар хүний эрхийн төлөө зааж сургах үйл ажиллагааг эхлүүлж болно, гэхдээ үүнд эцэс төгсгөл гэж үгүй. Иймээс энэхүү товхимлын бичвэрийн ихэнх хэсэг нь үйл ажиллагаанаас бүрдэнэ.



Эдгээр нь суралцагчид болон багш нарт эхлээд хүний эрхийг бүрдүүлдэг үндсэн элементүүд болох амьдрал, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал болон хохирол (эрхийг хасах), зовлон зүдгүүр, өвдөлт зэрэг хор хөнөөлтэй шинж чанарын талаар судалж, дараа нь бодит ертөнцийн өргөн хүрээний асуудлын талаар эргэцүүлэн бодож, мэдэрч буй зүйлээ боловсруулахад ашиглах боломжийг бий болгоно.

Хүний эрхийн боловсролын гол төвлөрөх асуудал нь зөвхөн юмсын гаднах асуудал, тэдгээрийн ил харагдах гадаад илрэл төдийгүй хувийн үнэт зүйлс, хандлага, зан байдал зэрэг дотоод асуудалд чиглэнэ. Хүний эрхийн боловсрол нь зан үйлд нөлөөлж, хүний эрхийн төлөө хариуцлага хүлээх мэдрэмжийг бий болгохын тулд бие даасан судалгаа, дүн шинжилгээ, шүүмжлэлт сэтгэлгээг чухалчилдаг оролцооны арга зүйг ашигладаг.

Эрх, хариуцлага

Хүний эрхийн соёлын үндсэн зарчмууд оршин тогтнохын тулд, Үхмүүс тэдгээрийг хамгаалахын тулд “Би үүнийг хийх эрхтэй. Энэ бол зөвхөн миний хүсэж байгаа эсхүл хэрэгтэй зүйл биш. Энэ бол миний эрх. Үүний төлөө хариуцлагатай байх ёстой” хэмээн үздэг байх нь чухал юм. Гэхдээ эрхийг хамгаалах шалтгаан, үндэслэл байсан цагт л эрх оршин тогтнож байдаг бөгөөд эдгээр нь зөв зүйтэй байх ёстой. Хүмүүс эдгээр шалтгаан, үндэслэлийг ухаараагүй бол эрхийг зөрчиж, хангахгүй байгаа нөхцөлд өөрийн эрхийг хамгаалахгүй, түүнчлэн бусдын эрхийг хамгаалах үүрэгтэй гэдгээ ч ухамсарлах боломжгүй болно. Эрхийг хамгаалах энэ үндэслэл, шалтгааныг олж авах газар бол сургууль юм. Эрх яагаад ийм чухал байдаг учир шалтгааныг эрэн хайх нь эргээд хариуцлагын тухай ойлголтыг төлөвшүүлдэг.

Хүний эрхийн боловсролыг хүний үүрэг, хариуцлагын талаар эхлэн зааж болно. Гэхдээ багш нар суралцагчдад эхлээд үүрэг, хариуцлагын талаар ярихыг илүүд үзэхгүй байх.. Хүний эрхийг амьдралд бодитой буулгах нь суралцагчдад нийгмийн үүрэг хариуцлагыг жинхэнэ утгаар нь ойлгож, хүлээн зөвшөөрөх боломжийг бий болгоно. Дараа нь багш болон суралцагчид үүрэг, хариуцлага, эрхийн талаарх зайлшгүй зөрчилдөөнийг шийдвэрлэхэд шаардагдах зарчим, ур чадварыг эзэмшинэ.

Зөрчилдөөнийг шийдвэрлэх нь суралцагч нарт сургамж, ойлголт өгч болох тул эдгээр асуудлыг таатай хүлээн авах хэрэгтэй. Улмаар хүний эрхийг зааж сургах үйл явцыг илүү амьд, ач холбогдолтой болгодог. Зөрчилдөөн нь суралцагчдыг эсрэг тэсрэг байдлыг бүтээлчээр, айдасгүйгээр даван туулж, тэдгээрийг шийдвэрлэх өөрсдийн арга замыг эрэлхийлэхэд суралцах боломж олгодог.

Сургахуй, заахуй: үйлдэл үгнээс илүү хүчтэй

Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, Хүүхдийн эрхийн тухай конвенц нь дэлхийн хэмжээнд хүчин төгөлдөр үйлчилж, хэрэгжих боломжтой байгаа нь багш нарт ихээхэн чухал юм. Энэ утгаараа багш хоосон номлогч бус хүний эрхийн түгээмэл хэм хэмжээг хөхиүлэн дэмжигч юм. Гэхдээ багш нар анги танхим болон сургуулийн орчинд хүний эрхийг хэрхэн хангах талаар заах дараагийн сорилттой тулгардаг. Сургалтын практик үр шимийг гаргахын тулд суралцагчид зөвхөн хүний эрхийн талаар суралцахаас гадна тэдгээрийг загварчлах орчинд суралцах хэрэгтэй.

Энэ нь хоёр нүүр , хуурмаг дүр гаргахаас зайлсхийнэ гэсэн үг. Хамгийн энгийнээр хэлбэл, хоёр нүүр буюу хуурмаг дүр гаргах гэдэг нь багшийн зааж байгаа зүйл нь түүний зааж буй арга барилтай илт зөрчилдөх нөхцөл байдлыг ойлгоно. Тухайлбал: “Өнөөдөр бид үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний тухай ярих болно гэснээ арын эгнээнийхэн чимээгүй бай!”... Ийм нөхцөлд суралцагчид ихэвчлэн эрх мэдлийн талаар голчлон суралцаж, хүний эрхийн талаар хангалттай ойлголтгүй хоцроно. Суралцагчид ихэнх цагаа багшаасаа суралцахад зарцуулж, багш нарын итгэл үнэмшлээс ойлголт авдаг учир шударга бус, хүчирхийлэгч багш нар суралцагч нарт эерэг нөлөө үзүүлэхгүй. Ихэнхдээ суралцагчид багшид таалагдахын тулд өөрсдөө ч бодохгүйгээр багшийн хувийн үзэл бодлыг дуурайх гэж оролддог. Энэ нь багш нар ядаж л өөрсдийн санаа бодлоо илэрхийлэхгүй байх шалтгаан байж болох юм. Том зургаар нь авч үзвэл дүр эсгэх тухай ойлголт нь анги танхим, сургууль, нийгэмд багш, сурагчдын нэр төрийг хэрхэн хамгаалах, хангах талаарх гүн гүзгий ойлголтыг хөнддөг.

Сургууль, анги танхим дахь “хүний эрхийн уур амьсгал” нь оролцогч бүх талуудын харилцан хүндлэлд үндэслэх ёстой. Тиймээс шийдвэр гаргах үйл явцын хэлбэр, зөрчилдөөнийг шийдвэрлэх арга замууд, сахилга батыг тогтоох арга барил, талууд хоорондын дотоод болон хоорондын харилцаа зэрэг нь энэ уур амьсгалыг бүрдүүлэх гол нөлөөлөгч хүчин зүйл болдог.

Багш нар хүний эрхийн боловсролд зөвхөн суралцагч, сургуулийн удирдлага, боловсролын байгууллага, эцэг эхчүүдийг оролцуулаад зогсохгүй олон нийтийг хамруулах арга замыг судлах шаардлагатай. Ингэснээр хүний эрхийн төлөө сургах үйл ажиллагаа нь анги танхимаас нийгэмд хүрч, аль алинд нь үр өгөөжөө өгөх болно. Холбогдох бүх талууд түгээмэл үнэт зүйлс, тэдгээрийг бодит байдалтай хэрхэн уялдаа холбоог хангах талаар хэлэлцэж, сургууль нь хүний эрхийн үндсэн асуудлыг шийдвэрлэх нэг хэсэг болж чадна гэдгийг хүлээн зөвшөөрөх боломжтой болно.

Суралцагчдын хувьд ангийн дүрэм, хариуцлагын талаар хэлэлцэн тохиролцох нь удаан хугацааны турш практикт шалгагдсан хамгийн үр дүнтэй арга зам юм (Хоёрдугаар бүлгийн Ангийн дүрмийг бий болгох хэсгийг үзнэ үү). Хүний үндсэн эрхэд нийцсэн заах арга барил нь тууштай, үлгэр жишээ загвар болдог. Ийм байдлаар, биеийн тамирын болон математикийн багш нар ч хичээлээрээ дамжуулан хүний эрхийг зааж болно.





Хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх нь

Суралцагчид хүний эрхийг судалж эхлэхэд зарим тохиолдолд маргаантай, эмзэг сэдвүүд гарч болно. Иймд багш нар суралцагчдын таагүй байдал, санал зөрөлдөөндбайнга сэрэмжтэй хандах хэрэгтэй. Хүний эрх нь үнэт зүйлсийн зөрчилдөөнтэй холбоотой бөгөөд суралцагчид эдгээр зөрчлийг ойлгож, шийдвэрлэхийг эрэлхийлэх замаар үр шимийг хүртэх болно гэдгийг багш нар хүлээн зөвшөөрөх шаардлагатай.

Заримдаа багш нар хүний эрхийн боловсролыг нутгийн ёс заншил, үнэт зүйлст нийцэхгүй, түүнд халдах харь зарчмууд гэх эсэргүүцэлтэй тулгардаг. Удирдлагуудын зүгээс ирэх энэ төрлийн эсэргүүцэлд санаа зовж буй багш нар тэдэнтэй урьдчилан уулзаж, ангийн зорилго, төлөвлөгөөний талаар мэдээлж, НҮБ-ын хүний эрхийн тогтолцоо, холбогдох боловсролын санаачилгын талаар (НҮБ-ын Хүний эрхийн боловсролын арван жил гэх мэт) тайлбарлах хэрэгтэй. Удирдлагуудыг өөрийн зааж буй хичээлд зочлохыг уриалаарай - Тэд ч бас хүний эрхийн боловсролын үр шимийг хүртэж магадгүй!

Хүний эрхийн боловсролын заах арга зүй

Хоёр болон гуравдугаар бүлэгт санал болгож буй дор дурдсан арга техникүүд, тэдгээрийг сургалтын үйл ажиллагаанд ашигласнаар суралцагчид бусдын байр сууринд өөрийгөө тавих буюу өрөвдөх нинжин сэтгэл, ёс суртахууны төсөөллийг мэдрэх, өөрсдийн таамаглалыг сорих, хүний нэр төр, эрх тэгш байдал гэх мэт ойлголтуудыг хүмүүс, эрх мэдэл, үүрэг хариуцлагын талаарх өдөр тутмын туршлагадаа нэгтгэх аргазүйд суралцахболно. Эдгээр арга техник нь тунгаан бодох /шүүмжлэлт/ сэтгэлгээ, танин мэдэхүйн болон нөлөөллийн аль алинд нь суралцах, туршлага болон үзэл бодлын ялгаатай байдлыг хүндэтгэх, бүх оролцогчдыг тасралтгүй суралцахад идэвхтэй оролцуулахыг дэмждэг утгаараа хүний эрхийн боловсролд онцгой ач холбогдолтой болох нь нотлогдсон.

А Оюун бодлоо уралдуулах

Энэ аргыг онолын болон практик асуудлын шийдлийг эрэлхийлэхэд ашиглаж болно. Энэ нь асуудалд дүн шинжилгээ хийж, дараа нь шийдлийг боловсруулахыг шаарддаг. Оюун бодлоо уралдуулах нь идэвхитэй оролцоо, оролцож буй хүмүүсийг бүтээлч сэтгэлгээг дээд зэргээр дэмждэг.

Асуудлыг танилцуулсны дараа өгөгдсөн санаа болон хариултуудыг самбар эсвэл хүснэгт бүхий цаасан дээр тэмдэглэнэ. Бүх хариултыг тэмдэглэнэ; Энэ үе шатанд ямар нэгэн тайлбар хийх шаардлагагүй бөгөөд саналыг шүүмжилж, эсхүл үгүйсгэхгүй. Дараа нь багш хариултуудыг ангилж, дүн шинжилгээ хийх бөгөөд заримыг нэгтгэх, хялбар болгон засварлах, татгалзах буюу үгүйсгэх зэргээр үргэлжлүүлнэ. Эцэст нь бүлэг асуудлын талаар зөвлөмж гаргаж, шийдвэр гаргадаг.

Жишээ нь: “Шилэн саван дахь зурвас” (32 дахь тал); “Шархлуулах үгс” (41 дэх тал); “Зарим “цөөнхийн бүлгүүдийг” тодорхойлох нь” (47 дахь тал); “Орон байр” (55 дэх тал); “Эрчим хүч” (57 дахь тал).

В Тохиолдол шинжлэх

Суралцагчдыг хүний эрхийн хэм хэмжээг хэрэгжүүлэхийг шаарддаг бодит эсвэл зохиомол тохиолдолд дээр жижиг бүлгээр ажиллуулна. Тохиолдол шинжлэх дасгал нь хоёр, гурван үндсэн асуудалд анхаарал хандуулсан, найдвартай, бодит хувилбарууд дээр суурилсан байх шаардлагатай. Дүн шинжилгээ хийх тохиолдлуудыг суралцагчдад бүхэлд нь танилцуулах эсхүл тэдэнд хариулт өгөхөд шаардлагатай өгөгдлийг ар араас нь дэс дараалуулан танилцуулж болно. Энэ арга

нь дүн шинжилгээ хийх, асуудлыг шийдвэрлэх, төлөвлөх ур чадвар, түүнчлэн хамтын ажиллагаа, багаар ажиллах чадварыг дэмждэг. Тохиолдол шинжлэх аргыг мэтгэлцээн, хэлэлцүүлэг эсвэл цаашид хийх судалгаанд ашиглаж болно.

Жишээ нь: “Сэтгүүлч алга боллоо!” (32 дахь); “Цүнхээ багла” (34 дэх тал); “Хангалттай нас” гэж хэдэн насыг хэлэх вэ?” (42 дахь тал).

С Бүтээлч илэрхийлэл

Урлаг нь хүний эрхийн талаарх сэтгэл хөдлөл, оюуны хариу үйлдлийг нэгтгэснээр ойлголтыг илүү тодорхой болгох, хийсвэрлэлийг хувийн болгох, хандлагад нөлөөлөхөд тусалдаг. Энэхүү аргад өгүүллэг, яруу найраг, графит, уран баримал, жүжиг, дуу, бүжиг зэргийг хамруулж болно. Багш нар өөрсдөө уран бүтээлч байх шаардлагагүй, харин сонирхол татахуйц даалгавар өгч, суралцагчдад өөрсдийн бүтээлээ хуваалцах арга замыг бий болгоно.

Жишээ нь: ““Би хэн бэ?” ном” (21 дэх тал); “Амьдралын шугам” (22 дахь тал); “Би хана/газар дээр” (22 дахь тал); “Захидал ба найз нөхөд” (23 дахь тал); “Хүсэл ба хэрэгцээ” (28 дахь); “Хүүхдэд юу хэрэгтэй вэ?” (28 дахь тал); “Хүүхдийн эрхийг дэмжих нь” (29 дэх тал); “Тэд бүгд адилхан” (45 дахь).

D Хэлэлцүүлэг

Багаар, жижиг бүлгээр эсхүл анги нийтээр нь утга учиртай хэлэлцүүлгийг өдөөх олон арга техник байдаг. Итгэлцэл, хүндлэлийн орчныг бүрдүүлэхийн тулд суралцагчид өөрсдийн “хэлэлцүүлгийн дүрэм”-ийг боловсруулж болно.

Хэлэлцүүлгийг янз бүрийн үр дүнтэй аргаар зохион байгуулж болно. Зарим сэдвүүд нь албан ёсны мэтгэлцээн, панел хэлэлцүүлэг эсвэл “Загасны шилэн аквариум” форматад тохиромжтой (өөрөөр хэлбэл жижиг бүлгүүд ярилцаж харин ангийн бусад гишүүд сонсож, дараа нь тайлбар хийж, асуулт асууна). Бусад сэдэв нь “Ярилцах тойрог”-д илүү тохиромжтой (өөрөөр хэлбэл суралцагчид хоёр тойрог болон сууж, нэг нь гадагшаа, нөгөө нь дотогшоо харна. Тэд эсрэг талд сууж буй хүнтэй ярилцдаг; хэсэг хугацааны дараа багш тойрог дотор байгаа хүн бүрийг баруун тийш шилжүүлж, шинэ хүнтэй нэг сэдвийг ярилцахыг хүсдэг). Хувийн болон сэтгэл хөдлөлийн сэдвүүдийг хосоор эсвэл жижиг бүлгээрээ ярилцах нь илүү дээр байдаг.

Ангийг бүхэлд нь тухайн сэдэвт татан оролцуулахын тулд багш “Ярилцах” гэх мэт арга техникийг ашиглаж болно (өөрөөр хэлбэл багш “Нэр төр таны хувьд юу гэсэн үг вэ?” эсвэл “Би аз жаргалтай байх үед ...” гэх мэт нээлттэй асуулт асууж, суралцагч бүр ээлжлэн хариулдаг).

“Хэлэлцүүлгийн сүлжээ” бол хэлэлцүүлгийг графикаар дүрслэх хөгжөөнт арга юм. Суралцагчид хэлэлцүүлгийн тойрогт сууж, нэг нэгээрээ ярина. Ингэхдээ тэд нэхмэлийн бөмбөлөг утсыг дамжуулах бөгөөд ийнхүү дамжуулахдаа утсыг хөврүүлнэ. Хүн бүр утаснаас барьж үлдэнэ. Эцэст нь бүгд утсаар холбогдож, түүний дотор өрнөж буй харилцааны хэв маягийг харж болно.

Жишээ нь: “Ярилцах тойрог” (21 дэх тал); “Би ба миний мэдрэхүй” (22 дахь тал); “Хүслийн тойрог” (22 дахь тал); “Шинэ улс орны төлөвлөлт” (26 дахь тал); “Хүн байх нь” (31 дэх тал); “Эхлэл ба төгсгөл” (32 дахь тал); “Хуулийн өмнө эрх тэгш байх” (38 дахь тал); “Эрхээ мэдэх эрх” (53 дахь тал).

Е Хээрийн аялал/Танилцах аялал

Суралцагчид сургуулийн орчныг нийгмийн бусад орчноор өргөжүүлэх, хүний эрхийн асуудал үүсдэг газрууд (жишээ нь шүүх, хорих газар, олон улсын хил) эсвэл хүмүүсийн эрхийг хамгаалах эсвэл хохирогчдод дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажилладаг (жишээлбэл, төрийн бус байгууллага, хоол хүнс, хувцасны хандивын төв, үнэ төлбөргүй эмнэлэг) байгууллагуудад очиж, үйл ажиллагаатай нь танилцаж суралцдаг.

Ийнхүү зочлох зорилгыг урьдчилан тайлбарлаж, суралцагчдад тунгаан бодож анхаарлаа хандуулан байгууллагуудад зочилсны дараах хэлэлцүүлэгт зориулж ажиглалтаа тэмдэглэх, эсвэл эргэцүүлэл бичүүлэх хэрэгтэй.

Жишээ нь: “Зөвлөл ба шүүх” (36 дахь тал); “Манай сургуульд хэн байхгүй вэ?” (51 дэх тал); “Хоол хүнс” (54 дэх тал); “Эрүүл мэнд” (57 дахь тал).

Г Ярилцлага

Ярилцлага нь шууд суралцах боломж олгож, асуудал болон түүхийг хувь хүний түвшинд ойлгуулахад тохиромжтой арга юм. Ярилцлагад оролцогчид нь гэр бүл, нийгмийн бүлгийн гишүүн, идэвхтэн, удирдагч эсвэл хүний эрхийн үйл явдлын гэрч байж болно. Ийм төрлийн аман түүхүүд нь тухайн бүлэгт тулгардаг хүний эрхийн асуудлыг баримтжуулж, ойлгоход тусална.

Жишээ нь: “Зөвлөл ба шүүх” (36 дахь тал); “Эрт нэгэн цагт” (44 дэх тал); “Хөгжлийн бэрхшээлийн асуудлаар илтгэгч” (51 дэх тал); “Бизнесийн хүрээнийхний илтгэгчид” (60 дахь тал).

G Судалгааны төсөл

Хүний эрхийн сэдвүүд нь бие даасан судалгаа шинжилгээ хийх олон төрлийн боломж олгодог. Номын сан эсвэл интернэтийн хэрэгслийг ашигласан албан ёсны судалгаа эсвэл ярилцлага, санал асуулга, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хийсэн ажиглалт болон бусад мэдээлэл цуглуулах арга техник дээр суурилсан мэдээллийн судалгаа хийж болно. Ганцаарчилсан эсвэл бүлгийн судалгаа байх эсэхээс үл хамааран судалгааны төсөл нь бие даан сэтгэх, өгөгдөлд дүн шинжилгээ хийх чадварыг хөгжүүлж, хүний эрхийн асуудлаарх нарийн төвөгтэй байдлын талаарх ойлголтыг гүнзгийрүүлдэг.

Жишээ нь: “Цүнхээ багла” (34 дэх тал); “Хүүхэд цэрэг” (35 дахь тал); “Хүмүүнлэгийн эрх зүй” (35 дахь тал); “Зөвлөл ба шүүх” (36 дахь тал); “Олон улсын эрүүгийн шүүх” (39 дэх тал); “Зарим “цөөнхийн бүлгүүдийг” тодорхойлох нь” (47 дахь тал); “Хоол хүнс” (54 дэх тал); “Ажил” (56 дахь тал); “Эрчим хүч” (57 дахь тал).

H Дүрд тоглох/Жүжигчилсэн тоглолт

Дүрд тоглох нь хичээл эхлэхээс өмнө тоглодог жүжигчилсэн тоглолттой адил юм. Ихэвчлэн зохиомол бөгөөд өгүүллэг (өгүүлэгч болон гол дүрүүдийн хамт) эсвэл жүжгийн хэлбэрээр (гол дүрүүд хоорондоо харилцаж, харилцан яриа өрнүүлдэг - магадгүй багш болон ангийн бусад хүмүүсийн тусламжтайгаар) хийж болно. Дүрд тоглох нь суралцагчдад бусад бүлгийн мэдрэмж, хандлага болон зарим асуудлын харилцан хамаарлыг мэдрэх боломж олгодог онцгой ач холбогдолтой юм.

Дүрд тоглох тоглолтууд нь богино байх тусам сайн байдаг бөгөөд дараа нь ярилцах хангалттай цаг гаргах хэрэгтэй. Ийм үйл ажиллагааны дараа хүүхдүүд өөрсдийн мэдрэмж, айдас, ойлголтоо илэрхийлэх, боломжит үр өгөөжийг нэмэгдүүлэх, бий болсон сөрөг мэдрэмжийг арилгах нь ихээхэн чухал. Багш нар суралцагчдыг жүжгийн дүрд гарсан хүнтэй адил болж болохгүйг сануулах шаардлагатай тулгарч магадгүй. Оролцогчид хийж буй зүйлээсээ татгалзах, магадгүй тайлбар өгөх, асуулт асуух боломжтой байх ёстой. Ангийн бусад гишүүд ч гэсэн дүрд тоглоход оролцох, санал бодлоо илэрхийлэх, асуулт асуух боломжтой байх ёстой.

Дүрд тоглох хувилбарууд нь зохиомол шүүх хурал, төсөөллийн ярилцлага, сонсгол, хуралдаан, дуурайх тоглоом байж болно. Эдгээр нь ихэвчлэн зохион байгуулалттай, удаан үргэлжилдэг тул багш, суралцагчд үүнд бэлдэх шаардлагатай.

Жишээ нь: “Миний хүүхэлдэйн гэр бүл” (23 дахь тал); “Дээд хэмжээний уулзалт” (34 дэх тал); “Зөвлөл ба шүүх” (36 дахь тал); “Шүүхийн төрлүүд” (37 дахь тал); “Ажлын амьдрал” (58 дахь тал); “НҮБ-ын загвар хурал” (61 дэх тал).

I Сурталчилгааны хуудас

Самбар, хүснэгт, зурагт хуудас, гэрэл зураг, слайд, видео, кино зэргийг ашиглан суралцах үйл ажиллагааг сайжруулж болно. Ерөнхийдөө дүрмийн хувьд зурагт хуудас, диаграммын мэдээлэл нь товч, тодорхой байх, тойм эсвэл жагсаалт хэлбэрээр байх нь зүйтэй. Хэрэв нэмэлт бичвэр шаардлагатай бол гарын авлагыг ашиглаж болно. Үзүүлэн таниулах хэрэглэгдэхүүнийг ямар ч хэмжээгээр ашиглаж болох хэдий ч энэ нь суралцагчдын идэвхтэй хэлэлцүүлэг, шууд оролцоог хэзээ ч орлож чадахгүй.

Үнэлгээ

Мэдээллийн агуулга болон суралцагчдын ойлголтын түвшинг стандарт аргаар үнэлж болно. Гэхдээ хандлага, хандлагын өөрчлөлтийг үнэлэх нь субъектив шинж чанартай тул илүү хэцүү байдаг. Давтамжтай интервал бүхий нээлттэй асуулга нь хамгийн энгийн арга боловч тэдний өгсөн сэтгэгдэл нь түр зуурын, хэт өнгөц байдаг.

Сургуулийн хамт олны хүний эрхийн уур амьсгал сайжирсан эсэхийг дүгнэх нь мөн адил хэцүү. Гэхдээ амжилтын шалгуур үзүүлэлтүүдийг сайтар тодорхойлж, үнэлгээг тогтмол хийж байвал сургуулийн орчинд гарч буй өөрчлөлтөд дүн шинжилгээ хийж, хариу арга хэмжээ авах боломжтой.

Хүний эрхийн үүднээс хувь хүн, анги, сургуулийн хамт олны туршлагыг үнэлэх хяналтын хуудас гаргахад суралцагчдыг татан оролцуулах нь сургалтын чухал үйл ажиллагаа байж болох юм («Сургуулийнхаа хүний эрхийн орчныг хэмжих нь», 63 дахь талыг үзнэ үү).



Хоёрдугаар бүлэг

Сургуулийн өмнөх болон бага боловсролын сургууль дахь хүний эрхийн сэдвүүд

Өөртөө итгэх итгэл ба нийгмийн хүндлэл

Сургуулийн өмнөх болон бага боловсрол дахь хүний эрхийн сургалт нь суралцагчдын өөртөө итгэх итгэл, өөрийгөө болон бусдыг хүндэтгэх мэдрэмжийг төлөвшүүлэхэд чиглэгддэг. Эдгээр нь хүний эрхийн соёлын үндэс суурь юм. Иймд багшийн “багшлах зарга барил” маш чухал. Дэмжих арга барил нь хүний эрхийн сургалтын үйл ажиллагаа, тэр ч байтугай хүний эрхийн бус бусад үйл ажиллагааг ямагт утга учиртай болгож өгдөг.

Сургамжит түүхүүд үнэлж баршгүй чухал ач холбогдолтой. Балчир насны хүүхдүүд сургамжит түүх, ёс суртахуунаас суралцдаг бөгөөд сургамжит түүхүүд нь тэдний маш их хайртай дүртэй холбоотой бол тэдгээрийг тод томруун санаж чадна. Ийм сургамжит түүхийг үлгэрийн номноос, эцэг эх, өвөө эмээгээс эсвэл бүр өөрийн төсөөллийг ашиглан олж авч болно.

Хэрэв хангалттай нөөц болно гэж үзвэл ангийн номын сан нь ихээхэн ач тустай. Ном сонгохдоо олон соёлт, идэвхтэй, хэвшмэл бус дүрүүд болох эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн аль алиныг нь харуулсан сэтгэл татам бүтээлүүдийг олж авах нь чухал. Ангидаа ном унших эсвэл зурагт ном үзүүлэхдээ түүнд агуулагдаж байгаа эсхүл хэлсэн сайн зүйлсийг онцлон тэмдэглэнэ.

Хэрэв бололцоотой бол суралцагчдыг хоол хийх, модон урлал хийх эсхүл шавар сав хийх зэргээр оролцуулж болно. Эдгээрийг төсөөллийн тоглоом хэлбэрээр ч хийж болно. Бүх үйл ажиллагаанд охид, хөвгүүдийн аль алиныг оролцуулна. Хэрэв үйл ажиллагааны талаар санал зөрөлдөөн үүсвэл нөхцөл байдлыг тэнцвэржүүлэх, ялгаварлан гадуурхах үйлдлийг таслан зогсоох ангийн дүрэм гаргах шаардлагатай. Гэхдээ ийм дүрмийг байнга хэрэглэх шаардлагагүй. Анги танхимын зохион байгуулалт, суралцагчдын эгнээ, жагсаалтыг өөрчлөх замаар тэгш байдлыг хангажболно. Суралцагчдыг илт ялгаатай байдалд үндэслэн бүлэглэхээс зайлсхийх нь чухал. Суралцагчид хоорондын нөхөрлөлийг дэмжих, түүнчлэн ялгаатай байдал нь хүлээн зөвшөөрөгдөхүйц бөгөөд зүй ёсны хандлага гэдгийг тэдэнд ойлгуулахыг хичээгээрэй.

Зөрчилдөөнийг шийдвэрлэх

Зөрчилдөөн тул багш нар түүнийг шийдвэрлэх тогтвортой стратеги боловсруулах шаардлагатай. Багш хүн бүхий л тохиолдолд зөрчилдөөнийг хэлэлцэхэд нээлттэй байх нь зайлшгүй чухал юм.

Аливаа асуудалд шийдэл үргэлж байдаг гэдгийг онцол. Гэхдээ хүүхдүүд асуудлыг шийдвэрлэхийн тулд асуудлын талаар бодох хэрэгтэй. Асуудлыг шийдвэрлэх илүү системтэй хандлагыг дараах байдлаар харуулав.

1. **Асуудлыг тодорхойлж, түүнийгээ ойлгох.** Үйл хөдлөл, яриаг зогсоож, оролцож байгаа хүүхдүүдээс өөрсдийн зан төлөвийн асуудлыг хамтдаа хэлэлцэхийг хүснэ.
2. **Юу болсон талаар тайлбарлуулах.** Болсон үйл явдлын талаар оролцсон хүүхдүүд болон бусад хүмүүсээс асууна. Хөндлөнгөөс тасалдуулахгүйгээр ярих боломжийг хүүхэд бүрд олгоно. Тохиромжтой үед бие биедээ хүрэх, тэврэх зэрэг эерэг урам зориг нь уур уцаар, гэм буруутай бах мэдрэмжийг бууруулдаг. Гэхдээ үргэлж төвийг сахисан байх нь чухал.
3. **Төрөл бүрийн шийдлүүдийг судлах.** Асуудалд шууд холбоотой хүмүүсээс тухайн асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар асууна. Хэрэв хүүхдүүд шийдлийг санал болгож чадахгүй бол багш зарим санааг санал болгож болно.
4. **Шийдлүүдийг үндэслэлтэй гаргах.** Асуудлыг шийдэх олон шударга шийдэл байж болохыг онцолно. Эдгээр шийдлийн бие махбодын болон сэтгэл санааны үр дагаврын талаар бодолцож, үүнтэй төстэй өмнөх туршлагауудыг эргэн санахад хүүхдүүдийг дэмжээрэй.
5. **Үйлдлээ сонгох.** Танилцуулсан шийдлүүдээс аль нэг дээр харилцан тохиролцохыг эрэлхийлнэ.
6. **Тухайн үйлдлийг хийх.**

Ялгаварлан гадуурхалттай тэмцэх



Ялгаварлан гадуурхсан зан үйлийн тохиолдолд шийдлийг олоход тийм ч хялбар байдаггүй. Ихэвчлэн гадуурхсанхүүхэд болон гомдсон хүүхдийн аль аль нь ялгаварлан гадуурхалтын талаар тодорхой ойлголтгүй байдаг. Ийм тохиолдолд багшийн үйлдэл онцгой ач холбогдолтой. Юуны өмнө багшийн зүгээс ялгаварлан гадуурхах зан үйлийг хатуу шүүмжилж, энэ нь хүлээн зөвшөөрөгдөхгүй гэдгийг тодорхой хэлэх ёстой. Багш зөрчлийн хохирогч болсон хүүхдэд түүний уур уцаар,

айдас, төөрөгдөл зэргийг шүүмжлэхгүйгээр тодорхой дэмжлэг үзүүлж, харин ялгаварлан гадуурхсан зан үйл гаргасан хүүхдэд хатуу боловч дэмжлэгтэй харилцана. Багш нар хохирогч хүүхдүүдэд тэдний жендэр, гадаад төрх, хөгжлийн бэрхшээл, хэл, арьс

үндэс болон бусад зүйлд сөрөг хариу үйлдэл үзүүлэх нь хүлээн зөвшөөрөгдөөгүй өрөөсгөл үзлээс үүдэлтэй гэдгийг ойлгоход нь туслах ёстой; Түүнчлэн багш нар уг асуудалд хамааралтай эсхүл нөхцөл байдлын гэрч болсон хүүхдүүдтэй холбоотой асуудлыг судлах шаардлагатай. Ийм тохиолдлын талаар эцэг эх, ажилтнууд, орон нутгийн бүлгийн гишүүдтэй ярилцаарай.

Дээрх аргыг сургуулийн бүх түвшинд ашиглахаас гадна сургуулиас гадуурх бусад онцгой нөхцөл байдалд ашиглаж болно. Үүнийг ялгаварлан гадуурхалтын бүх зан үйлд хэрэглэж болно. Боломжтой бол анги дотор угсаатны олон янз байдлыг хүлээн зөвшөөрч, ойлгож, боломжит бүхий л үед угсаатны баяруудыг тэмдэглэх хэрэгтэй. Арьс үндэс болон жендэрийн ялгаварлан гадуурхах үзэл нь ихэвчлэн бага насны хүүхдүүдэд тохиолддог гэдгийг санах хэрэгтэй бөгөөд уг аргыг ашиглан энэ зан байдлыг арилгах боломжтой. Мөн багш нар ялгаварлан гадуурхах хандлагатай байж болохыг анзаарч, хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ түүнийг арилгахын тулд хичээнгүйлэн анхаарах хэрэгтэй.

Түүнчлэн анги танхим, сургуулийн орчныг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд хүртээмжтэй, тав тухтай байлгахад анхаарах хэрэгтэй.

Хүний эрхийн ойлголтыг бага насны хүүхдийн боловсролд нэвтрүүлэх дараах стратеги, үйл ажиллагаа нь арга замыг санал болгож байна.

Ижил болон ялгаатай байдлыг хүндэтгэх

А Шинж тэмдэг, шинж чанар

Хүүхдүүд тойрог хэлбэрээр сууна. Нэг хүүхэд тойргийн голд зогсоод өөрийгөө дүрсэлсэн үг хэлнэ. Жишээ нь: “Бүс зүүсэн байна” эсвэл “Би эгчтэй” гэх мэт. Өөрийн шинж тэмдгийн талаар хуваалцсан бүх хүүхэд суудлаа сольж суух буюу тойргийн голд зогсож байгаа болон сууж байгаа бүх хүүхэд солигдоно. Суудалгүй үлдсэн хүүхэд тойргийн гол зогсож, дараагийн шинж чанарыг нэрлэнэ. Хүүхдүүд ижил төстэй, олон талаараа ялгаатай болохыг хурдан хугацаанд ажиглан харна. “Сайхан сэтгэлтэй хүмүүс” гэх мэт илүү биет бус шинж чанараар хүүхдүүдийг ангилан сонгох нь төгсгөлийг сонирхолтой болгоно. Ийм шинж чанаруудыг нэг дор тодорхойлоход хэцүү болдог тул тоглоом илүү задарч өгнө. Багш нар ийм зан чанарыг хүмүүс хэрхэн таних талаар ярилцаж болно.

(ХЭТТ-ын 1, 2 дугаар зүйл; ХЭТК-ын 2 дугаар зүйл)

В Нэг завин дээр

Хүмүүс заримдаа өөртэйгөө адил гэдгийг мэддэггүй болохыг багш тайлбарлана. Дараа нь багш нэг ангиллыг (жишээлбэл, төрсөн сар, ах дүүсийн тоо, гэрийн тэжээвэр амьтан, дуртай тоглоом, наадгай гэх мэт) нэрлээд, хүүхдүүдээс энэ ангилалд багтдаг бусад хүмүүстэй бүлэг байгуулахыг хүснэ. Хүүхдүүдийн нас томрохын хэрээр хүүхдүүд илүү төвөгтэй ангилалд (жишээлбэл, ярьдаг хэлний тоо, ажил мэргэжлийн хүсэл эрмэлзэл, хобби, сургуулийн дуртай хичээл) хариулна. Тоглоомыг “Та нар энэ дасгалаас юу сурсан бэ?” гэсэн асуултаар үргэлжлүүлж хүмүүсийн төдийлөн анзаардаггүй ижил төстэй болон ялгаатай талуудын тухай хэлэлцүүлэг өрнүүлснээр төгсөнө.

(ХЭТТ-ын 2 дугаар зүйл; ХЭТК-ын 2 дугаар зүйл)

Өөртөө итгэх ИТГЭЛИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

1. Би хэн бэ? Би ямар хүн бэ?

А “Би хэн бэ?” ном

Хүүхдүүд өөрсдийнхөө тухай номыг бичих бөгөөд өөрийн зургийг номын нүүрэнд байрлуулна. Энэхүү номонд хувийн зураг, зохиол, шүлэг оруулж болно. Хүүхдүүд туршлагажихын хэрээр хувийн мэдээлэл, өөрийнхөө тухай асуулт, асуултын хариулыг оруулах боломжтой. Хэрэв нөөц боломж хязгаарлагдмал байвал бүх ангид зориулж хүүхэд бүрд нэг эсвэл хоёр хуудас ноогдох ном бүтээж болно.

(ХЭТТ-ын 3, 19 дүгээр зүйл; ХЭТК-ын 6,7,8,12,13, 30 дугаар зүйл)

В Ярилцах тойрог

Хүүхдүүдийг багш болон бусад оролцогчдын хамт тойрог хэлбэрээр суулгана. Багш нээлттэй асуулт асууж, суралцагч бүр ээлжлэн хариулна. Дараах асуултаас нэг буюу хэд хэдэн асуулыг асууж болно.

— Надад хамгийн их таалагддаг зүйл бол ... Би ... байхыг хүсэж байна

- Миний дуртай тоглоом бол ...
- Миний нэр ... утгатай гэж би бодож байна
- Би ... талаар мэдэхийг хүсэж байна.
- Би байхдаа аз жаргалтай байдаг. Би ... үед гунигтай байдаг.
- Би илүү их ... болохыг хүсэж байна. Хэзээ нэгэн цагт би найдаж байна.

Тасалдалгүйгээр сонсож цагийг тэнцвэртэй хуваарилах нь маш чухал. Хэрвээ хүүхдүүд ярихыг хүсэхгүй бол “алгасаж” болно. Дасгал дуусах хүртэл хүн бүр суудалдаа сууна. Хариултуудыг “Би хэн бэ?” номонд оруулж болно.

(ХЭТТ-ын 18,19 дүгээр зүйл, ХЭТК-ын 8,12,13,14,17,31 дугаар зүйл)

С Амьдралын шугам

Хүүхэд бүр өөрийнхөө амьдралыг дүрслэн харуулахын тулд нэхмэлийн утсыг сунган хананд өлгөнө. Дараа нь зурсан зураг, түүх, өөрт тохиолдсон чухал зүйлсийг харуулсан зүйлсийг утсандаа тогтооно. Үүнийг он цагийн дарааллаар эсвэл хүүхдийн хүссэн дарааллаар хийж болно. Утасыг цаашид сунгах боломжтой байдлаар байршуулна.

(ХЭТТ-ын 1,3,19 дугаа зүйл, ХЭТК-ын 6,8,12,13,14,27,30,31 дугаар зүйл)

Д Би хана/газар дээр

Хүүхэд бүр том цаасан дээр эсхүл газарт өөрийн биеийг зурж дараа нь хувийн болон бие бялдрыг шинж чанаруудыг (жишээ нь: нэр, өндөр, жин, хүүхэд сургуульдаа эсвэл том болоод юу сурч, юу хийхийг хамгийн их хүсдэг) бичнэ. Хэрэв та цаас ашигласан бол тэдгээрийг хананд тогтоох хэрэгтэй. Бүх суралцагчид бие биенийхээ тухай төдийгүй өөрсдийнхөө тухай мэдэх боломжийг олгоно.

(ХЭТТ-ын 3, 19, 24 дугаар зүйл, ХЭТК-ын 6, 7, 8, 12, 13, 28, 29, 31 дугаар зүйл)

Е Би болон миний мэдрэхүй

Хүүхдүүд тойрог хэлбэрээр ярилцах, эсхүл дүрд тоглох тоглоом ашиглан дараах асуултыг асууна.

Сонсох нь надад ... тусалдаг. Харах нь надад ... тусалдаг. Үнэрлэх нь надад тусалдаг. Хүрэх нь надад ... тусалдаг. Амтлах нь надад ... тусалдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдээс асуулт асуухдаа тэдгээрийн хэрэгцээнд нийцүүлэн асуултыг өөрчилнө. (жишээ нь: «сайн, эсхүл огт харж чадахгүй байсан ч Би хэвээрээ л байгаа, би чадна»). Илүү сайн сонсох, үнэрлэх, хүртэхэд нь туслах хэрэгсэл зохион бүтээхийг хүүхдүүдээс хүсээрэй. Тэднээс үүнийг дүрсэлж, зурж, жүжигчилсэн байдлаар үзүүлээрэй.

(ХЭТТ-ын 22, 25, 26 дугаар зүйл; ХЭТК-ын 23, 26, 28, 29 дугаар зүйл)

F Хүслийн тойрог

Суралцагчдыг тойрог хэлбэрээр суулгаж хүүхэд бүр дараах хүслийг ээлжлэн хэлэхийг санал болгоно (үүнийг мөн жижиг бүлгүүд эсвэл хосоор хийж болно):

- Хэрэв би ямар нэгэн амьтан болж чадах байсан бол, би ... байх байсан, учир нь ...
- Хэрэв би шувуу болж чадах байсан бол ...
- Хэрвээ би шавж болж чадах байсан бол байсан. Учир нь би ...
- Хэрэв би цэцэг болж чадах байсан бол ... учир нь би ...
- Хэрэв би мод болж чадах байсан бол ...
- Хэрэв би тавилга олж чадах байсан бол би ...
- Хэрэв би хөгжмийн зэмсэг болж чадах байсан бол ... учир нь ...
- Хэрэв би барилга байшин болж чадах байсан бол ...
- Хэрвээ би машин болж чадах байсан бол ..., учир нь би ...
- Хэрвээ би гудамж байсан бол...
- Хэрвээ би хот/аймаг/бүс нутаг болж чадах байсан бол би ... байх байсан, учир нь ...
- Хэрэв би гадаад улс болж чадах байсан бол ...
- Хэрвээ би тоглоом болж чадах байсан бол ... учир нь би ... байх байсан
- Хэрвээ би бичлэг байсан бол ...
- Хэрвээ би телевизийн шоу байсан бол
- Хэрвээ би кино байсан бол ...
- Хэрвээ би хоол болж чадах байсан бол би ...
- Хэрэв би ямар нэгэн өнгөтэй болж чадах байсан бол би ... байх байсан.

(ХЭТТ-ын 19 дүгээр зүйл; ХЭТК-ын 13, 14 дүгээр зүйл)

2. Би хэрхэн бусадтай амьдрах вэ?

А Миний хүүхэлдэйн гэр бүл

Хүүхэд бүр өөрийгөө оролцуулсан хүүхэлдэйн гэр бүлийг хийнэ. Эдгээр нь өнгөт цаасан хайчилбар, саваа, шавар эсвэл баримлын шавар дүрс гэх мэт энгийн байж болно. Тэдгээр дүрс бүрд нэр өгч, тэдгээрийн түүнтэй хэрхэн хамааралтай болохыг тайлбарлуулна. Дараа нь хүүхэд бүр ёслол (жишээ нь хурим) эсвэл баяр зохион байгуулж, ангийнхандаа үзүүлнэ. Хүүхэлдэйн гэр бүлд ойр орчим амьдардаг бусад хүмүүсийг багтааж өргөтгөж болно. Хүүхдүүд тэдэнтэй байнга юу хийдэг талаар ямар нэгэн зүйлийг жүжигчлэн үзүүлж чаддаг. Дэлхийн хаанаас ч ирсэн хүмүүсийг тоглоомын гэр бүлдээ хамруулж, өргөжүүлж болно.

**(ХЭТТ-ын 16, 20, 27 дугаар зүйл;
ХЭТК-ын 9, 10, 15, 31 дүгээр зүйл)**

В Төсөөллийн найз

Хүүхдүүд нүдээ аньж чимээгүйхэн сууж, эсхүл хэвтэнэ. Тэднээс гүнзгий амьсгал аваад дараа нь аажмаар түүнийгээ гаргахыг хүснэ. Дахин хоёр удаа давтана. Одоо тэднээс дэлхийн хаана нэгтээ (эсвэл бүр сансар огторгуйд ч) онцгой эсхүл дуртай газраа төсөөлөхийг хүснэ. Тэд тэр газартаа алхаж байна гэж хэлээрэй. Тэд өөрсдийн төсөөллөөр тэнд юу болж байгааг мэдэрч, сонсож, харж байна. Тэднийг нүдээр харж болох байшин эсвэл барилга руу хөтөлж, тусгай өрөө олохоор оч. Өрөөний нэг хана нь автомат хаалгатай. Хаалга аажмаар дээш онгойно, ингэхдээ тэдний урьд өмнө хэзээ ч уулзаж байгаагүй онцгой найзынх нь хөл, бие, эцэст нь нүүр царай нь харагдана. Энэ найз хөгшин эсхүл залуу хүн, ер нь юу ч байж болно. Энэ найз нь үргэлж дэргэд байдаг бөгөөд хэрэв хүсвэл, ярилцах, хандах хүн хэрэгтэй бол, түүнтэй дахин уулзах боломжтой. Хаалгаа хаагаад гэрээсээ гараад ангидаа ирээрэй. Хүүхдүүдээр төсөөлсөн зүйлээ ярианы тойрогт эсвэл хос, бүлгээр хуваалцахыг хүсээрэй.

(ХЭТТ-ын 20 дугаар зүйл; ХЭТК-ын 15 дугаар зүйл)

С Захидал болон найз

Өөр сургууль эсвэл өөр улсын сургуулийн суралцагчтай захидал болон цахим шуудан солилцох боломжтой. Ангисаа шүлэг эсвэл бэлэг илгээх замаар энэхүү солилцоог эхлүүлнэ.

Хэрвээ очих боломжтой бол бусад бүлгийн хүүхдүүдтэй уулзах боломжийг олгоорой. Хамтрах сургуулийг судлах:

- Хэр том вэ?
- Тэнд ямар тоглоом тоглодог вэ?
- Эцэг эхчүүд юу хийдэг вэ?
- Ялгаатай болон ижил төстэй талууд юу вэ?

(ХЭТТ-ын 19, 20, 26 дугаар зүйл; ХЭТК-ын 13, 17, 29 дүгээр зүйл)

Д Найз

Суралцагчдыг дээд ангийн сурагч нартай холбоо тогтоолгоно. Тухайн хүүхдэд ямар нэг асуудал тулгарвал дээд ангийн найзаасаа тусламж хүсэхийг дэмжих үйл ажиллагаа зохион байгуулах хэрэгтэй. Дээд ангийн найз нь тоглоом заах, хичээлд нь туслах зэргээр бяцхан хамтрагчийнхаа сонирхлыг тата, халамжлахад нь туслах арга замыг бодож олох хэрэгтэй.

(ХЭТТ-ын 20 дугаар зүйл; ХЭТК-ын 15 дугаар зүйл)

Е Миний эргэн тойрны хүмүүс

Хүүхдүүдийг тойрог болгож суулгаж, өөрийн сайн чанарын тухай бодохыг хүснэ, эсхүл «Хүнд байдаг бидний биширдэг зан чанарууд юу вэ?» гэж асууна. Дараа нь эдгээр сэдвээр хэлэлцүүлэг явуулна:



- Чамд өөрт чинь байдаг, чиний дуртай чанар бүхий бусад хүнийг чи хүндэтгэх үү?
- Чамд байдаггүй бусад хүнд байдаг чанарыг хүндэтгэх үү?
- Хүн бүр хүндэтгэгдэх ёстой юу? Яагаад?
- Та бусдыг хэрхэн хүндэтгэдэг вэ?

Дараа нь хэн нэгэн өөрсдийг нь хүндэтгээгүйгээс болж гомдсон үеэ эргэн бодохыг хүүхдүүдээс хүснэ.

- Хүндлэлгүй байдал ямар санагдсан бэ?
- Хүмүүс яагаад заримдаа бусдад хүндлэлгүй ханддаг вэ?
- Нэр төр гэж юу вэ? Бусад хүмүүс чамайг хүндэтгэхгүй байхад таны нэр төр хохирч байна уу?
- Бусад хүмүүс чамтай хүндлэлгүй харьцвал чи юу хийх вэ?

Эцэст нь,

- “Бүх хүн хүндлэл хүлээх ёстой гэдэг нь юу гэсэн үг вэ?” хэмэн асууна.
- Хүмүүс бие биеэ илүү хүндэлдэг бол тэдний нийгэм дэх амьдрал хэрхэн илүү тайван байж болох тухай жишээ асуугаарай.
- Хэн нэгэнд хүндлэл үзүүлж болох нэг арга замыг бодохыг хүүхдүүдээс хүснэ.

(ХЭТТ-ын 1, 2, 12 дугаар зүйл; ХЭТК-ын 2, 12, 13, 14, 16, 29 дүгээр зүйл)

F Угаалгын машин

Хүүхдүүд хоорондоо ойрхон, харилцан бие бие рүүгээ харсан хоёр зэрэгцээ эгнээ үүсгэнэ. Хүүхдийг нэг захаас нөгөө зах хүртэл энэхүү эгнээний дундуур явуулаарай (“угаалгын зам”). Хүн бүр (энэ нь соёлын хувьд тохиромжтой бол) түүний нурууг товшиж эсвэл магтаал, урам зоригийн үгсийг хэлэнгээ гар барина. Үүний үр дүн нь “Угаалгын” төгсгөлд гялалзсан, гялтганасан, аз жаргалтай хувь хүн юм. Тэрээр аль нэг эгнээнд нэгдэж, дараа нь өөр хүүхэд дээр энэхүү үйл явц давтагдана. (Өдөр бүр нэг юм уу хоёр хүүхэд дээр ажиллах нь нэг дор хүүхэд бүрийг угаалгад оруулахаас илүү хөгжилтэй байдаг.)

(ХЭТТ-ын 1, 2 дугаар зүйл; ХЭТК-ын 2 дугаар зүйл)

Итгэлцлийг бий болгох

Итгэлцэл нь багш, сурагчийн харилцаанаас эхэлдэг. Суралцагчдын тав тухыг хангах гэдэгт:

- Багш ч гэсэн тэдэнтэй адилхан хүн гэдгийг сурагчдад ойлгуулах;
- Үйл ажиллагаа нэг бүрийг сайтар тайлбарлах;
- Танил бус үг хэллэг, утга санааг (агуулга) тайлбарлах;
- Мэдээллээр хангах (зөвхөн тодорхой үйл ажиллагааны талаар төдийгүй суралцагчдын амьдралд хамаарах асуудлуудын талаар).

Шаардлагатай тохиолдолд багш нар өдөрт ердөө хэдэн минутыг орон нутгийн үйл явдал, хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарч буй мэдээний талаар ярилцахад зарцуулах хэрэгтэй. Энэ нь хүний эрхийн асуудлыг албан бус талаас нь харах олон янзын боломжийг олгоно. Энэ нь өөрөө боловсрол болж болно.

Сохор итгэл

Ангийн хүүхдүүдийг хоёр хоёроор нь баг болгоно. Нэг хүүхэд нь нөгөө хүүхдийнхээ нүдийг боож улмаар “нүдээ боолгосон” хүүхдийг хэдэн минутын турш чиглүүлэн дэмжинэ. Ийнхүү дэмжлэг үзүүлж байгаа хүүхэд нь нүдээ боолгосон хүүхдийн итгэлийг хөсөрдүүлэх, үгүй хийх зорилгогүй тул чиглүүлж, дэмжлэг үзүүлж байгаа хүүхэд энэ байдлыг урвуулан ашиглахгүй байхад сайтар анхаарна. Багийн “чиглүүлэгч” нь “нүдээ боолгосон” хамтрагчдаа хөл болон хуруугаараа юмсыг мэдрэх, дуу хоолойгоор удирдан чиглүүлэх, тоглоом тоглох зэргээр олон төрлийн үйлдэл хамт хийхийг хичээх хэрэгтэй.

Хэдэн минутын дараа хүүхдүүдийн дүрийг сольж, “чиглүүлэгч” нь нүдээ боолгож, “нүдээ боолгосон” хамтрагч нь дэмжлэг үзүүлэн чиглүүлнэ.

Дасгал дууссаны дараа хүүхдүүдэд юу болсон талаар ярилцах боломжийг олгоно. Тэдний “нүдээ боолгосон” хамтрагчид төдийгүй “чиглүүлэгч, дэмжигч”-ийн үүднээс хариуцлага хүлээх мэдрэмжийн талаар ярилцаарай.

Энэ нь харааны (эсвэл сонсголын) бэрхшээлтэй хүмүүсийн амьдрал ямар байдгийг илүү сайн ойлгоход туслах төдийгүй, нийгэмд итгэх итгэлийн ач холбогдлын талаар ярилцахад туслах болно. Улмаар хүний нийгэм, уг нийгэм хэрхэн ажилладаг, яаж бүтэлгүйтэж болох талаар хэлэлцүүлэг өрнүүлж болно.

(ХЭТТ-ын 28 дугаар зүйл; ХЭТК-ын 3, 23 дугаар зүйл)

Ангийн дүрмийг бий болгох

Ангийн уур амьсгалын ач холбогдол, оролцоо, хамтын ажиллагааны хэрэгцээний талаар хэт их онцолж болохгүй. Хүүхдүүдийн санал бодол, зөвлөмж нь ангийн уур амьсгалыг бүрдүүлэхэд хамгийн их ач тустай байдаг. Тэдний санал, дэмжлэгт нээлттэй хандаж, шаардлагатай өөрчлөлтүүдийг хийгээрэй.

Дараагийн дасгал нь ангийн уур амьсгалд шууд нөлөөлдөг учраас маш чухал юм. Энэ дасгал нь багшийн анги танхимыг зохион

байгуулахад анги хамт олныг татан оролцуулах хүсэл эрмэлзэл, сурагчиддаа итгэх итгэлийг тодорхой болгох, ангид ямар дүрэм тогтоох нь зүйтэй эсхүл боломжтой эсэх, тэдгээрийг хэрхэн дагаж мөрдөх, хадгалахад багшийн үүрэг оролцоог онцлох зорилготой.

А Ангийн хэрэгцээ

Ангийн дүрмийг хэд хэдэн аргаар зохиож болно. Үүнд оюун бодлоо уралдуулах (дараагийн хэлэлцүүлгээр орхигдсон зүйлсийг дахин авч үзнэ); жижиг бүлгүүдээр, дараа нь бүх ангийн нэгдсэн хуралдаанд дүгнэлтээ танилцуулах; эсвэл дараа нь ангид тухайлан хэлэлцэхээр багшийн нэгтгэсэн бие даасан даалгаврууд багтана.

Үүнийг эхлүүлэх сайн арга бол хүүхдүүдээс юу хүсэж байгаа нь асуух явдал юм (жагсаалт нэлээд урт болж магадгүй). Дараа нь энэ жагсаалтаас үнэхээр хэрэгтэй гэж үзсэн зүйлсээ сонгохыг тэднээс хүснэ. Энэхүү жагсаалт нь илүү богино, илүү чухал зүйлсийг агуулсан байх шаардлагатай. Эдгээрийг “Манай ангийн хэрэгцээ” гэсэн хүснэгтэд жагсаан бичнэ. Эцэст нь тэднээс нийгмийн гишүүдийн хувьд хүртэх “эрхтэй” гэж бодож байгаа зүйлээ “хэрэгцээ”-ний хүснэгтээс сонгохыг хүсээрэй. Эдгээрийг “Манай ангийн эрх” гэсэн хүснэгтэд жагсаан бичнэ. Тэднээс яагаад ийм сонголт хийсэн болохыг асууна.

(ХЭТТ-ын 7, 21 дугаар зүйл; ХЭТК-ын 12, 13, 28, 29 дугаар зүйл)

В Ангийн үүрэг хариуцлага

Эрх, үүрэг хоорондын чухал холбоог онцлон тэмдэглэнэ. Суралцагчдаас ангийн эрхийн жагсаалтыг гаргасны дараа тэднээс эрх тус бүрийг үүрэг хариуцлагын үүднээс дахин тайлбарлаж, «Манай ангийн үүрэг хариуцлага» гэсэн тусдаа хүснэгтэд жагсаахыг хүснэ (жишээ нь: «Энэ өрөөнд хүн бүр аюулгүй байх ёстой» гэснийг «Хүн бүр хэн нэгнийг доромжлох, сэтгэлийг нь шархлуулахгүй байх үүрэгтэй» гэж засаж болно).

(ХЭТТ-ын 29 дүгээр зүйл; ХЭТК-ын 29 дүгээр зүйл)

С Эрх болон үүрэг хариуцлагатай амьдрах

Ангийн үндсэн эрх, үүргийн жагсаалтыг тохиролцсоны дараа тэдгээрийг нэмэх, шаардлагатай бол өөрчлөх боломжтой байхаар харуулна. Заримдаа хүүхдүүд эсхүл багш дүрмийг зөрчих, цаашлаад дүрэмд заагаагүй нөхцөл байдал үүсэхийг үгүйсгэхгүй. Зарим тохиолдолд ангийн дүрэм нь бусад багшийн үзэл бодол, сургуулийн

захиргаатай нийцэхгүй байх үед зөрчилдөөн үүсэж болно. Эдгээр нөхцөл байдалд яагаад асуудал буруу болж байгаа талаар сайтар судалж, ярилцах шаардлагатай. Энгийн хяналтаас илүүтэй ерөнхий зөвшилцөлд үндэслэсэн дэг журамд тогтоох нь үргэлж хэцүү байдаг тул зөвшилцөлд хүрэх үйл явц нь харилцан буулт хийх, болгоомжтой хэлэлцээр хийхийг шаарддаг. Ийм үйл явц нь өөрөө үнэ цэнтэй суралцах туршлага юм.

(ХЭТТ-ын 7, 11, 21 дүгээр зүйл; ХЭтК-ын 12, 13, 28, 29 дугаар зүйл)

Хүний эрхийн ойлголт

Ангийн зарим дүрмийг тогтоосны дараа үүнтэй ижил зарчимуудыг дэлхий нийтийн түвшинд адилтган үзэх нь дараагийн чухал алхам юм.

А Шинэ төр улсыг төвхнүүлэх

Хүний амьдралыг тэтгэхэд шаардлагатай бүх зүйлс бүрэн бүрдсэн тийм нэгэн шинэ эх газрыг нээж илрүүлсэн хэмээн төсөөлөхийг суралцагчдаас хүснэ. Тэнд өмнө нь хэн ч амьдарч байгаагүй. Ямар ч хууль, түүх байхгүй. Ангийн бүх сурагч тэнд суурьших болно. Энэ цоо шинэ улсын эрхийн жагсаалтыг гаргахаар сурагчдыг жижиг бүлгүүдэд хуваана. Сурагчид шинэ улсад ямар статустай байхаа урьдчилан мэдэх боломжгүй байх ёстой.



Бүлэг тус бүрийн сурагчид энэ улсад нэр өгч, тохиролцож болох арван эрхийг жагсаана. Бүлэг бүр жагсаалтаа танилцуулж, улмаар ангийн бүх суралцагчид дурдсан эрхүүдийг багтаасан “ангийн жагсаалт”-ыг гаргана. Ангийн жагсаалтын талаар хэлэлцүүлэг хийнэ (жишээ нь зарим эрхийг хассан тохиолдолд юу тохиолдох вэ? Ямар нэгэн чухал эрхийг орхисон уу? Энэ жагсаалт танай ангийн дүрмээс юугаараа ялгаатай вэ?)

(ХЭТТ-ын 13, 21, 26 дугаар зүйл; ХЭтК-ын 12, 13 дугаар зүйл)

В Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалыг нэвтрүүлэх

Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалыг дэлхийн бүх хүмүүсийн эрхийн жагсаалт хэмээн тайлбарлаж танилцуулна. Дараа нь хялбаршуулсан хувилбарыг чангаар уншина. (Хавсралт 1-ийг үзнэ үү). Суралцагчид ангийн жагсаалтад бичигдсэнтэй адил эрхийг сонсвол баруун талд нь тухайн жагсаалтын дугаарыг бичнэ.

Уншиж дууссаны дараа үр дүнг ярилцана:

- Түгээмэл тунхаглалд багтсан эрхүүдээс ангийн жагсаалтад орхигдсон байсан уу? Суралцагчид одоо жагсаалтад ямар нэгэн шинэ эрх нэмэхийг хүсэж байна уу?
- Ангийн жагсаалтаас Түгээмэл тунхаглалд орхигдсон зүйл байна уу?
- Түгээмэл тунхаглалд эрхээс гадна үүрэг хариуцлага багтсан уу?

Суралцагчид Хүүхдийн эрхийн тухай конвенцын хялбаршуулсан хувилбарыг ашиглан ижил төстэй дасгалуудыг хийж үзэх боломжтой.

(ХЭТТ-ын 21, 26 дугаар зүйл; ХЭтК-ын 29 дүгээр зүйл)

Хүүхдийн эрхийг танилцуулах

А Хүүхдийн эрх гэж юу вэ?

Суралцагчдаас зөвхөн хүн болохын хувьд биш, харин хүүхдд болохын хувьд тэдэнд илүү хамааралтай эрх, үүргийн талаар асууна. Ердөө хүүхэд юм чинь гээд тухайн үед түүнд ямар нэг зүйл хийх (эсвэл хийхгүй байх нь) яагаад буруу вэ?



Хүүхдийн эрхийн тухай конвенц нь хүүхдэд эрүүл, аюулгүй, аз жаргалтай өсөн торниж, нийгэмдээ зөв иргэн болж төлөвшихөд нь шаардлагатай зүйлсийг баталгаажуулдаг болохыг тайлбарлана. Хүүхдүүдэд хэрэгцээ ба эрхийн хоорондын хамаарлыг ойлгоход нь туслаарай.

Хэлэлцэх асуудал:

- НҮБ ямар учраас зөвхөн хүүхдийн хүний эрхийн тухай баримт бичиг баталсан гэж бодож байна вэ? Хүүхдүүдийн хэрэгцээ насанд хүрэгчдийнхээс юугаараа ялгаатай вэ?
- Хүүхдийн эрхийг яагаад онцгойлон хамгаалах шаардлагатай вэ? Зарим жишээ хэлнэ үү?
- Хүүхдүүдийн сайн сайхны төлөө яагаад тухайлсан заалтууд хэрэгтэй байдаг вэ? Хүүхдийн эсэн мэнд, аз жаргалтай байдал, хөгжил дэвшилд юу хэрэгтэй вэ?

- Хүүхдүүд яагаад тухайн нийгэмд оролцох хэрэгтэй вэ? Зарим жишээ хэлээрэй.
- Хүүхдийн эрхийг хүндэтгэж байгаа эсэхийг хэн хариуцах вэ? (жишээ нь: эцэг эх? багш нар? бусад насанд хүрэгчид? бусад хүүхдүүд? Засгийн газар?)

В Хүсэл, хэрэгцээ

Жижиг бүлгээр ажиллаж байгаа хүүхдүүдээс хүүхэд аз жаргалтай байхыг илтгэн харуулах 10 зүйлийн талаар карт хийхийг хүснэ. Тэд хуучин сэтгүүлээс зураг хайчилж эсхүл зурж болно. Тэдэнд картуудыг оновчтой байдлаар нэрлэхэд нь туслаарай. Бүлэг бүр өөрсдийг хийсэн “Хэрэгцээ” гэсэн гарчигтай картуудаа тайлбарлаж, байрлуулна.

Дараа нь Засгийн газар жагсаалтад байгаа зөвхөн зарим зүйлийг л хийх боломжтой гэж үзсэн тул тэдгээр хэрэгцээний жагсаалтаас арван зүйлийг хасах ёстой болохыг мэдэгдэнэ. Сонгосон картуудыг хасаад “Хүсэл” гэсэн гарчиг дор байрлуулна уу.

Дараа нь хүсэл гэсэн картнаас дахин хасалт хийх шаардлагатай байгааг зарлаж, ижил журмын дагуу дахин арван зүйлийг хасахыг хүснэ.

Эцэст нь дараах асуудлыг хэлэлцэнэ:

- Эхлээд ямар зүйлсийг хассан бэ? Яагаад?
- Хүсэл, хэрэгцээ хоёрын ялгаа юу вэ?
- Хүмүүсийн хүсэл, хэрэгцээ өөр өөр байдаг уу?
- Хэрэв хэрэгцээнээсээ дахин дахин хасвал юу болох вэ?

Хүүхдийн эрх нь хүүхэд бүр эрүүл, аз жаргалтай амьдарч, хариуцлагатай иргэн болж өсөхөд шаардлагатай хэрэгцээнд үндэслэгддэг болохыг тайлбарлаж дасгал ажлыг дуусгана. Хүүхдийн эрхийн тухай конвенц нь хүүхэд бүр эдгээр эрхтэй байхыг баталгаажуулах хүчин чармайлтын илрэл болохыг тайлбарлана. (дээрх “Хүүхдийн эрх гэж юу вэ?” дасгалыг үзнэ үү). Дунд болон ахлах ангийн сурагчид Конвенцын хураангуй хувилбарыг (2-р хавсралтыг үзнэ үү) чангаар уншиж, өөрийн хүсэл, хэрэгцээний жагсаалттай харьцуулж болно.⁸

⁸ Adapted from It's Only Right! A Practical Guide to Learning about the Convention on the Rights of the Child by Susan Fountain (UNICEF, 1993).

С Хүүхдэд юу хэрэгтэй вэ?

Суралцагчид жижиг бүлгээр ажиллахдаа хүүхдийн биеийг тоймлон зурж (эсвэл аль нэгийг нь тоймлон) хүүхдэд нэр өгнө.



Дараа нь суралцагчид насанд хүрсэн хүмүүс тухайн хүүхдээс ямар оюун ухаан, бие бялдар, оюун санааны болон зан чанарын шинж чанаруудыг (жишээлбэл, эрүүл мэнд, хошин шогийн мэдрэмж, эелдэг байдал гэх мэт) хүсч байгаа хэлэлцэж эдгээр чанаруудыг бичнэ. Тэд мөн эдгээр хамгийн тохиромжтой чанаруудыг (жишээлбэл, боловсролыг илэрхийлэх ном) илэрхийлэхийн тулд хүүхдийн дээр эсвэл түүний эргэн тойронд тэмдэг тэмдэглэгээ хийж болно.

Улмаар зурсан хүүхдийнхээ гадна талд дээр дурдсан шинж чанаруудыг олж авахын тулд хүүхдэд шаардлагатай хүний болон материаллаг нөөцийг жагсаан бичнэ (жишээ нь хүүхэд эрүүл байхын тулд хоол хүнс, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хэрэгтэй гэх мэт). Дараа нь бүлэг тус бүр бүлгийнхээ зурсан шинэ гишүүнээ “танилцуулж», түүнд зориулсан сонголтуудаа тайлбарлана.

Дараа нь Хүүхдийн эрхийн тухай конвенцыг танилцуулна (дээрх “Хүүхдийн эрх гэж юу вэ?” гэсэн хэсгийг үзнэ үү). Дараа нь конвенцын хураангуй хувилбарыг чангаар уншина уу (хавсралт 2-ыг үзнэ үү). Суралцагчид өөрсдийн зурсан хүүхдэд хамааралтай хэрэгцээг хангахад шаардлагатай эрхийг сонссон даруйд хамаарах хэрэгцээний хажууд конвенцын зүйлийн дугаарыг бичнэ. Ангис тодорхойлсон болон Конвенцод тусгаагүй аливаа хэрэгцээг дугуйлна.

D Хүүхдийн эрхийг дэмжих

Зарим улсад хүүхдийн эрхийг сонин хэвлэл, радио, телевизээр сурталчилж байна. Жижиг бүлгээр ажиллаж буй суралцагчдаас Хүүхдийн эрхийн тухай конвенцын зарим зүйл заалтыг (жишээ нь, зурагт хуудас, уран сайхны кино, дуу болон бусад хэлбэр) хэрхэн сурталчилж болохыг асууна. Бүлэг тус бүр өөрсдийн ажлын үр дүнг ангидаа танилцуулна.



Бага, дунд болон ахлах сургууль дахь хүний эрхийн сэдвүүд

Хүний эрхийн соёл нь хүний бүхий л зан үйлийг эерэг байлгах зарчмуудыг тодорхойлохыг оролддог. Эдгээр зарчмыг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлуудыг доорх хэсэгт харуулав. Хэдийгээр асуудал тус бүрд хамаарах цөөн хэдэн дасгал ажлыг тайлбарласан ч эдгээр нь багш нарт өөрсдийн үйл ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх болно. Эдгээр асуудлуудын зарим нь маргаантай байж болох тул багшаас мэдрэмж, хянуур байдлыг шаардана.

Тухайлсан асуудалд (тухайлбал, энх тайван, зэвсэг хураах, дэлхийн хөгжил, үзэл санааны хоригдол, цөөнхийн ард түмэн, арьс үндсээр ялгаварлан гадуурхах эсвэл жендэрийн эсрэг үзэл гэх мэт) анхаарал хандуулахыг хүсэж буй багш нар эдгээрийг хүний эрхийн хүрээнд танилцуулах хэрэгтэй. Ингэснээр сурагчид хэлэлцэж буй асуудал нь олон бусад асуудлыг багтаасан өргөн хүрээний асуудлын зөвхөн нэг хэсэг болохыг ойлгох болно. Энэ ерөнхий ойлголт нь өргөн хүрээг хамарч, тодорхой асуудал нь гүнзгий ойлголтыг бий болгоно. Хүний эрхийн чиглэлээр мэргэшсэн багш нарт гүнзгийрүүлсэн ойлголт өгөхийн тулд сурагчидтай маш ойр хамтран ажиллах шаардлагатай.

Нийгэм дэх хувь хүн – Хүний амьдралыг хамгаалах нь

Хүн төрөлхтнийг хувь хүмүүсийн нэгдэл гэж тодорхой ойлгуулахын тулд багш “хүн байх” гэх ойлголтыг суралцагчидтай хамт судалж болно.. Энэ бол өөртөө итгэх илтгэл болон хүндлэлийн тухай хоёрдугаар бүлэгт байгаа дасгал ажлуудын илүү боловсронгуй хэлбэр юм. Хүн бол нийгмийн амьтан; Бид өөр өөрийн онцлог зан чанартай хэдий ч бусадтай хамт амьдрах замаар суралцдаг. Тиймээс хувь хүний тухай ажил бол нийгмийн төлөөх ажил мөн.

А Хүн байх

Хичээл эхлэхийн өмнө ямар нэгэн зүйлийг (жишээ нь доош нь харуулсан хогийн сав) байрлуул. Үүнийг ертөнцийн өөр нэг хэсгээс ирсэн зочин хэмээн танилцуулна. Энэхүү зочин өөрсдийгөө «хүн» гэж нэрлэдэг амьтдын талаар мэдэхийг хүсэж байна. Иймээс зочинд хандан биднийг «хүн» гэж тодорхойлоход туслах зөвлөмжүүдийг асууна.

Хэлэлцэх асуудал:

- “Хүн” гэж чухам нь юу гэсэн үг вэ?
- Энэ нь зүгээр л амьд байх эсвэл “амьд үлдэх”-ээс юугаараа ялгаатай вэ?

(ХЭТТ-ын 1 дүгээр зүйл; ХЭТК-ын 1 дүүгээр зүйл)

В Шилэн доторх зурвас

Суралцагчдаас сансар огторгуйгаас дохио хүлээн авсан гэж төсөөлөхийг хүснэ. НҮБ-аас хүний тухай мэдээллийг тусгай хөлөг онгоцоор явуулах гэж байна. Юу илгээхээ (жишээ нь хөгжим, хүмүүсийн загвар, хувцас, уран зохиол, шашны эд зүйлс гэх мэт) сонгох нь суралцагчдын үүрэг юм. Ангараа оюун ухаанаа уралдуулан эсвэл сурагчид дангаараа хийх эсхүл жижиг бүлгийн ажил болгож болно.

“Би юу вэ?”, “Бид хэн бэ?” гэх зэрэг асуултууд нь гүн гүнзгий утгатай. Дээрх үйл ажиллагаа нь суралцагчдад өөрийгөө хүн гэж үзэх, хүний нэр төрийг ойлгох чадварыг бий болгох эхлэхийг тавих боломж олгоно. Сурлацагчид өөрсдийгөө хүн төрөлхтний өмнө олон талт үүрэг хариуцлага хүлээдэг хүний төлөөлөгч хэмээн үзэх нь маш чухал юм.

Хүн гэж юу болохыг ерөнхийд нь тодорхойлох нь хүнлэг бус байж болох зүйлийг олж харахад бидэнд тусална.

(ХЭТТ-ын 1 дүгээр зүйл; ХЭТК-ын 1 дүгээр зүйл)

С Эхлэл ба төгсгөл

Нийгэм дэх хүний тухай асуудал хамгийн нарийн төвөгтэй байдаг. Багшийн зүгээс суралцагчдаас хүн төрөхөөс эхлээд нас барах хүртэлх хувь хүний амьдралын тухай асуудлыг авч үзэхийг хүснэ.

- “Амьдрал” хаанаас эхэлдэг вэ?
- Хэзээ нэгэн цагт арьдралыг үгүйсгэж, булааж болох уу?
- “Амьдрал” гэж чухам юу болох талаарх бидний үзэл бодлыг ямар хүчин зүйл тодорхойлдог вэ? (шашин, технологи, хууль гэх мэт)

(ХЭТТ-ын 3 дугаар зүйл; ХЭТК-ын 6 дугаар зүйл)

Д “Сэтгүүлч алга боллоо!”

Багш өөрийн сонголтод үндэслэн дараах жишээн дээр ажиллах талаарх дэлгэрэнгүй мэдээллийг суралцагч нарт өгнө.

Та өөрийгөө сэтгүүлч хүн гэж төсөөл. Та өндөр албан тушаал хашиж байгаа хүнийг уурлуулахнийтлэл бичиж хэвлүүлсэн. Маргааш нь үл таних хүмүүс танай гэрт нэвтэрч чамайг аваад явсан. Чамайг зодож ганцааранг нь өрөөнд оруулсан. Таны хаана байгааг хэн ч мэдэхгүй. Хэн ч юу ч хийх талаар чамтай холбогдоогүй. Та тэнд хэдэн сар болж байна.

Энэ сэтгүүлч хэд хэдэн үндсэн эрхээ хасуулсан. Түгээмэл тунхаглалыг ашиглан ямар эрхийг зөрчсөн болохыг суралцагчдаас тодорхойлохыг хүснэ.

Суралцагч нэг бүрээс уг эрхийн талаарх холбогдох Хууль зүйн сайд эсхүл сэтгүүлчдэд хандан нээлттэй захидал бичихийг хүсээрэй. Ийм тохиолдолд хэн тусалж чадах вэ? (иргэний нийгмийн байгууллагын үүргийг суралцагчдад танилцуулна)

(ХЭТТ-ын 3, 5, 8, 9, 11, 12 дугаар зүйл)

Е Хүүхдийг хамгаалах

Хүүхдийн эрхийн тухай конвенцыг судалж, хүүхдийг хамгаалах бүхий л зүйл заалт болон тэдгээр зүйлд дурдсан хүчирхийлэл, мөлжлөгийн нөхцөл байдал, тодорхой хэлбэрийн талаар жагсааж бич.

- Танд нэмэх өөр заалт байна уу?
- Зарим хүүхдүүд бусдаас илүү эмзэг, хамгаалалт шаардлагатай байдаг уу?

Хүүхдийг хамгаалах үүрэг хариуцлагын талаар ярилцаарай:

- Конвенцод зааснаар хүүхдийг хэн хамгаалах үүрэгтэй вэ?
- Конвенцод эдгээр үүрэг хариуцлагыг ямар нэгэн байдлаар эрэмбэлсэн үү?
- Хүүхдийг хамгаалах үүрэг бүхий этгээдүүд үүргээ биелүүлээгүй бол хэрхэх вэ?

Өмнө нь гаргасан жагсаалтыг ашиглан өөрийн улсын хүүхэд хамгааллын талаар судлаарай.

- Танай улсад хүүхдүүд ямар тарлийн онцгой хамгаалалтад байдаг вэ?
- Ямар хүмүүс эсхүл бүлэг тэднийг хамгаалдаг вэ?
- Та болон танай анги энэ хамгаалалтад хувь нэмэр оруулж чадах уу?
- Яагаад хүүхдийн эрхийг хүний эрхийн тухайлсан гэрээнд тусгах шаардлагатай гэж та бодож байна вэ?

(ХЭТК-ын 2, 3, 6, 8, 11, 16, 17, 19, 20, 22, 23, 32, 33, 34, 35, 36, 37, 38 дугаар зүйл)

Дайн, энх тайван ба хүний эрх

Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалыг дэлхийн хоёрдугаар дайны аймшигт үйл явдлын хариу арга хэмжээ болгож бичсэн юм. Тунхаглалын удиртгал хэсэгт “Хүний эрхийг үл тоомсорлох, басамжлах нь зон олны ариун сэтгэлийг сэвтээн жигшээсэн балмад үйлдэлд хүргэсэн” болохыг дурдаад, “Хүн төрөлхтний ам бүлийн гишүүн бүхэнд угаас заяасан нэр төр болон тэдний адил тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь эрх чөлөө, шударга ёс, бүх нийтийн энх тайвны үндэс мөн” гэдгийг онцлон тэмдэглэжээ.

Энх тайван, зэвсэг хураах, хөгжил, хүний эрх зэрэг нь өөр хоорондоо уялдаа холбоотой асуудал юм. Хүний эрхийн төлөөх цогц сургалтын хандлага нь энх тайван, зэвсэг хураах, түүнчлэн хөгжил, байгаль орчны талаарх мэдлэгийг цогц байдлаар сургах явдал юм.

Зэвсэглэлээр хөөцөлдөх, түүнийг хянах оролдлогын талаарх мэдээллийг сурагчдад өгч болно. Дэлхийн хоёрдугаар дайн

дууссанаас хойш 150 гаруй мөргөлдөөн гарсан нь зэвсэгт хүчирхийлэл үргэлжилсээр байгааг харуулж байна. Ангийн сурагчдын түвшнээс хамааран олон улсын улс төр, эдийн засгийн асуудлыг судлах нь энх тайвныг хадгалах зорилт яагаад ийм хэцүү байдаг талаарх ойлголтыг гүнзгийрүүлнэ. Хөгжлийн тэнцвэргүй байдал, экологийн асуудал нь нийтлэг, тогтмол тохиолддог бөгөөд тэдгээр нь өөрсдөө хүний эрхийн зөрчлийг өдөөдөг төдийгүй дайны үрийг тарихад ч нөлөөлдөг. Харин дайн, ялангуяа цөмийн дайн нь бага хэмжээтэй байсан ч байгаль орчны сүйрэлд хүргэж болзошгүй юм.

А Энх тайван



Боломжтой бол дулаахан өдрийг сонго. “Орон нутгийн зөрчилдөөн, дайны аюул заналхийлсэн дэлхийд энх тайван яагаад чухал гэж та бодож байна вэ?” гэсэн асуултыг асуугаад сурагчдыг гадаа гаргаж, аятайхан сайхан газар аваачна. Хүн бүр юу ч ярихгүй дээшээ харан хэвтэж, ойролцоогоор гурван минутын турш нүдээ анина. Хичээлээ үргэлжлүүлж, энх тайвны үндсэн үнэ цэний талаар ярилцана.

Тэгээд «энх тайван»-ыг та нар юу гэж тодорхойлох вэ? Энх тайван ба хүний эрхийн хооронд ямар харилцан хамаарал байгаа вэ? гэсэн асуултыг асууна.

(ХЭТТ-ын 1, 3, 28 дугаар зүйл; ХЭТК-ын 3, 6 дугаар зүйл)

В Дээд хэмжээний уулзалт

Суралцагчид дэлхийн улс орнуудын удирдагчдын дүрд тоглож хүний эрхийн онцгой чухал асуудал, тухайлбал явган цэргийн эсрэг газарт тэсрэх бөмбөг булж ашиглахыг хориглох, хүүхдийг аюултай хөдөлмөрөөс хамгаалах зэрэг сэдвийн хүрээнд дээд хэмжээний уулзалт зохион байгуулна. Тухайн сэдвийн дагуу ангид мэтгэлцээн өрнүүлж, бүлгүүд оролцож байгаа улс орнуудаар хамтран ажиллана: зарим бүлэг дээрх асуудлыг хориглохыг оролдож, зарим бүлэг хориглохоос татгалзана. Боломжтой бол Газрын минийг хориглох Оттавагийн конвенц (1997) эсвэл Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг хориглох тухай конвенц (Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 1999 оны 182 дугаар конвенц)-ын хэлэлцүүлгийг харьцуулж үзээрэй. Улс орнууд, хүмүүс бид бүгдээрээ энх тайвнаар зэрэгцэн амьдрах боломжийг олгох замаар хамтран ажиллаж чадна гэдгийг онцлон тэмдэглээрэй (НҮБ-ын загвар хуралдааныг өөр хэлбэрийг доорх дасгал ажлаас үзнэ үү.)

(ХЭТТ-ын 28 дугаар зүйл; ХЭТК-ын 3, 4, 6, дугаар зүйл)

С Цүнхээ багла

Дайн болон дарангуйллын нийтлэг үр дагаврын нэг нь дүрвэгсэд буюу “арьс үндэс, шашин шүтлэг, үндэс угсаа, нийгмийн тодорхой бүлгийн гишүүнчлэл, улс төрийн үзэл бодлын улмаас хавчигдах үндэслэл бүхий айдас”-аас болж эх орноосоо дүрвэсэн хүмүүс юм (Дүрвэгсдийн эрхийн тухай конвенцын 1.А.2 дугаар зүйл, 1951).

Дараах тохиолдлыг уншина уу:

Та бол багш. Таны хамтрагч алга болж, дараа нь алагдсан болохыг олж мэдсэн. Сонинд нийтлэгдсэн сэжиг бүхий хорлон сүйтгэгчдийн жагсаалтад таны нэр гарсан. Дараа нь улс төрийн үйл ажиллагаа явуулсан гэх шалтгаанаар таны амь насанд заналхийлсэн захидал хүлээн авсан. Та зугтах ёстой гэж шийднэ. Цүнхээ багла. Та цүнхэнд авч явах боломжтой зөвхөн таван төрлийн зүйл (жишээ нь: ариун цэврийн хэрэглэл, хувцас, гэрэл зураг)-ийг авч болно. Энэхүү шийдвэрийг гаргахад танд ердөө таван минут байна. Та эх орондоо хэзээ ч буцаж ирэхгүй гэдгийг санаарай.



Хэд хэдэн сурагчаас жагсаалтаа уншихыг хүснэ. Хэрэв суралцагчид сонины нийтлэл эсвэл заналхийлсэн захидлыг орхисон бол (шинэ улсын эрх баригчдад “хавчигдан мөшгөгдсөний улмаас хавчигдах үндэслэл бүхий айдас”-аас зугтаж байгаагийн цорын ганц тодорхой нотолгоо) «Орогнол олгохоос татгалзсан» гэж хэлээрэй. Ийм цөөн хэдэн тохиолдлын дараа дүрвэгсдийн тодорхойлолт, хавчлагад өртсөнийг нотлохын ач холбогдлыг тайлбарлана. Сэтгэл түгшсэн нөхцөл байдалд сэтгэл хөдлөлийн шийдвэр гаргах нөхцөл байдлын талаар ярилцаарай.

Дэлхий дээрх дүрвэгсдийн судалгаа:

- Дүрвэгсдийн хамгийн их төвлөрөл хаана байна вэ?
- Тэд хаанаас, яагаад зугтаж байна вэ?
- Тэднийг хэн анхааралдаа авах үүрэгтэй вэ?

(ХЭТТ-ын 14 дүгээр зүйл; ХЭТК-ын 22 дугаар зүйл)

D Хүүхэд цэрэг

Дэлхийн зарим улсад арав нас хүрээгүй охид, хөвгүүдийг цэрэгт татдаг. Ихэнхдээ тэдгээр хүүхдүүдийг хулгайлж, хүчээр энэ аюултай ажилд татан оруулдаг бөгөөд улмаар нас барах, тахир дутуу болох, гэр орон, нийгмээс нь хөндийрөхөд хүргэдэг. Хүүхдийн эрхийн тухай конвенцын нэмэлт протоколд (2000) хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд татан оролцуулахыг хориглосон бол Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай конвенцод (1999) нэгэн адил хориглосон.

Хэлэлцэх асуудал:

- Зэвсэгт хүчнүүд яагаад хүүхдийг дайнд ашиглахыг хүсдэг вэ?
- Эдгээр хүүхдүүдийн хүний ямар эрх зөрчигдөж байна вэ? Хүүхдийн эрхийн тухай конвенцын тодорхой зүйл заалтуудыг иштатна уу.
- Хүүхэд цэрэг байх нь охид, хөвгүүдэд хэрхэн ялгаатай байж болох вэ?
- Хэрэв тэдгээр хүүхдүүд амьд үлдэж, гэр бүлдээ эргэн ирвэл тэдэнд ямар бэрхшээл тулгарч болох вэ? Богино хугацаанд? Урт хугацаанд?

Суралцагчид уг асуудлыг цаашид судлах, үйл ажиллагаа явуулах зарим арга замуудыг дурдав:

- Дэлхийн өөр газруудад байгаа хүүхдүүдийн талаар илүү ихийг олж мэдэх;
- Цэргийн алба хааж байсан хүүхдүүдийг дахин нийгэмшүүлэх чиглэлээр ямар байгууллагууд ажиллаж байгааг олж мэдэх, тэдэнд дэмжлэг үзүүлэх;
- Хүүхдийн эрхийн тухай конвенцод хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд татан оролцуулахыг хориглосон нэмэлт протоколыг соёрхон батлахыг Засгийн газарт уриалсан захидал бичих.

(ХЭТТ-ын 3, 4, 5 дугаар зүйл;

ХЭтК-ын 3, 6, 9, 11, 32, 34, 36, 37, 38, 39 дүгээр зүйл)

Е Хүмүүнлэгийн эрх зүй

Олон улсын хүний эрхийн хуулийн нэгэн адил хэрэгждэг эрх зүйн тогтолцоо бол олон улсын хүмүүнлэгийн эрх зүй юм. 1949 оны Женевийн конвенцотусгагдсан “дайны дүрэм” гэж нэрлэгддэг эдгээр дүрэм нь шархадсан, өвчтэй, хөлөг онгоц сүйрсэн цэргүүд, дайнд олзлогдогсод, дайны бүс эсвэл дайсны эзлэн түрэмгийлэлд амьдарч буй энгийн иргэдийг хамгаалах хэм хэмжээг тогтоодог. Дэлхийн олон улс орны цэргийн хүчин нь Женевийн конвенцын дагуу зэвсэгт хүчнээ сургадаг бөгөөд Олон улсын Улаан загалмайн хороо (ОУУЗХ) нь олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн мэдлэг олгох, зэвсэгт мөргөлдөөний үед хүмүүнлэгийн тусламж үзүүлэх чиглэлээр олон улсад тэргүүлдэг.

Гэвч орчин үеийн дайны бодит байдал ихээхэн өөрчлөгдсөн. Дайнд оролцогч тал нь зөвхөн дайтагч улс орнуудын арми (олон улсын зэвсэгт мөргөлдөөн) төдийгүй босогчдын арми, алан хядагчид эсвэл өрсөлдөж буй улс төр, угсаатны бүлгүүд (олон улсын бус

зэвсэгт мөргөлдөөн) болж байна. Цаашлаад, хохирогчдын дийлэнх нь цэргүүд байхаа больж энгийн иргэд, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүд, өндөр настангууд болж байна.

Хүний эрхийн тогтолцоо, олон улсын хүмүүнлэгийн эрх зүй нь олон талаараа бие биенээ бэхжүүлдэг. Тухайлбал, эдгээрийн аль аль нь цэрэгт татагдсан хүүхдүүдэд онцгой анхаарал хандуулж, зэвсэгт мөргөлдөөний нөхцөлд хүүхдүүдийг тусгай хамгаалалтад авах шаардлагатай болохыг хүлээн зөвшөөрдөг.

Дайны нөхцөлд хүний эрх, хүмүүнлэгийн эрх зүй хэрхэн хэрэгждэг талаар дэлгэрүүлэн олж мэдээрэй:

- Олон улсын Улаан загалмай, Улаан хавирган сар хөдөлгөөний түүх, Женевийн конвенцуудыг судлах. 1949 оны анхны Женевийн конвенцуудыг орчин үеийн дайны нөхцөл байдалд хэрхэн тохируулсан бэ?
- Олон улсын Улаан загалмайн нийгэмлэгийн дайны хохирогчдод үзүүлэх хүмүүнлэгийн үйл ажиллагааны талаар олж мэдэх. ОУУЗХ-ны үндсэн долоон зарчмыг (хүмүүнлэг, шударга байдал, төвийг сахисан байдал, бие даасан байдал, сайн дурын байх, нэгдмэл байх, түгээмэл байдал) Түгээмэл тунхаглалын зарчмуудтай харьцуул.
- Хүүхдийн эрхийн тухай конвенц, 1949 оны Женевийн конвенц (Дайны үеийн энгийн иргэдийг хамгаалах тухай Женевийн конвенц) болон 1977 оны нэмэлт протоколуудын дайны нөхцөлд байгаа хүүхдүүдэд зориулсан заалтуудыг харьцуулаарай. Олон улсын хүний эрхийн эрх зүй, олон улсын хүмүүнлэгийн эрх зүй нь хүүхдийг хамгаалахад яагаад хэрэгтэй вэ?
- Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд татан оролцуулахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцын Нэмэлт протокол болон Женевийн конвенцын нэмэлт I протоколын 77 дугаар зүйлийг харьцуул. Аль нь илүү үр дүнтэй вэ? Аль аль нь хэрэгтэй юу? Арван таван настай хүүхэд цэргийн алба хаах насанд хүрсэн гэдэгтэй та санал нийлэх үү?
- Өнөөдөр дэлхий дахинд болж буй зэвсэгт мөргөлдөөний талаарх мэдээллүүдийг шалгана уу. Энэ мөргөлдөөнд Женевийн конвенцууд хэрэгжиж байна уу? ХЭТТ үйлчилж байна уу?

(ХЭТТ-ын 5, 9, 10, 11, 12, 13, 14, 21 дүгээр зүйл, ХЭТК-ын 3, 6, 22, 30, 38, 39 дүгээр зүйл)

Төр ба эрх зүй

Хүний эрх бол хүн бүрд угаас заяагдсан эрх юм. Бид эрхийг хуулиар тогтоосон эсэхээс үл хамааран ёс суртахууны шаардлага тавьж болно. Тухайлбал, амьд явах эрхийг хуулиар баталгаажуулаагүй байсан ч хүн бүр амьд явах эрхтэй.

Гэхдээ хууль тогтоомж нь ёс суртахууны шаардлагыг хууль ёсны болгодог. Эрхийг хуульчилсан улс орнуудад эдгээр хууль бүрэн хэрэгжиж байгаа эсэхийг мэдэх шаардлагатай. Харин ёс суртахууны шаардлагыг хууль ёсны эрх болгон хувиргах нь эхний чухал алхам юм.

Хууль нь боловсролын чухал нөлөөтэй байж болно. Хууль нь нийгмийн зүгээс юу хийхийг зөв гэж үзэж байгааг тодорхойлохын зэрэгцээ батлах ёстой хэмээн үзэж буй стандартуудын тодорхой илэрхийлэл болдог. Хууль бүгдэд ойлгомжтой байж, бүхий л хүнд тэгш үйлчлэх бөгөөд зарчмын хувьд удирдагчдаас дээгүүр хүчин чадалтай байх шаардлагатай.

А Зөвлөл ба шүүх



Хууль тогтоомжийг үндэсний хууль тогтоох байгууллагууд баталдаг. Суралцагчид эдгээр асуултад хариулахын тулд хууль боловсруулах үйл явцын талаар өөрсдөө олж мэдсэн байх шаардлагатай.

“Хууль” гэж юу вэ?

- Тэдгээрийг өргөн барьж баталдаг вэ?
- Яагаад? Юуны учир?

Суралцагчдыг орон нутгийн эсхүл парламентын танхимд анги хамт олноороо очиж танилцах үйл ажиллагааг зохион байгуулж болно. Ингэснээр тэд парламентын гишүүдийг ажил дээр нь харах боломжтой болно. Дээрх гурван асуултын талаар ярилцаарай. Үүний нэгэн адил, шүүхийн байгууллагатай танилцах аяллыг зохион байгуулна. Ингэснээр хуулийг хэрхэн сахиулж байгааг төдийгүй цаашдын шийдвэрт шууд болон шууд бусаар нөлөөлж болох хууль эрх зүйн жишгийг тогтоосон шийдвэрүүд хэрхэн гарч байгааг харах боломжтой болно.

Санал болгож байгаа байгууллагын үйл ажиллагаатай танилцах аяллыг зохион байгуулах боломжгүй, эсхүл зохион байгуулах боломжтой байсан ч цаг үеийн зарим нэгэн асуудлаар мэтгэлцээн зохион байгуулахын тулд парламентын загвар хуралдаан, эсхүл орон нутгийн болон үндэсний хэмжээнд гарсан маргаанаар шүүхийн

загвар хуралдааныг зохион байгуулна. Сурагч нарт өөрт тохирох жишээ олоход нь дэмжлэг үзүүлээрэй.

Олон улсын хэмжигдэхүүнийг танилцуулахын тулд багш нар НҮБ-ын шийдвэр гаргах үйл явц болон одоо хэлэлцэж буй асуудлуудын талаар ангийн суралцагчдаар судалгаа хийлгэх боломжтой. Тэд мөн олон улсын комисс, шүүх, шүүхэд гаргасан зарим хэргийг тоймлон үзэж болно. (Олон улсын эрүүгийн шүүхийн үйл ажиллагааг доорх хэсгээс үзнэ үү.)

Түүнчлэн дээр асуусан гурван асуултад болон дараах гурван асуултын талаар ярилцахаар орон нутгийн улс төрийн зүтгэлтнийг ангидаа урьж болно.

- Яагаад хуулийг дагаж мөрдөх ёстой вэ?
- “Шударга ёс” хэрхэн хэрэгждэг вэ?
- Төрийн үйл ажиллагаа болон хуульд “шударга ёс” хэрхэн зорилгоо хангадаг вэ?

Хүүхдийн эрхийн тухай конвенцын 12 дугаар зүйлд заасан хүүхэд өөрт хамаатай асуудлаар санал бодлоо илэрхийлэх эрхийг авч үзнэ. Уг эрхийг танай улсын шүүх хүлээн зөвшөөрсөн үү? хэрхэн?

Хэлэлцэх асуудал:

- Эмэгтэйчүүдэд хуулийн өмнө эрх тэгш байх боломжийг олгосон уу?
- Танай улсад хэчнээн эмэгтэй хуульч мэргэжилтэй вэ? Хэдэн эмэгтэй шүүгч байдаг вэ? Орон нутгийн эсвэл үндэсний хууль тогтоох байгууллагад хэдэн эмэгтэй хууль тогтоогч байдаг вэ?



- Эдгээр тоо нь эмэгтэйчүүдийн хуулийн хамгаалалтад хэрхэн нөлөөлж байна вэ? (Хуулийн өмнө тэгш байдал ба шийдвэр гаргах үйл ажиллагааг доороос үзнэ үү).

**(ХЭТТ-ын 7, 8, 10, 12, 21, 40 дүгээр зүйл;
ХЭТК-ын 12, 40 дүгээр зүйл)**

В Шүүхийн төрөл

Ангийг албан бус шүүх болгон зохион байгуулснаар хууль сахиулах үйл явцад суралцаж болно. “Маргагч талууд” ангийн төв хэсэг буюу голд нь сууж, зарим суралцагч “найз нөхөд”, “гэр бүл”-ийн гишүүн мэт тэдэнтэй ойр байж, харин бусад нь “тосгон” мэт тойрон сууж болно. Тойрогт сууж байгаа хэн нэгнийг хөндлөнгийн шүүгчээр томилно. Тэр нь орон нутгийн иргэд хөндлөнгийн хүний саналыг авахыг хүссэн үед ажиллана. Маргагч талууд асуудлаа ээлжлэн тавьж, хүн бүр өөрийн санал бодлоо илэрхийлэх боломжийг олгоно. Зөвшилцөлд хүрэх хүртэл хэлэлцүүлгийг үргэлжлүүлэх ёстой.

Шийдвэрлэх асуудлыг суралцагчдын тусламжтайгаар багш өөрөө сонгож болно. Дараа нь «хууль» энэ тохиолдолд албан болон албан бус хэлбэрээр хэрхэн хэрэгжсэн талаар ярилцана. Хэн нэгнийг заавал буруутгах шаардлагагүй гэдгийг тайлбарлана, ялангуяа маргагч тал бүр үндэслэлтэй санал дэвшүүлсэн нөхцөлд буруутгах шаардлагагүй.

(ХЭТТ-ын 8, 10 дугаар зүйл; ХЭтК-ын 3, 12 дугаар зүйл)

С Хуулийн өмнө эрх тэгш байх

Түгээмэл тунхаглалын 7 дугаар зүйл «Хуулийн өмнө бүгд адил тэгш ...» хэмээн эхэлдэг. Гэвч энэхүү зарчмын мэдэгдэл практикт тэр бүр хэрэгждэггүй.



Хэлэлцэх асуудал:

- Танай улсад бүгд хуулийн өмнө тэгш эрхтэй юу эсвэл зарим хүмүүст өөрөөр ханддаг уу?
- Ямар хүчин зүйл зарим хүнд бусдаас давуу байх боломжийг бүрдүүлдэг вэ?
- Хуулийн өмнө эрх тэгш байх нь хүний эрхийн соёлд яагаад зайлшгүй шаардлагатай вэ?

(ХЭТТ-ын 7 дугаар зүйл; ХЭтК-ын 2 дугаар зүйл)

Д “Хүний эрх”-ийн баримт бичгийг харьцуулах⁹

Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал зэрэг олон улсын баримт бичиг төдийгүй улс орнуудын үндсэн хууль зэрэг бүс нутгийн, үндэсний болон орон нутгийн хууль тогтоомжоор баталгаажуулдаг болохыг онцлон тэмдэглээрэй. Суралцагчдад ХЭТТ болон НҮБ-ын хоёр

⁹ Adapted from Teaching Human Rights by David Shiman (Center for Teaching International Relations Publications, University of Denver, 1998).

Пактын хуулбарыг өгч, тус бүр нь дараах эрхийг агуулж байгаа эсэхийг харьцуулж, холбогдох зүйл(үүдийг) тодорхойлохыг хүсээрэй.

1. Сурч боловсрох эрх
2. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө (хэвлэл мэдээллийн хэрэгслийг оролцуулан)
3. Эхнэр, нөхрөө чөлөөтэй сонгох
4. Эмэгтэйчүүд, цөөнх зэрэг бүх хүмүүсийн тэгш байдал
5. Хэдэн хүүхэдтэй байхаа чөлөөтэй сонгох
6. Эрүүдэн шүүх, хүнлэг бус харьцахаас ангид байх
7. Үзэл бодол, үзэл санаа, шашин шүтэх эрх чөлөө
8. Өмчлөх эрх
9. Галт зэвсэг эзэмших эрх
10. Зохистой хоол хүнс
11. Шаардлагад нийцсэн орон байр
12. Зохистой эрүүл мэндийн тусламж үйлчилгээ
13. Дотоод болон гадаадад чөлөөтэй зорчих эрх
14. 1Тайван хуран цуглах эрх
15. Цэвэр агаар амьсгалах, цэнгэг ус хэрэглэх эрх

Хэлэлцэх асуудал:

- Ямар ижил төстэй болон ялгаатай шинжийг олж мэдсэн бэ? Эдгээрийг хэрхэн тайлбарлах вэ?
- Танай улсын Үндсэн хууль эсвэл бусад хуулинд ХЭТТ-аас илүү эсхүл цөөн эрхийг тусгасан уу?
- Эдгээр баримт бичгийг зохиогчид "эрх" гэж чухам юу гэсэн утгатай талаар ижил ойлголттой байсан уу?
- Баримт бичгүүдэд эрхээс гадна үүрэг хариуцлага багтаасан уу?
- Танай улсын иргэд Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид тусгагдсанаас гадна өөр эрх эдэлдэг үү?
- Эдгээр хуулиуд хооронд зөрчилдвөл хэрхэх вэ?
- Иргэдийнхээ тодорхой эрхийг хангахад Засгийн газар ямар хязгаарлалт эсхүл үүрэг хүлээх вэ? Тухайлбал, өлсгөлөн, орон гэргүй байх явдалд засгийн газар үүрэг хариуцлага хүлээх үү?
- Жагсаалтад орсон бүх эрхийг төр баталгаажуулах ёстой юу?

(ХЭТТ-ын бүх заалт)

Е Олон улсын эрүүгийн шүүх

1945-1946 онд Нюрнберг болон Токио хотод болсон олон улсын цэргийн шүүх хуралд ялалт байгуулсан холбоотнууд Герман, Японы зарим албан тушаалтнуудыг Дэлхийн II дайнтай холбогдуулан «энх тайвны эсрэг гэмт хэрэг», «дайны гэмт хэрэг», «хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг»-т буруутган ялласан.

Тэр цагаас хойш ийм төрлийн гэмт хэрэг, хүний эрхийг өргөн цар хүрээнд зөрчсөн бусад олон зэвсэгт мөргөлдөөн гарсан. Камбожид Кхмерийн улаан хувцастнууд 1970-аад оны үед 2 сая орчим хүний амь насыг хөнөөсөн. Мозамбик, Либери, Сальвадор болон бусад улс оронд болсон зэвсэгт мөргөлдөөний улмаас олон мянган энгийн иргэн, тэр дундаа маш олон тооны зэвсэггүй энгийн иргэн болох эмэгтэйчүүд, хүүхдүүд амь үрэгдсэн. Гэвч 1990-ээд онд хуучин Югославт мөргөлдөөн дэгдэж, “үндэсний цэвэрлэгээ” гэсэн нэрийн дор дайны гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, төрлөөр устгах гэмт хэрэг дахин олон улсын анхаарлыг татах хүртэл ийм харгис хэрцгий үйлдлүүдийг шүүн хэлэлцэх олон улсын шүүх байгуулах талаарх олон улсын хэлэлцээрт хүрч чадаагүй юм. 1993 онд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл хүний эрхийг системтэйгээр, өргөн хүрээнд зөрчиж байгаа хүмүүсийг яллах, шийтгэх зорилгоор хуучин Югославын олон улсын эрүүгийн шүүхийг байгуулсан. Үүний нэгэн адил 1994 оны 4 дүгээр сараас 7 дугаар сар хүртэл Руанда улсад өрнөсөн 1 сая орчим энгийн иргэдийг төрлөөр устгасан иргэний дайн дууссаны дараа Аюулгүйн зөвлөл Руандагийн олон улсын эрүүгийн шүүхийг байгуулсан.

Хувь хүнд хариуцлага хүлээлгэх олон улсын эрүүгийн шүүхийн механизмгүйгээр төрлөөр устгах, хүний эрхийг балмад зөрчилүүд ихэвчлэн ял шийтгэлгүй үлддэг болохыг түүх гэрчилнэ. Эдгээр шүүх нь дээр дурдсан гэмт хэргийг үйлдэгчдийг тухайн улс нь яллах боломжгүй, эсхүл хүсээгүй тохиолдолд төрлөөр устгах, дайны гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн хэрэгт шийтгэх нэмэлт хэрэгсэл болох боломжтой бөгөөд олон улсын эрх зүйн эсрэг гэмт хэрэг цаашид үйлдэгдэхээс сэргийлнэ.

1998 онд засгийн газрын төлөөлөгчид Ромд болсон дипломат бага хурлын үеэр олон улсын байнгын ажиллагаатай эрүүгийн шүүхийн дүрмийг боловсруулсан. Улмаар 1998 оны 7 дугаар сарын 17-нд Олон улсын эрүүгийн шүүхийн дүрмийг баталсан бөгөөд 120 засгийн газар дэмжиж, 7 нь эсэргүүцэж, 21 нь түдгэлзсэн. Уг дүрмийг 2002 оны 7 дугаар сард 60-аас доошгүй улс соёрхон баталснаар хүчин төгөлдөр болсон бөгөөд эдүгээ Гааг хотод (Нидерланд) Олон улсын эрүүгийн шүүх ажиллаж байна.

Ийнхүү Олон улсын эрүүгийн шүүх байгуулсан нь суралцагчдын анхаарч үзэх, цаашид үйл ажиллагаа явуулах дараах хэд хэдэн чухал асуудлыг бий болгосон.

- Ийм шүүх яагаад хэрэгтэй байна вэ? Энэ нь үр дүнтэй байж чадах уу?
- Олон улсын хамтын нийгэмлэг ямар бүрэн эрхийн хүрээнд улс орны дотоод асуудалд хөндлөнгөөс оролцох вэ?, тухайлбал Засгийн газар иргэдтэйгээ хэрхэн харьцаж байгаа нь дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцож байгаа хэрэг мөн үү? (ангийн үйл ажиллагаа нь Олон улсын байгууллага тухайн улсын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцох эрхтэй эсэх, хэрэв тийм бол хэзээ, ямар тохиолдолд оролцох талаарх хэлэлцэнэ)
- Олон улсын эрүүгийн шүүхийн талаар илүү ихийг олж мэдэх (жишээ нь, үйл ажиллагааны дүрэм, хянан шийдвэрлэх хэргийн төрөл гэх мэт – Шүүхийн албан ёсны вэбсайт нь <http://www.icc.org>). Олон улсын эрүүгийн шүүхтэй хамтран ажиллах Засгийн газрууд ямар үүрэг хүлээх вэ?
- Олон улсын эрүүгийн шүүхийг байгуулахын тулд түүний дүрмийг дор хаяж 60 улс соёрхон батлах ёстой. Одоогоор ямар улс орнууд соёрхон батлаад байгааг олж мэдээрэй. Хэрэв танай улс соёрхон батлагдаагүй байгаа бол соёрхон батлахын давуу болон сул талуудын талаар мэтгэлцээн өрнүүлээрэй. Соёрхон батлах тухай өөрийн байр суурийг шаардаж, өөрийн улсын хууль тогтоогчдод захидал, өргөдөл илгээнэ үү.
- Тухайн үед ийм шүүх байсан бол олон улсын эрүүгийн шүүхэд хандаж болох нөхцөл байдлыг дэлхийн түүхээс судалж мэдэх

(ХЭТТ-ын 7, 10, 11, 28 дугаар зүйл; ХЭТК-ын 3, 40, 41 дүгээр зүйл)

Бодож сэтгэх, үзэл санаа, шашин шүтлэг, үзэл бодол болон түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө

Бодож сэтгэх, үзэл санаа, шашин шүтлэг, үзэл бодол болон түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө нь хүний эрхийн соёлд чухал байр суурь эзэлдэг. Хүүхдийн эрхийн тухай конвенцод эдгээр эрхийг хүүхдийн төлөвшиж байгаа байдлаас нь хамааруулан олгодог (доорх “Төлөвшил, Хэзээ насанд хүрсэн гэж үзэх бэ?” зэрэг



дасгал ажлыг үзнэ үү). Эдгээр эрхэд шашин шүтлэг, итгэл үнэмшлээ өөрчлөх эрх чөлөө; хөндлөнгийн оролцоогүйгээр үзэл бодлоо илэрхийлэх; хил хязгаар харгалзахгүйгээр аливаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл, санаа хайх, хүлээн авах, түгээх эрх хамаарна.

А Тайлбарын хүрээ

Үзэл бодол нь бидний харж байгаа зүйлс бидэнд таалагдаж байгаа эсэхээс хамааран харилцан адилгүй өөр байж болно. Энэ нь бидний үгийн сонголтод илэрдэг. Жишээлбэл, хүнийг «ганцаардмал» эсвэл «бие даасан», «түрэмгий» эсвэл «өөртөө итгэлтэй», «хүлээн зөвшөөрөгдсөн» эсвэл «хамтран ажиллахад бэлэн», «илүү их хүсэл эрмэлзэлтэй» эсвэл «шаргуу хөдөлмөрлөхөөс няцахгүй» гэж тодорхойлж болно. Суралцагчдаас энэ төрлийн бусад өөр бусад эсрэг тэсрэг ангилал хуваагдлын талаар бодохыг хүсээрэй.

Суралцагчдаас өөрсдийнхөө биширдэг таван чанарыг аль болох эерэг байдлаар жагсаахыг хүснэ. Дараа нь тэдгээр зан чанарыг хор хөнөөлтэй сөрөг утгад хувирган орлуулаарай. Үүний дараа эсрэгээр нь эхлээд өөрсдийн таалагддаггүй сөрөг чанаруудыг жагсааж, дараа нь жагсаалтыг доромж утга багатай үгс болгон хувирган бичнэ.

Энэ үйл ажиллагааны өөр нэг хувилбар нь багш сурагчдаас охид хөвгүүдийг ерөнхийд нь дүрсэлсэн нэр үгсийг жагсаахыг хүснэ. Дараа нь хүйсээ өөрчлөх даалгавар өгөөрэй (жишээ нь, хөвгүүний “эрч хүчтэй” эсвэл “амбицтай” гэж тодорхойлсон шинж чанарууд нь охины хувьд “сэхэлзүүр” эсвэл “эрээ цээргүй” гэж тооцогддог).

(ХЭТТ-ын 1, 2 дугаар зүйл; ХЭТК-ны 2 дугаар зүйл)

В Шархлуулах үгс

Хүүхдийн эрхийн тухай конвенцын 13 дугаар зүйлийн 13.2.а-д хүүхдэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг олгосон боловч бусдын эрх, нэр хүндэд халдаж үзэл бодлоо илэрхийлэхийг тухайлан хязгаарласан. Бид өөрсдийн бодож сэтгэж, итгэл үнэмшиж байгаа зүйлийн талаар юу хэлэхээ хязгаарлах шаардлагатай юу? Бид үргэлж дуртай зүйлээ хэлж чаддаг байх ёстой юу? Дараах үйл ажиллагааг багш өөрийнхөө сонголтод тохируулан хийхийг зөвлөж байна.



Хүүхэд бүрд цаас өгөөд сургууль дээр сонссон гомдоосон сэтгэгдлээ тус тусад нь цаасан дээр бичүүлнэ. Эдгээр сэтгэгдлийг “тоглож өгөөдсөн/дэггүйтсэн” болон “Маш их өвтгөсөн/гутаан доромжилсон” хүртэл нь эрэмбэлж эгнээ үүсгэн хананд наана. Суралцагчдаас цаасан дээр бичсэн үгсийг харьяалагдах хэсэгт тогтоож байршуулахыг хүсээрэй (эсвэл нэрсийг нууцлахын тулд багш цаасыг цуглуулж, уншиж болно - суралцагчид дараа нь тэдгээр үгсийг хамаарах хэсэгт байршуулна). Дараа нь хүн бүрээс хананд байгаа үгсийг чимээгүй унжих боломж олгоно.

Ихэвчлэн үгс хэд хэдэн удаа давтагдаж болох ч тухайн хүнд төрүүлсэн сэтгэгдлийн хувьд өөр өөр зэрэгтэй байдаг.

Дараах туршлагыг ярилцаарай: суралцагчдаас үгсийг (жишээ нь, гадаад төрх, чадвар, үндэс угсаа, бэлгийн чиг баримжаа зэргээр) ангилахыг хүснэ.

- Зарим үгс зөвхөн охидод зориулагдсан уу? Хөвгүүдийн хувьд?
- Эдгээр ангиллаас доромжилсон үг хэллэгийн талаар ямар дүгнэлт хийж болох вэ?
- Яагаад зарим хүмүүс тухайн үгийг маш хүндээр өвтгөн хүлээж авч байхад зарим нь хөгжилтэй гэж бодож байна вэ?

Ангийг жижиг бүлгүүдэд хувааж, бүлэг тус бүрд хамгийн их гомдмоор, шархлуулах үгсийг өгнө. Бүлэг бүрийн гишүүн өгөгдсөн үг эсвэл хэллэгийг бусаддаа чангаар уншиж өгнө. Дараа нь бүлгүүд (1) хүмүүст ийм зүйл хэлэхийг зөвшөөрөх эсэх (2) ийм зүйл тохиолдсон үед юу хийх зэргийг хэлэлцээд эдгээр үгсийг шархлуулах үг мөн гэдгийг хүлээн зөвшөөрөх шаардлагатай. Энэ үйлдлээ үг, хэллэг нэг бүр дээр давтана.

Эцэст нь ангиараа доромжилсон үг хэллэгтэй холбоотой эрх, үүргийн талаар суралцагчидтай ярилцана.

- Сургууль дээр үзэн ядсан үг хэллэгийг таслан зогсоох үүргийг багш хүлээх үү?
- Суралцагчид өөрсдийн амьдралд уг үйлдлийг зогсоох үүрэгтэй юу? Хэрэв тийм бол яагаад?
- Үзэн ядалтыг таслан зогсоохын тулд та нийгэмдээ юу хийж чадах вэ?
- Ингэх нь яагаад чухал вэ?

(ХЭТТ-ын 1, 2, 18, 19 дүгээр зүйл; ХЭТК-ын 12, 13, 14, 16, 17, 29 дүгээр зүйл)

С Төлөвшил

Хүүхдийн эрхийн тухай конвенц нь хүүхдийн төлөвшлийн байдлыг харгалзан бодож сэтгэх, үзэл санаа, шашин шүтэх эрх чөлөөг олгодог. Залуу хүн хангалттай төлөвшсөн бол гэр бүл, соёл, уламжлалаас өөр шашин шүтэх эсвэл улс төрийн үзэл баримтлалыг баримталж болох эсэх талаар суралцагчдыг мэтгэлцэхийг хүсээрэй. Үүнийг хэн шийдэх ёстой вэ?

(ХЭТК-ын 14 дүгээр зүйл)

Хувийн халдашгүй байх эрх

Хүүхдийн эрхийн тухай конвенцын 16 дугаар зүйлд хүүхдийн хувийн нууц, гэр бүл, орон байр, захидал харилцааны нууцад хөндлөнгөөс нөлөөлөх, нэр төр, алдар хүндэд халдах явдлаас хамгаалуулах эрхийг баталгаажуулсан. Гэвч, конвенцод баталгаажуулсан бусад олон эрхийн нэгэн адил түүнийг хэрэгжүүлэх боломж нь хүүхдийн "хөгжиж буй чадавх"-аас хамаарна. Мэдээж долоон настай хүүхэд арван долоон настай хүүхэд шиг эрх, үүрэг хүлээх боломжгүй.



Хэзээ «хангалттай насанд хүрсэн» гэж үзэх вэ?

Дараах түүхийг ангидаа уншина.

Екү, Ромит хоёр бага сургуульд зэрэгцэн сууж байхдаа хоорондоо танилцжээ. Тэд удалгүй хамгийн сайн найзууд болсон ч тэдний нөхөрлөлд асуудал гарсан. Тэдний гэр бүл олон жилийн туршид үл итгэлцсэн нийгмийн хоёр өөр бүлэгт харьяалагддаг байв. Тиймээс

Ромит Экүгийн гэрт очиж болох эсэхийг асуухад эцэг эх нь хоёулаа эрс татгалзав. Экүгийн гэр бүл багштай ярилцаж, найзуудыг салгаж тусад нь суулгав. Гэвч Экүг өөр хотод дунд сургуулиа төгсгөх хүртэл тэдний нөхөрлөл үргэлжилсэн юм. Найзууд захидал бичнэ хэмээн амласан ч Экүгээс захидал ирэх бүрд Ромитийн эцэг эх нь захидлыг уншихаас нь устгадаг байв. Ромит эцэг эхийнхээ сэтгэлийг ойлгож байгаа ч арван зургаан настай тэрээр найз нөхдөө сонгох насанд хүрсэн бөгөөд захидал харилцаагаа нууцлах эрхтэй гэж боддог.

Хэлэлцэх асуудал:

- Хүүхдийн эрхийн тухай конвенцын дагуу Ромит ямар эрхтэй вэ?
- Ромитийн “хөгжиж буй чадавхыг” хэрхэн тодорхойлох вэ?
- Ромитийн эцэг эх ямар эрхтэй вэ? Энэ зөрчилдөөнийг хэрхэн шийдвэрлэх талаар стратеги боловсруул.

(ХБНЭ-ийн 12 дугаар зүйл; ХХЗХ-ны 5, 16 дугаар зүйл)

Зөвлөлдөх, нийтийн үйл хэрэгт оролцох эрх чөлөө



Нийгмийн бүлгүүд хэрхэн оршин байж, хөгждөг вэ? Нийгмийн гишүүд цуглаж, өөрсдөө зохион байгуулалтад орох зэргээр нийгэм хөгждөг. Эдгээр эрх чөлөө нь нийтийн оролцоог чухалчилдаг. Нийтийн үйл хэрэгт оролцох эрх чөлөөг үгүйсгэх нь нийгмийг хамгийн баялаг нөөцийн нэг болох хүмүүсийн ур чадвар, авьяас чадварыг үнэгүйдүүлэх болно.

Суралцагчийн нийтийн оролцооны дадал нь сургуульд суралцах бүхий л хугацааны туршид төлөвшинө. Мөн сургуулиас гадуур олон нийтэд тустай ажил хийх боломж нь нийгэм, улс төрийн үйл хэрэгт насан туршдаа хувь нэмэр оруулах үндэс суурь нь болдог. Хэдийгээр практикт суралцагчдын үйл хэргийг насанд хүрэгчид хязгаарладаг боловч ихэнх сургуульд суралцагчид өөрсдийн үйл хэрэгт оролцох боломжийг олгодог сурагчдын зөвлөл байдаг

Хүний эрхийн клуб

Хүний эрхийг дэмжих ангийн клуб байгуулах нь ямар нэгэн үнэ цэнтэй зүйлийн төлөө хамтран ажиллах шууд туршлага уримтлуулах боломжийг олгодог.



Багш нар ийм төрлийн клубыг бий болгоход чиглэсэн хэд хэдэн ажлыг санаачлан эхлүүлж болно.

- Хүний эрхийн клубын зорилгыг илүү нарийвчлан тодорхойлох;
 - Клубын бэлгэдлийг бий болгох тэмцээн зохион байгуулах;
 - Энэхүү бэлгэдэл бүхий гишүүнчлэлийн карт хийх;
 - Чиг үүргийг зохион байгуулах;
- Хүний эрхийн клубын үйл ажиллагаанд тухайлан зориулсан самбар байрлуулах;
 - Үндэсний болон олон улсын хүний эрхийн сүлжээ, клубтэй харилцах байгууллагуудын талаар олж мэдэх; тэдний хэвлэлийг асууж, эдгээрийг хүмүүс ашиглах боломжтой газарт харагдахуйц байрлуулах;
 - тогтмол хурал зохион байгуулж эхлэх — эхлэлийн сэдэв болгож эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний тухай ярилцаж болно: «Яагаад эвлэлдэн нэгдэх үйл ажиллагааг зохион байгуулах ёстой вэ? Орон нутаг, үндэсний болон бусад нийтийн үйл хэрэгт оролцох нь яагаад чухал вэ?»
 - Зочин илтгэгчдийг (жишээ нь, орон нутгийн улс төрчид, тухайн тухайн асуудлаар ажилладаг мэргэжилтнүүд, бүсийн мэргэжилтнүүд) урьж, богино хэмжээний илтгэл тавьж, хэлэлцүүлэг өрнүүлэх;
 - Дэд хороодыг хуралдуулж, тодорхой асуудлыг талаар судлах;
 - 12 дугаар сарын 10-нд Олон улсын хүний эрхийн өдрийг тэмдэглэх; хүний эрхийн холбогдолтой бусад олон улсын өдрүүдийн талаар мэдээлэл авч, тэмдэглэн өнгөрүүлэх.¹⁰

Бүлэг нь бусад ангиудтай холбоо тогтоож хүний эрхийн тодорхой асуудлууд/салбарын талаар ярилцах, клуб яагаад байгуулагдсан, юу хийдэг талаар тайлбарлах, мөн гишүүн болох санал тавьж болно; Хэрэв нөөц боломжтой бол Клуб тогтмол мэдээллийн товхимол гаргаж болно.

(ХЭТТ-ын 20, 21 дүгээр зүйл; ХЭтК-ын 15 дугаар зүйл)

¹⁰ For practical ideas, see "More than 50 Ideas for Commemorating the Universal Declaration of Human Rights", available at <http://www.ohchr.org> or through the Office of the United Nations High Commissioner for Human Rights. A list of International Days is also available on the web site or through the Office.

Нийгэм болон соёлын сайн сайхан байдал



Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, Хүүхдийн эрхийн тухай конвенцод амрах, сурч боловсрох, чөлөөтэй шүтэн бишрэх, нийгмийн соёлын амьдралд чөлөөтэй оролцох, өөрийгөө бүрэн дүүрэн хөгжүүлэх эрхийн талаар заасан байдаг. Сургууль нь суралцагчдад өөрийн бүс нутаг болон дэлхийн урлаг, шинжлэх ухааны талаар мэдэх, холбогдох боломжийг олгож, хүүхдийн соёлын өвөрмөц байдал, хэл, үнэт зүйлс, түүнчлэн бусдын соёлыг хүндэтгэх ёстой. Түүнчлэн сургуулиуд янз бүрийн түүхэн цаг үеийн олон талт соёлын жишээн дээр хүний эрхийн асуудлыг заах ёстой.

Хувь хүний болон нийгмийн сайн сайхан байдлын ихэнх мэдрэмжийг гэр бүлээс олж авдаг. Гэр бүлүүд нь ганц бие насанд хүрэгчдийн нэгжээс эхлээд бүхэл бүтэн бүлгийг хамарсан өргөн хүрээний ураг төрлийн систем бүхий гишүүдийн амьдралын соёл, эдийн засгийн хамгийн их хамааралтай хэлбэрийг өөртөө шингээдэг. Хүүхдийн эрхийн тухай конвенцын 18 дугаар зүйлд эцэг эх хоёулаа хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх үндсэн үүргийг хүлээн зөвшөөрсөн бол 20 дугаар зүйлд гэр бүлгүй хүүхдийг өөр гэр бүл эсвэл байгууллагад тусгайлан хамгаалах талаа заасан байдаг.

Сургуулийн сургалтын хөтөлбөрийн ихэнх үйл ажиллагаа энэ сэдэвтэй холбоотой байдаг. Иймээс хэлэлцүүлгийг боловсролын үйл явцаас эхэлж болох юм. Боловсрол (сургуулийн боловсролоос ялгаатай нь) бол насан туршийн асуудал бөгөөд иж бүрэн цогц ойлголт юм. Учир нь тухайн соёл устан үгүй болоогүй л бол үе бүрийн соёлыг дахин сурах ёстой. (Соёлын тодорхойломж хэсгийг харна уу.)

А Эрт нэгэн цагт ...

Ахмад настнуудыг урьж тэд багадаа юу сурч мэдэж байсан, эдгээр нь тэдний амьдралд хэрхэн хэрэг болсон талаар суралцагчидтай ярилцана. Хүүхдийн эрхийн тухай конвенцоор баталгаажсан ямар эрх тэднийг бага байхад дутагдаж, үгүйлэгдэж байсан бэ?

Суралцагчдаас хүний хувийн шинж чанарыг бүрэн дүүрэн хөгжүүлэхэд хэрхэн төлөвшүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх талаар юу сурсан, нийгмийн янз бүрийн бүлгүүд, үндэстнүүдийн

хоорондын ойлголцол, харилцан хүндэтгэлийг хэрхэн хөгжүүлэх, шударга ёс, энх тайвныг юу болгодог талаар асуугаарай.

(ХЭТТ-ын 19, 27 дугаар зүйл; ХЭтК-ын 29, 31 дүгээр зүйл)

В Гэр бүлийн холбоосыг зургаар илэрхийлэх

Суралцагчдаас өөрсдийн гэр бүлийнхээ яг өнөө цаг үеийн байдлаар гэр бүлийн холбоосыг бичүүлээрэй (Хэрэв ангид үрчлэгдсэн хүүхэд байгаа тохиолдолд мэдрэмжтэй байх ёстой). Дараах асуудлыг харьцуулан авч хэлэлцэнэ :

- Тэдний гэр бүлийн амьдрал элэнц өвөө эмээгийн амьдралаас юугаараа ялгаатай вэ? Тэдний өвөө эмээ? Тэдний аав ээж?
- Эдгээр өөрчлөлтүүд юунаас үүдэлтэй вэ? Тэдгээр нь үнэт зүйл, соёл, технологи эсвэл бусад төрлийн өөрчлөлт үү? Аль нь үр ашигтай, аль нь үр ашиггүй вэ?
- үр хойч буюу өнөө үеийн гэр бүлийн гишүүдийн хүний эрх өмнөх үеийнхнээс сайжирсан уу?

(ХЭТТ-ын 16, 19, 27 дугаар зүйл; ХЭтК-ын 5, 29, 31 дүгээр зүйл)

Ялгаварлан гадуурхалт



Хэн ч бусдаас илүү биш, мөн хэн ч бусдаас дутуу биш. Үндсэндээ бид бүгд эрх тэгш, хүн бүр хүүний эрхийг эрх тэгш хүртэх эрхтэй.

Бид эрх тэгш ч яг адилхан биш — энэхүү факт нь хүмүүсийг хүний газрын зурагт хувааж, өөрсдийн чухал гэж үзсэн ялгаатай байдалдаа анхаарал хандуулахад хүргэдэг. Хэрэв хүмүүсийг бүлгээр нь хуваагаад зогсохгүй арьс үндэс, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодол, үндэстэн, нийгмийн гарал үүслээр

нь нэг бүлгийг илүүд эсвэл дорд үздэг шугам тогтоогдсон бол энэ нь ялгаварлан гадуурхалт юм.

Жендэр бол ялгаварлан гадуурхах хамгийн түгээмэл үндэслэлүүдийн нэг юм. Энэ нь бидний төрөл зүйлийн биологийн эсрэгцүүлэх ангилалтай давхцаж байгаа нь бидний онцлог байдлын талаарх гүн гүнзгий ялгааг олж харахад хэцүү болгодог байж болох юм. Зөвхөн зарим шинжээрээ ялгаатай байгаа нь биднийг бүх талаараа ялгаатай гэж үзэх үндэслэл болохгүй. Өөр өөр зориулалттай биеийн хэсэгтэй байна гэдэг нь бидний хүний эрх бас өөр байх ёстой гэсэн үг биш.

Ялгаварлан гадуурхалын өөр нэг хор хөнөөлтэй хэлбэр бол арьсны өнгө, арьс үндсээр ялгаварлах юм. Тодорхой ялгаатай байдалд хэт их ач холбогдол өгч онцлох нь хүн төрөлтхтний нийтлэг шинж чанарыг улам үгүй хийдэг.

Ямар ч багш ялгаварлан гадуурхах асуудлаас зайлсхийж чадахгүй. Эрх тэгш байдал, амьдрал-боломж, амьдрал- сонголт нь зүгээр ч нэг тохиолддоггүй. Иймд энэ талаарх хичээлийг заахдаа зөвхөн хэвшмэл хандлага, өрөөсгөл ойлголтыг судлах төдийгүй суралцагчдад мэдлэгтэй, чадвартай, халамжтай байж чадна гэдгийг ойлгуулж, зохих, үнэн зөв мэдээллийг өгөх шаардлагатай.

Энэ бол тасралтгүй үргэлжлэх асуудал, үйл явц юм. Нийгэм-эдийн засаг, улс төрийн нөхцөл байдал хэрхэн уялддаг талаар мэдээлэлтэй байх нь чухал. Гэхдээ багш нар өөрсдөдөө төдийгүй бүх хүмүүст байдаг өрөөсгөл ойлголт, ялгаварлан гадуурхах хандлагыг мэддэг байх нь хамгийн чухал юм. Багш нэг бүр өөрийгөө шалгах амаргүй үүрэг хариуцлага хүлээдэг, учир нь багш нар өрөөсгөл үзлийг хүлээн зөвшөөрвөл тэдгээр үзэл нь амь бөхтэй үлдэж, залуу үеийнхэнд нөлөөлөх болно.

1. Ялгаварлан гадуурхалт – хэвшмэл ойлголт

Хэвшмэл ойлголтын талаар ярихдаа түүний эсрэг ойлголтыг дэмжих аюул байгааг онцлон тэмдэглээрэй. Хэвшмэл ойлголтод байдаг үнэн гэж итгэж байгаа шинж нь зүгээр л нэг шинж гэдгийг сайтар тайлбарлана. Эсвэл ангийнхнаас “Тэд бүгд адилхан, тийм биш гэж үү” эсвэл “Тэдгээр олон зүйл бүгдээрээ адилхан» гэх мэт хэллэгийг сонсож байсан тохиолдлын талаар асуу.

А Тэд бүгдээрээ л адилхан

Суралцагч бүрд жижиг чулуу эсвэл төмс гэх мэт энгийн зүйл өгөөд, тэдэнтэй «найзууд» болохыг хүсээрэй. Цөөн хэдэн хүүхдээс «найз»-ыгаа ангидаа танилцуулж, хэдэн настай, гунигтай эсвэл баярласан эсэх, эсвэл ямар хэлбэр дүрстэй болсон тухай түүхийг ярихыг хүсээрэй. Тэд энэ сэдвээр эсээ, дуу эсвэл шүлэг бичиж болно. Дараа нь бүх зүйлийг хайрцаг эсвэл уутанд хийж, холино. Тэгээд суралцагчдаас өөрсдийн «найз»-аа уутнаас олохыг хүсээрэй.

Ижил төстэй байдлыг онцол: аль ч бүлэг хүмүүс эхэндээ ижил төстэй мэт санагддаг, гэхдээ та тэднийг таньж мэдсэний дараа тэд бүгд өөр, тэд бүгд амьдралын түүхтэй бөгөөд тэд бүгд найз нөхөд

байх магадлалтай. Энэ нь аливаа хэвшмэл ойлголтыг («чулуунууд хүйтэн, хатуу» гэх мэт) таньж мэдэхэд хангалттай хугацаа олгоно гэсэн үг юм.

(ХЭТТ-ын 1, 2 дугаар зүйл; ХЭтК-ын 2 дугаар зүйл)

В Ялгааг тодорхойлох

Дараах бодомжийг танилцуулна.

1. Эмч нар үргэлж сайхан сэтгэлтэй байдаг учраас би тэдэнд дуртай.
2. Зарим эмч надад эелдэг ханддаг нь таалагддаг.
3. Эмч нар их эелдэг хүмүүс.

Аль нь хэвшмэл ойлголт (№ 3), аль нь өрөөсгөл ойлголт (№ 1), аль нь үзэл бодлоо илэрхийлэх (№ 2) болохыг ярилц. Бүх гурван бодомж (сэтгэл зүйн хүрээний хувьд) эмч нарыг зөвхөн эелдэг, халамжтай хүмүүс төдийгүй уур уцаартай, тэвчээргүй хүмүүс хэмээн үнэлэхэд хэрхэн хэцүү болохыг онцол! Хэвшмэл ойлголт, өрөөсгөл ойлголт, үзэл бодол зэрэг хандлага хэрхэн урьдчилан тодорхойлогддог талаар ярилцаарай.

(ХЭТТ-ын 2 дугаар зүйл; ХЭтК-ы 2 дугаар зүйл)

2. Ялгаварлан гадуурхалт – арьсны өнгө, үндэс угсаа

Арьсны өнгө, үндэс угсаагаар бусдаас давуу эсвэл дор (ихэвчлэн бие махбодын) шинж чанартай тодорхой бүлэг хүмүүс байдаг гэсэн бодол нь арьс, үндсээр ялгаварлан гадуурхах үзлийг бий болгодог. Арьс, үндсээр ялгаварлан гадуурхах зан үйл нь зөвхөн ил тод хэлбэрээр - жишээлбэл, хүмүүсийг арьсны өнгө, угсаа гарвалаар нь ялгаварлан харьцахаар зогсохгүй, далд хэлбэрээр ч илэрч болдог. Жишээлбэл нийгэм тодорхой бүлэг хүмүүсийг ялгавартай үнэлгээ, шүүлтээр системтэйгээр харьцдаг байдал хамаарна. Арьс, үндсээр ялгаварлан гадуурхах зан үйл нь ихэвчлэн арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах, түүний илэрхий сөрөг үр дагаварт хүргэдэг бөгөөд энгийн үл тоомсорлох, эсвэл өөр, доогуур гэж үздэг хүмүүсээс зайлсхийх, дарамтлах, мөлжлөг, гадуурхах зэргээр илэрдэг үзэгдэл, хэлбэрүүд юм.

Асуудлыг шалгах сайн эх сурвалж бол арьс үндэсээр ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц (ICERD) юм.

Дасгалын хувьд суралцагчдаас арьсны өнгө нь ямар байхыг урьдчилан мэдэхгүйгээр амьдрах тавилантай олон үндэстний нийгмийг төлөвлөхийг хүс.

Арьс үндсээр ялгаварладаггүй анги

Анги танхимыг хүлээн зөвшөөрч, олон үндэстний баяр ёслолын газар болгох олон арга бий. Соёлын хүчин зүйлүүд нь сурагчийн хариултад нөлөөлдөг, тухайлбал, жүжигчилсэн тоглолт, үлгэр ярих хэв маяг нь нөлөөлдөг. Ангид арьс үндэстний зөрчилдөөн гарсан тохиолдолд түүнийг шийдвэрлэх; бүү орхи. Арьс үндсээр ялгаварлан гадуурхах үзлийг бэхжүүлдэг х зан үйлийг хэрхэн танихыг сурагчдадаа заа. Ялгаварлан гадуурхалтын эсрэг тэмцэж байсан алдарт хүмүүсийн түүхийг судлаарай. Хүний мэдлэг, туршлагын сан хөмрөгөөс дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн хүмүүсийн оруулсан хувь нэмрийг судал. Хичээлийн хөтөлбөрт аль болох соёлын олон янз байдлыг оруулах боломжтой. Энэ талаар эцэг эх, хамаатан садан, найз нөхдөөсөө тусламж хүс. Олон нийтийн ажилд идэвхтэй оролцдог өөр арьстан эсвэл өнгөт хүмүүсийг ангийнхандаа юу хийдэг талаар ярихад урь.

(ЭЗБНХУ-ын 1, 2-р зүйл; ХХЗХ-ны 2-р зүйл)

3. Ялгаварлан гадуурхалт – нийгмийн цөөнхийн эрх зүйн байдал

“Цөөнхийн бүлэг” гэсэн ойлголтыг «угсаатан», ихэвчлэн “арьс үндэс” гэсэн ойлголттой хольж ойлгодог бөгөөд ийм үед өмнөх үйл ажиллагаанууд мөн хамааралтай болно. Энэ нэр томьёо нь уугуул хүмүүс, нүүн дайжсан хүмүүс, цагаач ажилтан, дүрвэгсэд, тэр ч байтугай хэлмэгдсэн олонхыг тодорхойлоход хэрэглэгддэг. Эдгээр бүлгүүд нийтлэг шинж нь ядуурал юм. Цөөнхийн бүлэг хангалттай хүчирхэгжвэл “цөөнхийн бүлэг” байхаа больж болно.

Цөөнхийн бүлгийн гишүүд хувь хүнийхээ эрхийг эдлэх эрхтэй боловч тэв ихэвчлэн бүлэг болохыг хувьд тодорхой зарим эрхийг эдлэхийг шаарддаг. Ямар бүлэг байгаа эсэхээс хамааран эдгээрт соёл, улс төрийн хувьд өөрсдийгөө тодорхойлох эрх, газар нутгийг нь эзлэн авсны нөхөн төлбөр, байгалийн баялгийг хянах эсвэл шашны дурсгалт газруудад нэвтрэх зэрэг байж болно.

А Зарим “цөөнхийн бүлгүүдийг” тодорхойлох

Ангийн суралцагчдад “цөөнхийн бүлэг” гэсэн тодорхойлолтыг боловсруулахад туслаарай.

- Математикийн хувьд тэд үргэлж цөөнх байдаг уу?
- Цөөнхүүд дийлэнх буюу давамгайлсан нийгмийн бүлгээс ямар шинж чанараараа ялгаатай байдаг вэ?

Өөрийн улсын иргэдээс эхлээд орчин үеийн «цөөнхийн бүлгүүдийн» жагсаалтыг гаргахын тулд ангийнхантай оюун бодлоо уралдуулах аргыг ашиглаарай. Нийгмийн анги давхарга, чадвар, бэлгийн чиг баримжаа болон бусад арьс үндэсний хүчин бүхий цөөнхүүдийг оруулахаа мартуузай. Эдгээр цөөнхийн бүлгүүд ялгаварлан гадуурхалтад өртөж байна уу? Тийм бол ямар арга замаар?

Ахлах ангийн суралцагчид тодорхой цөөнхийн бүлгүүдийн хэмжээ, байршил, түүх, соёл, орчин үеийн амьдралын нөхцөл байдал, тэдний хүсдэг үндсэн шаардлагуудын талаар олж мэдэхийн тулд тохиолдол шинжлэх аргыг ашиглаж болно.

- Хүн амын дунд цөөнхийн бүлгийг (жишээлбэл, уугуул хүмүүс, цагаачид, дүрвэгсэд, цагаач ажилтнууд) үүсгэдэг зарим нөхцөл байдал юу вэ?

(ХЭТТ-ын 1, 2 дугаар зүйл; ХЭТК-ын 2, 29, 30 дугаар зүйл)

В Соёлын онцлог байдал/соёлын олон янз байдал

Хүн бүр соёлын өвөрмөц онцлогтой бөгөөд энэ нь тэдний нэг хэсэг учир төдийлөн анзаараад мэддэггүй. Гэхдээ угсаатны, шашны, хэлний цөөнх эсвэл уугуул үндэстний цөөнхтэй улс орнуудад соёлын өвөрмөц байдал нь ялангуяа илүү хүчирхэг бүлэглэл өөрийн соёлыг хүч чадал багатай бүлэгт тулгах гэж оролдох үед хүний эрхийн асуудал болж хувирдаг.



Хүүхдийн эрхийн тухай конвенцод хүүхдийн соёлын онцлогтой байх эрхийг тухайлан авч үздэг. Конвенцын 29 дүгээр зүйлд хүүхдэд өөрийн соёл, хэл, үнэт зүйлсийг хүндэтгэх хүмүүжлийг төлөвшүүлэх хөгжүүлэхийг, 30 дугаар зүйлд хүүхдийн соёл, урлагийн амьдралд бүрэн оролцох эрхийг, 31 дүгээр зүйлд ялангуяа цөөнх болон уугуул хүмүүсийн хүүхдүүд соёл, шашин шүтлэг, хэлний эрхийг хүлээн зөвшөөрсөн.

ЮНЕСКО-гийн Соёлын олон янз байдлын тухай түгээмэл тунхаглалд соёлын өвөрмөц байдал болон олон талт байдлын хоорондын уялдаа холбооны талаар “Соёл нь цаг хугацаа, орон зайд олон янзын хэлбэрийг олж авдаг. Энэхүү олон янз байдал нь хүн төрөлхтнийг бүрдүүлдэг бүлгүүдийн өвөрмөц болон онцлог олон талт шинж чанарт тусгалаа олдог. Байгаль эх дэлхийн биологийн олон янз байдлын нэгэн адил соёлын олон талт байдал нь хүмүүний нийгмийн солилцоо, шинэ санаачилга, бүтээлч байдлын эх үүсвэр болохын хувьд зайлшгүй шаардлагатай. (1 дгээр зүйл).

Өөрийнхөө амьдарч байгаа нийгмийн орчныг шалгах.

- Танай улсад соёлын цөөнх байдаг уу?
- Тэдний соёлыг хүндэтгэдэг үү?
- Тэд өөрсдийн соёлд чөлөөтэй, нийтээрээ оролцдог уу, эсвэл зөвхөн хувь хүнийхээ хувьд оролцдог уу? эсхүл огт оролцдоггүй юу?
- Танай сургууль цөөнхийн соёлыг хүндэтгэхийг дэмждэг үү?

Хэлэлцэх асуудал:

- Соёлын онцлогтой байх эрх яагаад ийм чухал вэ? Янз бүрийн соёлыг хадгалах, хөгжүүлэх, мэдрэх буюу үнэлэх нь яагаад чухал вэ?
- Яагаад давамгайлсан бүлгүүд өөрсдийн соёлыг цөөнхийн бүлэгт тулгах гэж оролддог вэ?

(ХЭТТ-ын 26 дугаар зүйл; ХЭтК-ын 29, 30, 31 дүгээр зүйл)

С Цөөнх бүлгийн төлөөлөл



Цөөнх бүлгийн төлөөллийг ангидаа урьж, Хүний эрхийн клуб-ын хүрээнд яриа хийлгээрэй. Сурагчдыг өөрсдийн хэвшмэл ойлголт, хүлээлтийг таньж, асуулт асуухад бэлдэхэд туслаарай. Суралцагчид шударга ёс, эрх чөлөө, тэгш байдлыг өөрийн анги танхимдаа бий болгоход хэрхэн оролцож болох вэ?

(ХЭТТ 26-р зүйл, ХЭтК-ын 29,30 дугаар зүйл)

4. Ялгаварлан гадуурхалт – жендэр

Түгээмэл тунхаглалын 2 дугаар зүйлд хүний эрхийг “аливаа ялгаагүйгээр” тунхагласан бөгөөд ард түмний хооронд дур зоргоороо шугам татахад хэрэглэгддэг хэд хэдэн үндэслэлийн талаар тодорхой дурдсан байдаг. Эдгээрийн нэг нь хүйс бөгөөд хүйсээр ялгаварлан гадуурхах (“сексизм”) нь нийгмийн шударга бус байдлын хамгийн өргөн тархсан эх сурвалжуудын нэг хэвээр байгаа тул энэ асуудлыг тодорхой тайлбарлах шаардлагатай.

Арьс үндсээр ялгаварлан гадуурхах үзлийн нэгэн адил хүйсээр ялгаварлах үзэл нь соёл, нийгмийн бүх талыг хамардаг. Энэ нь хүмүүсийн хандлагад ухамсаргүйгээр тусгалаа олсон байдаг нь ялгаварлан гадуурхалтыг улам бүр нэмэгдүүлдэг. Нэг хүйсийн хүний эрхийг бүрэн эдлэхийг үгүйсгэх нь тухайн хүнийг бүрэн хүн гэж үзэхгүй байх үр дагаварт хүргэнэ.

А Хүйс эсхүл жендэр?

Хүйс (биологийн хувь тодорхойлогддог хүчин зүйл) ба жендэр (соёлын хувьд тодорхойлогддог хүчин зүйлүүд) хоорондын ялгааг тайлбарлана. Суралцагчдыг хоёр багт хувааж, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгааг тодорхойлуулна. Зарим нь хүйсээр (жишээ нь насанд хүрсэн эрэгтэй сахалтай; эмэгтэйчүүд урт насалдаг) зарим нь жендэрт (жишээ нь эрэгтэйчүүд математикт илүү сайн; эмэгтэйчүүд ичимхий) тулгуурлан ялгаа бүхий жагсаалтыг гаргахыг хүсээрэй. Баг тус бүр өөрсдийн тодорхойлсон онцлог шинж чанаруудыг нэг нэгээр нэрлэх бөгөөд энэ нь хүйсийн эсхүл жендэрийн ялгаа эсэхийг ангиараа тогтооно. Мэдээж санал зөрөлдөөн гарах болно (жишээ нь, эрэгтэйчүүд байгалиасаа илүү түрэмгий байдаг уу?) Гэхдээ хэлэлцүүлгийн үр дүн нь суралцагчдад өөрсдийн жендэрийн хэвшмэл ойлголтыг танихад тусална. Жендэрийн хэвшмэл ойлголтын жишээг анги, сурах бичиг, хэвлэл мэдээлэл, нийгмийн бүлгүүдээс илрүүлэн шалгаарай. (ХЭТТ-ын 2 дугаар зүйл; ХЭТК-ын 2 дугаар зүйл)

В Хэн нь хэн бэ?

Суралцагчдаас сургууль дээр байдаг ном болон бусад хэрэглэгдэхүүнээс дараах зүйлийг судлуулна:

- Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн талаарх ижил тооны эшлэл байна уу?

- Эмэгтэй дүрүүдийг зоригтой шийдвэр гаргадаг, бие бялдрын хувьд чадвартай, адал явдалт, бүтээлч, хэтийн карьерыг сонирхдог байдлаар харуулсан байна уу?
- Эрэгтэй дүрүүдийг хүнлэг, бусдад анхаарал халамж, тусламж үзүүлдэг, сэтгэл хөдлөлөө илэрхийлдэг, бусдад өөрийгөө «эр хүн» гэж бодохгүй байх вий гэсэн айдасгүй хүн шиг илэрхийлсэн байна уу?
- Эрэгтэй, эмэгтэй хүмүүс бие биенээ эрх тэгш хүндэтгэдэг үү?
- Эрэгтэйчүүд хүүхэд асрах, гэрийн ажил хийх ажилд идэвхтэй оролцдог уу?
- Эмэгтэйчүүд гэрээсээ гадуур идэвхтэй үүрэг гүйцэтгэдэг, хэрэв тийм бол энэ нь эмэгтэйчүүдийн уламжлалт ажил (жишээ нь, багш, сувилагч, нарийн бичгийн дарга гэх мэт) эсвэл цалингүй эсвэл бага цалинтай ажлаас өөр ажил байсан уу?

(ХЭТТ-ын 2 дугаар зүйл; ХЭтК-ын 2, 29 дугаар зүйл)

С Жендэр

Танил үүх түүхүүдийн (жишээ нь, роман, кино, телевизийн цуврал эсвэл ардын үлгэр гэх мэт) дүрүүдийн жендэрийг өөрчилсөн байдлаар дахин ярилцана. Энэхүү жендэрийн өөрчлөлтийн үр нөлөөний талаар хэлэлцээрэй

(ХЭТТ-ын 2 дугаар зүйл; ХЭтК-ын 2, 29 дүгээр зүйл)

Д Би юунд дуртай/би юу хийдэг¹¹

Суралцагчдаас өөрийнхөө тухай эдгээр асуултад хариулт бичихийг хүснэ:

1. Миний хүйсийн хийх ёстой надад таалагддаг гурван зүйл.
2. Миний хүйсийн хийх ёстой миний дургүй гурван зүйл.
3. Хэрвээ би өөр хүйсийн хүн байсан бол хийхийг хүсдэг гурван зүйл.

Суралцагчдаас өөрийн бичсэн жагсаалтын ижил хүйсийн хамтрагчдаа уншуулахыг хүснэ. Дараа нь хос бүрээс эсрэг хүйсийн хостой хуваалцахыг хүснэ.

¹¹ Adapted from *Local Action/ Global Change: Learning about the Human Rights of Women and Girls* by Julie Mertus, Nancy Flowers and Mallika Dutt (UNIFEM, 1999).

Үр дүнг хэлэлцээрэй. Энэ нийгэм жендэрийн хүлээлтэд үл нийцэх хүмүүст хэрхэн ханддаг вэ? Жендэрийн хүлээлт хүмүүсийн хүний эрхийг хязгаарлаж байна уу?

(ХЭТТ 2 дугаар зүйл; ХЭтК-ын 2 дугаар зүйл)

Е Шийдвэр гаргах

Суралцагчдаас гэр бүлийнхээ бүх гишүүдэд нөлөөлөх зарим чухал шийдвэрийн талаар оюун бодлоо уралдуулах дасгал хийхийг хүснэ. Шийдвэр бүрийн хажууд энэ нь голчлон эрэгтэй, эмэгтэй эсвэл аль алинд нь хамаарах эсэхийг бичнэ. Гэр бүлд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн гаргадаг шийдвэрийн ялгааг ярилцаарай.

Дараа нь суралцагчдаас сүүлийн хэдэн жилд тухайн нийгмийн орчинд нь гарсан нийт хүн амд нөлөөлсөн зарим чухал шийдвэрүүдийг жагсаахыг хүснэ (жишээлбэл, шинэ клуб эсвэл баг байгуулах, эмнэлэг барих эсвэл хаах, газар олгох, автобусны үнэ нэмэх). Жижиг бүлэгт дараах шийдвэрүүдийн нэгийг өгч, дүн шинжилгээ хийнэ.

- Эдгээр шийдвэр жендэрийн үр дагавартай юу? Тэд охид, эмэгтэйчүүдэд тухайлан нөлөө үзүүлэх үү? Хөвгүүд болон эрэгтэйчүүдэд ямар нөлөө үзүүлэх вэ?
- Шийдвэр бүрийн хажууд шийдвэр гаргасан бүлгийн нэр, тухайн бүлэгт эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ойролцоо хувийг бичнэ.
- Шийдвэр гаргахад эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тоо тэнцүү байсан бол шийдвэр өөр байж болох уу?

(ХЭТТ-ын 2, 21 дүгээр зүйл; ХЭтК-ын 2, 12 дугаар зүйл)

Ф Хүйсээр ялгаварлан гадуурхдаггүй анги

Арьс үндсээр ялгаварлан гадуурхалтгүй анги танхимд зориулсан саналуудын ихэнхийг (Дээрх “Ялгаварлан гадуурхах - арьсны өнгө, арьс үндэс” хэсгийг үзнэ үү) бусад ангиудыг хүйсээр ялгаварладаггүй болохыг сурталчлах зорилгоор хэрэгжүүлж болно. Жендэрийн хэвшмэл ойлголтыг эвдэхийн тулд аль болох тусламж хүсээрэй. Хүйсээр ялгаварлан гадуурхах явдлыг хэзээ ч бүү хүлээн зөвшөөр. Шударга байдал гэж юу болохыг эргэж асуу. Суралцагчдыг Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцтой танилцуулна.

Багш нар өөрсдөө охидыг ялгаварлан гадуурхаж, харин хөвгүүдэд илүү анхаарал хандуулж, хөвгүүдийг охидоос хоёр дахин их ярихыг дэмждэг болох нь судалгаагаар нотлогдсон. Хөвгүүдийг сониуч зан,

зоригтой байдлаар нь магтдаг бол охидыг цэвэр цэмцгэр, шуурхай, зааварчилгааг дагах чадвараар нь сайшаадаг. Эдгээр судалгаанд хамрагдсан багш нарын ихэнх нь хөвгүүдийг илүүд үздэгээ мэддэггүй байсан бөгөөд эдгээрийг илтгэн харуулсан баримтад сэтгэл дундуур байсан.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, ялангуяа зар сурталчилгаа нь жендэрийн дүн шинжилгээ хийх сайн материал болно. Сургуулийн сургалтын хөтөлбөр, сурах бичгийг сайтар судалж үзэхийг зөвлөж байна (мөн дээрх Хэн нь хэн бэ? үйл ажиллагааг үзнэ үү).

- “Түүх” нь эрэгтэй хүний нэгэн адил эмэгтэй хүний үүрэг рольд нухацтай анхаарал хандуулдаг уу?
- “Эдийн засаг” нь хөдөлмөрийн зах зээл дэх эмэгтэйчүүдийн талаар (гэрийн эсвэл гэрийн гадаа) хэлэлцдэг үү?
- “Хууль” эмэгтэйчүүд болон эд хөрөнгийг асуудалд анхаардаг уу?
- “Засгийн газар” эмэгтэйчүүдийн төлөөллийн дутмаг байдалд анхаардаг уу?
- “Шинжлэх ухаан” эмэгтэйчүүдийн хийсэн зүйлд зохих ач холбогдол өгдөг үү?
- Охидыг математик, шинжлэх ухаан, компьютерийн хичээлд амжилт гаргахыг дэмждэг үү?
- “Уран зохиол”, “хэл”, “урлаг” гэсэн сургалтад хэр хүйсийн ялгаварлан гадуурхах үзэлт гардаг вэ?

Сургуулийн хичээлээс гадуур үйл ажиллагааг мөн анхааралтай авч үзнэ.

- Охидыг клуб, сонгуульт албан тушаалд удирдан манлайлан эрх тэгш боломжоор хангадаг уу? Сургуулиа олон нийтэд төлөөлөн оролцоход?
- Сургуулийн ивээн тэтгэсэн үйл ажиллагаанаас охидыг хасдаг уу?
- Охид хөвгүүдийн нэгэн адил спортын байгууламж, спортын багт хамрагдах боломжтой юу?
- Охид сургууль дээрээ бэлгийн дарамт, бие махбодын заналхийлэлд өртөхөөс аюулгүй байж чаддаг гэж боддог уу?
- Шагнал, тэтгэлэг, санхүүгийн тусламж болон бусад шагналыг охидод эрх тэгш байдлаар олгодог уу?

(ХЭТТ-ын 2, 26 дугаар зүйл; ХЭТК-ын 2, 29 дүгээр зүйл)

5. Ялгаварлан гадуурхалт – Хөгжлийн бэрхшээлтэй байдал

Суралцагчид сургуулиас гадуур холбогдох асуудлыг илүү их ойлгохыг хүсвэл бие бялдар, оюуны хомсдолтой хүмүүстэй хамт олон нийтийн практик үйл ажиллагаа явуулах нь хамгийн тохиромжтой байж болно.

А Хөгжлийн бэрхшээлтэй байдлын талаарх илтгэгч

Тусгай хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ангидаа урьж ярилцлага өрнүүлэх. Тэд өөрт тохиолдож буй бэрхшээл, үр дүнд нь сурсан сургамж, тэдний эрх ямар байж болохыг хамгийн сайн тайлбарлаж чадна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нэгдүгээрт хүн, хоёрдугаарт эмзэг бүлгийнхэн байдаг гэдгийг онцлон тэмдэглээрэй.

(ХЭТТ-ын 1, 2 дугаар зүйл; ХЭтК-ын 2, 23 дугаар зүйл)

В Бүгдэд зориулагдсан сургууль

Ангийнхнаас сургууль болон түүний хүрээлэн байгаа орчныг судалж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хэр хүртээмжтэй байгааг олж мэдээрэй.

Хэлэлцэх асуудал:

- Тэд ямар өөрчлөлтийг санал болгох вэ?
- НҮБ-аас 1975, 1971 онд тус тус тунхагласан Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай тунхаглал, Оюуны хомсдолтой хүмүүсийн эрхийн тухай тунхаглалыг сурталчлахын тулд танай сургууль юу хийж чадах вэ?

(ХЭТТ-ын 1, 2 дугаар зүйл; ХЭтК-ын 2, 23 дугаар зүйл)

Сурч боловсрох эрх



Хүн бүр сурч боловсрох эрхтэй хэдий ч олонх нь Хүүхдийн эрхийн тухай конвенцын 29 дүгээр зүйлд заасан “хүүхдийг бие хүн болгон төлөвшүүлэх, авьяас билэг, оюуны болон биеийн чадавхыг бүрэн төгс хөгжүүлэх” (**ХХТХ-ийн 29.1-р зүйл**) шаардлагад нийцсэн боловсролыг олж авч авдаггүй. Сая сая хүүхдэд сургуульд явах боломжоор огт хангагдаагүй. Тэдний нийгмийн байдал, хүйс, ядуурал зэрэг олон хүчин

зүйл нь тэднийг амь зуухын тулд хөдөлмөрлөхөд хүргэдэг. Боловсрол дутмаг байх нь хүний бусад эрхийг эдлэх боломжийг нь ч мөн хязгаарладаг.

А Манай сургуульд хэн байхгүй вэ?

Суралцагчдаас тухайн сургуульд нь ямар залуучууд төлөөлөлгүй байгаа талаар бодож үзэхийг хүсээрэй. Тухайлбал:

- охид эсвэл хөвгүүд цөөн үү?
- хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд?
- оюуны хомсдолтой хүүхдүүд?
- Хууль болон сургуулийн удирдлагуудтай асуудалд орсон хүүхдүүд?
- өнчирсөн хүүхдүүд?
- орон гэргүй хүүхдүүд?
- эцэг эх болон/эсвэл гэрлэсэн хүүхдүүд?
- Цагаач ажилтнуудын хүүхдүүд?
- Дүрвэгчдийн хүүхдүүд?
- Цөөнхийн бүлгийн хүүхдүүд?
- Гэр бүлдээ ажил хийх шаардлагатай ядуу хүүхдүүд?

Сургуульдаа байхгүй гэж дурдсан бүлэг бүрээс дараах зүйлийг асуу.

- Эдгээр хүүхдүүд яагаад энэ сургуульд сурдаггүй вэ? Тэд сурах ёстой юу? Яагаад эсвэл яагаад болохгүй гэж?
- Тэд өөр газар сургуульд сурдаг уу?
- бие бялдрын хувьд сургуульд суралцах боломжгүй хүүхдүүдийг хэрхэх вэ? Тэд яаж боловсрол эзэмшдэг вэ?

Хэрвээ зарим хүүхэд өөр сургуулийг нэрлэсэн бол дараах асуултыг асуугаарай.

- Эдгээр хүүхдүүд яагаад танайхаас өөр сургуульд сурдаг вэ?
- Энэ сургууль хаана байдаг вэ? Хүүхдүүд тэнд амархан хүрч чадах уу?
- Энэ сургуульд хүүхдээ суралцуулах тулд гэр бүлүүд төлбөр төлөх ёстой юу? Эцэг эх нь эдгээр сургуулийн төлбөрийн төлж чадахгүй бол яах вэ?

- Тэнд хүүхдүүд сайн боловсрол эзэмшдэг гэж та бодож байна уу?

Сургуульд хамрагддаггүй хүүхдүүдэд (тухайлбал, гэр бүлдээ

ажиллах шаардлагатай ядуу хүүхдүүд, насанд хүрээгүй байхдаа гэрлэсэн эсвэл хүүхэдтэй болсон охид) сурч боловсрох эрхийг хэрхэн эдлүүлэх талаар асуу. Тэдний сурч боловсрох эрхийг хангах нь хэний үүрэг вэ?

Боломжтой бол суралцагчдаар судалгаа хийлгэж, тусгай хэрэгцээ бүхий суралцагчдад зориулсан зарим сургуульд зочлоорой. Эдгээр сургуулиуд нь хүүхдийн сурч боловсрох эрхийн талаарх Хүүхдийн эрхийн конвенцын стандартад нийцэж байгаа эсэх талаар сурагчидтай ярилцаж, бичихийг хүсээрэй. Тэд бүх хүүхдийн боловсрол эзэмших эрхийг хамгаалахын тулд юу хийж чадах вэ?

(ХЭТТ-ын 26 дугаар зүйл; ХЭтК-ын 28, 29 дүгээр зүйл)

В Хэрэв та уншиж чадахгүй бол яах вэ?

Суралцагчдаас гэртээ, сургууль дээрээ, олон нийтийн газар эсвэл хаана ч байсан энгийн өдөр ямар нэг зүйл уншсан бүх цагаа жагсаан бичихийг хүс. Үүнд компьютер ашиглах, зурагт үзэх, ойр орчим алхах үедээ “ухамсаргүйгээр” унших үйлдлийг мөн хамруулан тооцно.

Суралцагчдаас жагсаалтаа харьцуулан ярилцахыг хүс:

- Хэрэв та уншиж чадахгүй бол энэ нь таны амьдралд хэрхэн нөлөөлөх вэ?
- Та ямар үйлдлүүдийг хийж чадахгүй эсвэл сайн хийх вэ?
- Бичиг үсэг үл мэдэх нь таны болон танай гэр бүлийн эрүүл мэнд, аюулгүй байдал, найдвартай байдалд хэрхэн нөлөөлж болох вэ?
- Хэрэв та уншиж чадахгүй дараах хүн байсан бол танд энэ нь хэрхэн нөлөөлөх вэ?
 - Ээж? /Аав?
 - Үйлдвэрийн ажилтан?
 - Хөдөө аж ахуйн ажилтан уу?
 - Дэлгүүрийн эзэн?
 - Цэрэг?
 - Иргэн?

С Боловсрол хүний эрх болох нь

Сурч боловсрох эрх нь хүний эрхийн харилцан хамаарлын зарчмыг тодорхой харуулна. Суралцагчдаас ХЭТТ-ын 30 зүйл тус бүрийг болон/эсвэл Хүүхдийн эрхийн тухай конвенцын хураангуй хувилбарыг анхаарч үзэхийг хүсээд “Хэрэв та боловсролгүй бол

энэ эрхийг эдлэх чадвар тань юугаараа ялгаатай байх байсан бэ?” хэмээн асууна. **(Тухайлбал, ХЭТТ-ын 21 дүгээр зүйлд заасан төрийн үйл хэрэг болон чөлөөт сонгуульд оролцох эрх; эсвэл ХЭТК-ын 13 дугаар зүйлд заасан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө)**

2000 онд дэлхийн 850 сая гаруй бичиг үсэг тайлагдаагүй насанд хүрэгчдийн бараг гуравны хоёр нь эмэгтэйчүүд байсныг онцлон тэмдэглээрэй. Түүнчлэн, дэлхий дээр бага боловсролд хамрагдаагүй 113 сая орчим хүүхдийн 60 хувь нь охид байна.¹² Суралцагчдаас эдгээр статистикийг тайлбарлуулаарай. Энэ баримт нь охид, эмэгтэйчүүдийн хүний эрхэд хэрхэн нөлөөлж байна вэ?

D Өөрийн эрхийг мэдэх эрх

Хүний эрхийн тухай, хүний эрхийн төлөөх хүний эрхийн боловсрол нь өөрөө олон улсын хэм хэмжээгээр хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрх болохыг тайлбарлана (энэ товхимлын Нэгдүгээр бүлгийг үзнэ үү). Суралцагчдаас дараах асуултыг асууна:

- Хүний эрхийн талаар хүмүүс юу мэдэх ёстой вэ?
- Хүний эрхийн боловсрол яагаад чухал вэ? Зарим хүмүүст энэ нь бусдаас илүү хэрэгтэй юу? Хэрэв тийм бол хэнд? Яагаад, юуны учир?
- Хүний эрхийг хэрхэн сургах вэ?
- Хүний эрх сургуулийн бусад хичээлээс юугаараа ялгаатай вэ? (жишээ нь: тэдгээр нь ямар үйл ажиллагаа, мэдлэгийг агуулдаг)?
- Сурагчид өөрсдөө хүний эрхийн талаар хэрхэн суралцах вэ?

(ХЭТТ-ын 26 дугаар зүйл; ХЭТК-ын 17, 29 дүгээр зүйл)

Хөгжил ба байгаль орчин

Та хаана амьдардаг вэ? Хөгжил нь хүн төвтэй, оролцоотой, байгаль орчинд ээлтэй байх ёстой учраас дэлхийн хаана ч байсан хөгжил, хүний эрх, байгаль орчны асуудал харилцан хамааралтай байдаг. Энэ нь зөвхөн эдийн засгийн өсөлт биш, харин тэгш хуваарилалт, хүмүүсийн чадавхыг дээшлүүлэх, тэдний сонголтыг өргөжүүлэх явдал юм. Энэ нь нэн тэргүүнд ядуурлыг арилгах, эмэгтэйчүүдийг хөгжлийн үйл явцад оролцуулах, ард түмэн болон засгийн газрын

¹² UNESCO, “Education for All Year 2000 Assessment”.

бие даах чадвар, бие даан шийдвэр гаргах, уугуул хүмүүсийн эрхийг хамгаалахад анхаарал хандуулдаг.

Хүний эрх ба хөгжлийн хоорондын нягт уялдаа холбоо нь хагас зууны туршид турш НҮБ-ын хэлэлцүүлэгт чухал байр суурь эзэлсээр ирсэн. 1986 онд НҮБ-ын Хөгжих эрхийн тухай тунхаглалын 1 дүгээр зүйлд “Хөгжих эрх нь хүний салшгүй эрх бөгөөд үүний ачаар хүн бүр, бүх ард түмэн эдийн засаг, нийгэм, соёл, улс төрийн хөгжилд оролцох, хувь нэмрээ оруулах, эдлэх эрхтэй бөгөөд хүний эрх, үндсэн эрх чөлөө бүрэн дүүрэн хэрэгжих боломжтой” хэмээн тодорхойлсон. Хөгжих эрх нь дараах зүйлийг өөртөө агуулдаг.

- байгалийн баялгийн бүрэн эрхт байдал
- өөрийгөө тодорхойлох
- хөгжилд ард түмний оролцоо
- боломжийн эрх тэгш байдал
- иргэний болон улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын бусад эрхээ эдлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх.

Суралцагчид хаана амьдарч байгаа эсэхээс хамааран эдгээр асуудлын талаар өөр өөр ойлголт, туршлагатай байж болно.

Өдөр бүр материаллаг хомсдолд амьдарч буй суралцагч нартай ажилладаг багш нар өөрсдийн үйл ажиллагааг бодит байдалд тулгуурлан, дэлхийн тогтолцоотой аль болох ойртуулахыг хүсэж болно. Тэд дэвшилтэт хөгжлийн хэтийн төлөв, түүнд хүрэхэд шаардлагатай алхмуудыг талаар авч үзэж болно.

Материаллаг давуу тал бүхий суралцагч нартай ажилладаг багш нар хөгжил, өөрийгөө тодорхойлох шаардлагад хариу үйлдэл үзүүлэх чадварыг нь нэмэгдүүлэх, тэднийг хэрхэн дэмжих талаар практик жишээ өгөхийг хүсэж болно. Суралцагчид хөгжих эрх, байгаль орчныг дэмжихэд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр зэрэг төрийн бус байгууллага, засгийн газар хоорондын байгууллагуудын олон улсын хамтын ажиллагааны үүргийн талаар судалгаа хийж болно.

А Хоол хүнс

Суралцагчдаас нэг өдрийн дотор идэж уусан бүх зүйлийнх нь бүртгэлийг хөтлүүлээрэй. Амьд байх, хөгжихөд нь тэдний бие махбодод юу хэрэгцээтэй (жишээ нь нүүрс ус, өөх тос, уураг, эрдэс бодис, витамин, ус) талаар дүн шинжилгээ хийлгэнэ.

Нэг хоолыг сонгоод түүний бүрэлдэхүүн хэсэг тус бүрийг үйлдвэрлэсэн, боловсруулсан, тээвэрлэсэн, бэлтгэсэн хүмүүсийн талаар олж мэдээрэй. Энэхүү судалгааг орон нутгийн зах, хүнсний дэлгүүрүүдийг хангадаг бөөний төвүүдтэй танилцах аялалтай хослуулж болно.



Өдөр тутмын хоолны орцонд ордог ч ойролцоо ургах боломжтой ногоо, жимсийг сонгоорой. Анги хамт олон хосоороо ажиллаж, лааз, ваар эсвэл сургуулийн цэцэрлэгт хүрээлэнд үүнийгээ тарьж ургуулна. Зарим суралцагчид ургамал тарих чадвар яагаад бусдаас илүү амжилттай байдгийг тодорхойл. Цэцэрлэг, газар тариалангийн талаар сайн мэддэг хэн нэгнийг ангийнхантай ургамал арчлах талаар ярилцахад урь.

Бүх суралцагчид хамтран ажиллаж, үр шимийг нь хуваалцах боломжтой ангийн цэцэрлэг байгуулаарай. Боломжит сайжруулалтын талаар хэлэлцэхийн тулд оюун ухаанаа уралдуулах дасгал ажлыг зохион байгуул. Жишээ нь, тариалах аль арга нь хамгийн тохиромжтой вэ? Хортон шавжтай тэмцэх өөр арга байгаа эсэх? Ажлаа хуваарилах системийг хэрхэн илүү үр ашигтай, хамтын ажиллагаатай болгох вэ?

Энэхүү ангийн ажлыг дэлхийн бусад хэсгүүдийн нөхцөл байдал хооронд ижил төстэй зүйл байгаа эсэхийг судалж болно. Хотын сургууль хөдөө орон нутгийн сургуульд харилцан зочилж, тодорхой туршлагаа хуваалцахаар тохиролцож болно (энэ тохиолдолд хүнсний үйлдвэрлэл, түгээлттэй холбоотой харилцаа холбоог өргөжүүлэхэд анхаарна).

(ХЭТТ-ын 25 дугаар зүйл; ХЭтК-ын 24, 27 дугаар зүйл)

В Ус

Дэлхий дээр цэвэр ус ховордож, улам бүр хомсдож байна. Хуурайшил ихтэй газар амьдардаг суралцагчид энэ нөхцөл байдлын талаар бүрэн ойлголттой болно. Суралцагчдаас өдөрт хэдий хэмжээний ус хэрэглэж байгааг тооцоолж, уух, угаах гэх зэргийг харуулсан хүснэгт гаргаж, хэрэглэж буй усаа хаанаас авдаг болохыг судлаарай.

Ус нь өвчин үүсгэдэг хог хаягдал, организмыг зөөвөрлөнө. Ариун цэврийн усны менежмент (татан нийлүүлэлт болон зайлуулах) нь нийтийн сайн сайхан байдалд зайлшгүй шаардлагатай. Сурагчдаас дангаар нь эсвэл жижиг бүлгээрээ сургуулийнхаа усан хангамж, зайлуулах системийг судалж, хэрхэн сайжруулах талаар санал боловсруулахыг санал болгоно. Энэ ажлаа үргэлжлүүлж нийгмийн бусад хүрээнд хийж болно. Хэрэглэж буй усныхаа аюулгүй байдлыг хангахад хэн үүрэг, хариуцлага хүлээх вэ?

(ХЭТТ-ын 25 дугаар зүйл; ХЭтК-ын 24, 27 дугаар зүйл)

С Аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх

Хангалттай хоол хүнс, ус бол хөгжлийн тэргүүлэх үндсэн асуудал юм. Түгээмэл тунхаглалын 25 дугаар зүйлд эрүүл мэнд, сайн сайхан байдалд хүрэлцэхүйц амьжиргааны түвшинд хүрэх эрхийн бүрэлдэхүүн хэсэг болох хоол хүнсний талаар тусгайлан заасан байдаг. Хүүхдийн эрхийн тухай конвенцын 27 дугаар зүйлд хүүхэд бүр өөрийн бие бялдар, оюун ухаан, оюун санаа, ёс суртахуун, нийгмийн хөгжилд тохирсон амьжиргааны түвшинг хангах эрхийг баталгаажуулсан. Эдгээр эрх нь НҮБ-ын Хүүхдийн сан (ЮНИСЕФ), НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага зэрэг байгууллагуудын анхаарал хандуулдаг асуудал бөгөөд үндэсний аюулгүй байдал, дэлхийн энх тайвныг сахин хамгаалахад чухал ач холбогдолтой юм.

Суралцагчдаас сайн сайхан амьдрахад шаардлагатай хоол хүнс, усны хамгийн бага шаардлагыг судлуулаарай. Хүүхэд бүрэн хөгжихөд хүрэлцэхүйц амьжиргааны түвшин байхгүй бол яах вэ?

Суралцагчдыг НҮБ-ын Хүүхдийн Сангийн «Дэлхийн хүүхдийн нөхцөл байдал» эсхүл НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Хүний хөгжлийн тайлан зэрэг хэвлэлээс авсан НҮБ-ын статистик мэдээллийг ашиглан ялгаатай хөгжлийн түвшинтэй улс орнуудыг өөр хооронд нь харьцуулах даалгавар өгөөрэй. Суралцагч бүр тухайн улсын дундаж хүний талаарх мэдээллийг (жишээлбэл, дундаж наслалт, орлого, хоол тэжээл, цэвэр усны хүртээмж гэх мэт) танилцуулна. Ийм ялгаа нь хувь хүн төдийгүй улс орон, бүс нутгийн хөгжилд үзүүлэх нөлөөллийн талаар ярилцаарай

Материаллаг давуу тал бүхий орчинд суралцаж байгаа хүүхдүүдээс нийгэм дэх ядуурлын талаар олж мэдэхийг хүсэж болно. Хүмүүсийг ядуурлын нөлөөллөөс хамгаалах үүрэг хариуцлагыг хэн хүлээх талаар ярилцаарай.

(ХЭТТ-ын 23, 25 дугаар зүйл, ХЭтК-ын 6, 27 дугаар зүйл)

D Орон байр



Орон байр нь тухайн орон нутгийн уур амьсгал, газарзүй, гэр бүлийн бүтэц, эрх зүйн байдал, соёл, шашин, барилгын материалын хүртээмж зэрэг зүйлсийг шууд тусгадаг. Ангийнхантай хамт орон байранд байх ёстой бүх зүйлийн жагсаалтыг гаргаж, дараа нь эдгээр шинж чанаруудыг агуулсан орон байрыг зохион бүтээхийг хүсээрэй.

Тэдэнд өөрсдийн бүтээсэн зүйлийнхээ онцлогийг тодорхойлж, тайлбарлахыг хүсээрэй.

- Хийц нь тэдний үнэт зүйл, соёлыг хэрхэн тусгасан бэ?
- Ус, цахилгаан зэрэг нөөцийг хэмнэх, бохирдлыг багасгахын тулд орон нутгийн орон байрны хийцийг хэрхэн өөрчилж, сайжруулах вэ?
- Хөдөлгөөний хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүдийн онцлог хэрэгцээ юу байж болох вэ?

Тухайн нийгмийн орчинд орон гэргүй хүмүүс байгаа бол хэн, яагаад орон гэргүй байна вэ гэдгийг хэлэлцэж, судлаарай.

- Орон гэргүй хүмүүсийн асуудлаар хэн үүрэг хариуцлага хүлээх вэ?
- Орон байргүй байх нь хүний эрхийн асуудал мөн үү?
- Үүнийг шийдвэрлэхийн тулд юу хийж болох вэ?

(ХЭТТ-ын 25 дугаар зүйл; ХЭТК-ын 27 дугаар зүйл)

E Хүн ам

Дэлхийн олон улс оронд хүн амын өсөлтийн нөлөө маш тодорхой харагдаж байна. Бусад газруудад эдгээр нөлөө бага зэрэг хэдий ч илэрхий мэдрэгдэж байна. Гэвч энэ үзэгдлийн үр дагавар нь түгээмэл юм. Дэлхийн хүн ам хэрхэн хурдацтай өсөн нэмэгдэж, энэ өсөлт байгаль орчин, нөөцийн төлөөх өрсөлдөөнд хэрхэн нөлөөлж байгааг статистик харуулж байна. Суралцагчид хүн амын өсөлт, түүний цаад асуудлын талаар бодох нь чухал юм.

Хүн амын сэдэв нь зөрчилтэй эрх, хувь хүний төртэй харилцах харилцааны талаар ярилцах боломжийг олгодог. Олон хүүхэдтэй байхыг урамшуулах эсвэл хязгаарлах зэргээр гэр бүлийн хэмжээний

талаарх улс орнуудын бодлогыг судалж, мэтгэлцээн өрнүүлэхийг суралцагчдаас хүсээрэй.

- Эдгээр бодлого нь хувь хүний эрхтэй зөрчилдөж байна уу?
- Хэрэв тийм бол эдгээр зөрчлийг хэрхэн шийдвэрлэх ёстой вэ?

(ХЭТТ-ын 16 дугаар зүйл)

(f) Ажил хөдөлмөр

Дэлхийн эдийн засаг өөрчлөгдөхийн хэрээр дэлхийн ажил эрхлэлтийн мөн чанар өөрчлөгддөг. Тухайлбал, аж үйлдвэржсэн орнуудад үйлдвэржилт нь хотжилтыг бий болгож, тэдгээр улсад хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэж амьдардаг хүмүүс цөөрсөн. Томоохон хотуудад үйлчилгээний салбарт илүү олон хүн ажилладаг. Ажил хайж буй бүх хүнийг ажиллуулах хангалттай ажил байхгүй тохиолдолд хүмүүс эдийн засгийн боломжоо сайжруулахын тулд дэлхий даяар нүүн шилжих хандлагатай байдаг. Улс орнуудын дотоод болон улс хоорондын шилжилт хөдөлгөөний хэв маяг нь эдийн засгийн хөгжлийн хэв маягтай адил ихэвчлэн ажил эрхлэлттэй холбоотой байдаг. Улс орнууд хөдөө аж ахуй, аж үйлдвэр, санхүү, худалдааны бодлогоо нэгтгэж, ард иргэдийнхээ үйлдвэрлэлийн чадавхыг нэмэгдүүлэхэд хүчин чармайлт гаргах ёстой.



Насанд хүрч байгаа хүмүүсийн нэг хэсэг болохын хувьд суралцагчид янз бүрийн төрлийн ажлыг судалж үзэх болно. Нийгмийн олон салбарт ажил хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийг ангид урьж оролцуулах нь суралцагчдын мэдлэгийг өргөжүүлэхэд тусалдаг. Хамгийн чухал нь суралцагчдыг өөр өөр ажлын орчинд оруулснаар тэд чухам юу хийдэг болохыг бодитоор харах боломжтой болно. Боломжтой бол суралцагчдаас ямар ажил сонирхож байгааг асууж, хээрийн аялал зохион байгуулаарай.

Хүүхдийн хөдөлмөрийн талаарх асуудал, тухайлбал хүүхдийн хөдөлмөрийн нас, ажиллах цаг, ажлын төрлийг зохицуулах ёстой эсэх талаарх асуудал онцгой анхаарал татаж байна. Практик болон ёс суртахууны асуудлууд нь эргэцүүлэн бодох, судлах чухал салбар юм. Суралцагчид Олон улсын хөдөлмөрийн байгууллагын (НҮБ-ын хүний болон хөдөлмөрийн эрхийн чиглэлээр мэргэшсэн байгууллага) 1999 оны Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай конвенцыг (No182) Хүүхдийн эрхийн тухай конвенцод заасан заалттай харьцуулж үзэж болно.

Хүүхдийн хөдөлмөр, хөдөлмөрийн практикийг судлах нь ерөнхийдөө суралцагчдыг хэрэглэгчийн хариуцлагын сэдвийг судлах, хүний эрх болон дэлхийн худалдааны практик хоорондын уялдаа холбоог судлахад хүргэдэг. (Доорх “Бизнес ба хүний эрх”-ийг үзнэ үү).

Ажил хөдөлмөрийн асуудлаарх суралцагчийн төслүүд (тухайлбал, орон нутгийн, үндэсний болон олон улсын хөдөлмөр эрхлэлтийн хэв маяг; эдгээрийн аль нэг буюу бүх түвшинд “ажил хөдөлмөр” хэрхэн өөрчлөгдөж байгаа; «ажилтнууд” эрхээ хамгаалахын тулд хэрхэн зохион байгуулалтад ордог гэх мэт) нь сургалтын чухал үр дүнг бий болгож чадна. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын конвенц, зөвлөмж, тайлан нь ажил хөдөлмөр, хүний эрхийн талаар хэрэгцээтэй мэдээлэл өгнө.

(ХЭТТ-ын 23, 24 дугаа зүйл, ХЭтК-ын 31, 32, 36 дугаар зүйл)

Г Эрчим хүч

Аливаа зүйлийг хийхэд эрчим хүч зайлшгүй шаардлагатай. Илүү ихийг хийх тусам танд илүү их эрчим хүч хэрэгцээтэй болно. Ангидаа нарны гэрэл, хоол хүнс, нүүрс, хий, цахилгаан гэх мэт эрчим хүчний боломжит бүхий л эх үүсвэрийн талаар оюун бодлоо уралдуулах өрнүүлээрэй. Суралцагчдаас өдөрт хэрэглэж буй эрчим хүчний хэрэглээний талаар бүртгэл хөтлөхийг хүсээрэй. Тэдгээр эх үүсвэр нь хаанаас бий болсон, үүнийг ашигладаг хүмүүст хэрхэн хүрдэг болохыг олж мэдээрэй. Энэ нь “сэргээгдэх” эх үүсвэр үү? Эдгээр эрчим хүчний хэлбэрүүдийн байгаль орчинд үзүүлэх нөлөөг мөн ярилцана.

Сургуулийн эрчим хүчний тооцоо хийж болно. Эрчим хүчийг үр дүнгүй зарцуулж байгаа арга замууд нь юу вэ? Эрчим хүч хэмнэх талаар санал гарга. Үүнтэй ижил үйл явцыг гэр орон, олон нийтийн газар, бүс нутаг, дэлхий даяар хэрэглэж болно.

Орон нутгийг эрчим хүчээр хангах төхөөрөмжүүдийг зохион бүтээх, тэр ч байтугай бүтээхэд зориулж бүлгийн төслүүдийг зарлаарай. Энэ зорилгоор ашиглаж болохуйц орон нутгийн эх үүсвэр, нөөц юу байх вэ: салхи? нар? ус? чулуужсан түлш? хог хаягдал?

(ХЭТТ-ын 25 дугаар зүйл; ХЭтК-ын 27 дугаар зүйл)

Н Эрүүл мэнд

Эрүүл мэнд нь хүний үндсэн эрх бөгөөд дэлхийн хөгжлийн үндсэн зорилго юм. НҮБ-ын энэ чиглэлээр мэргэшсэн байгууллага болох ДЭМБ-ын олон тогтоолынзорилго бол дэлхийн хүн амын эрүүл



мэндийн байдлын тэгш бус байдлыг бууруулах шаардлагатай байгааг дахин нотолсон баримт бичиг юм. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэхэд хүн бүр эрүүл мэндээр хангагдаж байгаа ч ихэнх нөөц нь хамгийн хэрэгцээтэй хүмүүст хүрдэг байхын тулд хувь хүний болон хамтын үйл ажиллагааг шаарддаг. Орон нутгийн, үндэсний болон дэлхийн эрүүл мэндийн тогтолцоог судлах нь олон янзын, сонирхолтой төслүүдийг санал болгоно.

Ихэнх улс орнууд эрүүл мэндийн хичээлийг сургуулийнхаа хөтөлбөрт оруулж, сурагчдад хоол хүнс тэжээл, физиологи, өвчний шалтгаан, урьдчилан сэргийлэх талаар анхан шатны мэдээлэл өгдөг. Орон нутгийн эмч эсвэл эрүүл мэндийн ажилтнууд нь зочин илтгэгчийн хувьд эсхүл холбогдох баримт, санааг олж авч болох сайн эх сурвалж юм. Эмнэлэг, олон нийтийн эрүүл мэндийн төслүүдийг танилцах аялал зохион байгуулаарай.

Эрүүл мэндийн ерөнхий сэдэв нь эрүүл мэндийн салбар дахь охидын эсрэг ялгаварлан гадуурхалт, хүүхдийн хөдөлмөр, хүүхэд гэрлэлтийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөө, нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх мэдээлэл олж авах эрх, хүрээлэн буй орчны бохирдол, хоол тэжээлийн дутагдал, боловсролын эрүүл мэндэд үзүүлэх эерэг, сөрөг нөлөө зэрэг хүний эрхийн бусад чухал асуудлуудыг хамаарна.

(ХЭТТ-ын 2, 19, 25 дугаар зүйл;

ХЭТК-ын 2, 3, 17, 24, 17, 28 дугаар зүйл)

Эдийн засгийн хөгжил ба харилцан хамаарал

Түгээмэл тунхаглал, Хүүхдийн эрхийн тухай конвенцод хүний амьжиргааны зохистой түвшинд хүрэх эрхийг баталгаажуулсан хэд хэдэн заалт бий. Эдгээр нь хэрэгжих эсэх нь үндэсний нөөц, аж үйлдвэрийн хөгжил, эдийн засгийн тэргүүлэх чиглэл, улс төрийн хүсэл зоригоос шалтгаалах нарийн төвөгтэй асуудал юм. Үндэсний болон олон улсын үр дагавар бүхий эдийн засгийн хөгжлийн ололт амжилт нь эдгээр эрхийг хэрэгжүүлэхэд ихээхэн хамааралтай байдаг.

Дэлхийн нөөц ба түүний нөөц баялгийн хуваарилалт нь тэгш бус байдаг. Яагаад ийм байдалд хүрэв? Үүнд бүрэн хангалттай хариулахын тулд дэлхийн нийгэм, улс төрийн эдийн засгийн газрыг зураг, түүхийг бүхэлд нь дүрсэлж, тайлбарлах ёстой.

А Нэг улсын/дэлхийн



Суралцагчдаас дэлхийн өөр нэг хэсэгт өрнөж байгаа зүйл нь түүний амьдарч байгаа улсад хэрхэн нөлөөлж байгааг, эсхүл түүний амьдарч байгаа улс дэлхийн өөр хэсэгт хэрхэн нөлөөлж байгааг (жишээ нь байгаль орчин, эдийн засаг, эрүүл мэнд, улс төрийн асуудал; хоол хүнс, хувцас загвар, хөгжим болон соёлын бусад хэлбэрийн солилцоо; шилжилт хөдөлгөөн; импорт, экспорт, ялангуяа хүнс, нөөц баялгийн бүтээгдэхүүн) тодорхойлж, тайлбарласан нийтлэлүүдийг хайж олохыг суралцагчдаас хүсээрэй.

Ангийнхнаас олсон мэдээллийг төрлөөр (жишээ нь худалдаа, соёл, аялал жуулчлал, хүрээлэн буй орчин гэх мэт) нь ангилж, нийтлэл бүрийг холбогдох ангиллаар нэрлэнэ. Дэлхийн газрын зурагт тэмдэглэж, суралцагчдаас нийтлэлүүдийг ангилан бүлэглэхийг хүсээрэй. Нөлөөлөгч улс болон нөлөөлөлд өртөж буй улсуудын хооронд зурах эсвэл утсаар холбоно.

Хэлэлцэх асуудал:

- Дэлхийн аль хэсэгт хамгийн их холбоосууд байсан бэ? Хамгийн бага нь? Яагаад?
- Ямар төрлийн холбоосууд хамгийн их байсан бэ?
- Энэхүү үйл ажиллагаа нь бидний дэлхийн харилцан хамаарлын талаар ямар мэдээллийг харуулж байна вэ?

(ХЭТТ-ын 13, 19 дүгээр зүйл; ХЭТК-ын 17 дугаар зүйл)

В Хөдөлмөрийн асуудал

Ажилтнууд дарга эсвэл менежерүүдэд хандан хэд хэдэн хүсэлт гаргахааршийдсэн ажлын орчныг (жишээлбэл, үйлдвэр, тариалангийн талбай эсвэл ферм) дүрсэл. Тэд энэ газрыг хэрхэн удирдаж байгаа талаар илүү их зүйлийг хэлэхийг хүсэх бөгөөд цалингаа сайжруулах, өвчлөл, гэмтэл бэртлээс урьдчилан сэргийлэх, ажлын байрны аюулгүй байдалд илүү анхаарал хандуулах, боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх боломж, арай урт хугацаагаар амрахыг хүсэж байна.

Ангийг ажилтан, албан тушаалтнууд гэсэн хоёр бүлэгт хуваана. Тэдэнтэй хэлэлцээр хийж, талууд тайлангаа тавих төлөөлөгчдийг илгээнэ. Ажилчдын эрхийн талаарх холбогдох мэдээллийг авахын тулд Олон улсын хөдөлмөрийн байгууллагын конвенцтой танилцаарай. Дараа нь дүрээ солиод, уг дасгалын дахин хийгээрэй.

(ХЭТТ-ын 23 дугаар зүйл; ХЭТК-ын 32 дугаар зүйл)

С Харилцан хамаарал, үр дагаварын сүлжээ

Дэлхий ертөнц нь харилцан хамааралтай, харилцааны нарийн төвөгтэй сүлжээ бөгөөд тухайн сүлжээний хэсгүүдийн нарийн тэнцвэрт байдлыг үнэлэх шаардлагатай болохыг, түүнчлэн аль нэг хэсгийн өөрчлөлт бусад зүйлсэд нөлөөлдөг болохыг өнөөгийн залуучууд сайтар ойлгох шаардлагатай. Тухайлбал, нэг газрын орчны бохирдол нь бусад олон газрын хүнсний сүлжээ, эрүүл мэнд, амьдралын нөхцөл, амьжиргаанд сөргөөр нөлөөлдөг. Асуудлууд ч мөн өөр хоорондоо холбоотой. Ядуурал нь олон хүчин зүйлээс үүдэлтэй байж болох бөгөөд ядуурлыг арилгах аливаа хүчин чармайлтыг цогцоор нь авч үзэх шаардлагатай.

Суралцагчдад эдгээр харилцан хамаарлын нарийн төвөгтэй байдлыг ойлгоход нь туслахын тулд ангийг тэгш тоотой жижиг бүлгүүдэд хувааж, тус бүрт нь нэг нэг бодомж өгөх бөгөөд дор хаяж хоёр бүлэг адилхан бодомж авах ёстой. Эдгээр өгүүлбэр нь баримтыг (жишээ нь, “Хүн амын 30-аас доошгүй хувь нь ХДХВ-ДОХ-ын халдвартай” гэх мэт) эсвэл “Хэрэв яах вэ” гэсэн бодомжийг (жишээ нь, “Эмэгтэйчүүд эрчүүдтэй адил их өмчтэй байсан бол яах вэ”) илэрхийлсэн байх ёстой. Бүлэг бүр өөрсдийн бодомжийг хүснэгтийн цаасны дээд талд бичнэ. Бодомжийн доор уг асуудалд хамаарах гурван үр дагаврыг бичих ёстой (тухайлбал, “Олон хүүхдийн эцэг эх нас барна”, “ХДХВ-ДОХ-ын халдвартай олон хүүхэд төрөх болно”, “Үндэсний эрүүл мэндийн тусламж үйлчилгээ маш олон өвчтэй хүмүүсийн ачаалалд өртөх болно”). Дараа нь эдгээр гурван үр дагавар тус бүрээс үүдэх гурван үр дагаврыг бичнэ (жишээ нь: “Олон хүүхэдтэй эцэг эх нь нас барна” гэсний дор “Өнчин хүүхдүүдийг асарч буй гэр бүл, нийгмийн үйлчилгээ хэт ачаалалтай болно”, “Ажилчид цөөрнө”, “Тэднийг зөв хүмүүжүүлэх эцэг эхгүй олон хүүхэд бий болно” гэх мэт). Энэ маягаар нүдэнд харагдах, цаашид нэмж хөгжүүлэх боломжтой харилцан хамаарал, үр дагаварын сүлжээг гаргах юм. Ижил бодомж дээр ажиллаж байгаа бүлгүүдийг ажлаа харьцуулж, ярилцахыг хүсээрэй. Диаграммуудыг үзүүлээд “галерейгаар алхаарай”. Ингэснээр суралцагчид өөрсдийн бий болгосон харилцан хамаарал, үр дагаврын сүлжээг ангийн бусад гишүүдэд тайлбарлах боломжтой болно.

Эдгээр сүлжээний хүний эрхийн үр дагавар, нэг асуудал нийгмийн олон талт болон олон улс оронд хэрхэн нөлөөлж байгааг ярилцаарай.

(ХЭТТ-ын 28 дугаар зүйл; ХЭТК-ын 3 дугаар зүйл)

D Хөгжлийн асуудлаарх илтгэгчид

Хүний эрхийн клубын нэрийн дор зарим илтгэгчдийг хөгжлийн асуудалтай холбоотойгоор ангидаа урьж ярилцлага хэлэлцүүлэг зохион байгуулаарай. Суралцагчдад үндсэн мэдээлэл өгч, илтгэгчээс асуух асуулт боловсруулахад нь туслах зэргээр арга хэмжээнд бэлтгэнэ. Хэлэлцсэн асуудлын талаар (жишээ нь, газарзүйн бүс нутаг, нийгмийн тодорхой хэсэг, орчин үеийн байдал, хүнд суртал, даяаршил, хотжилт, соёлын үнэт зүйлсийн өөрчлөлт гэх мэт хүн бүрд нөлөөлдөг тусгай асуудлууд) цаашид үргэлжлүүлэн судлахын тулд ангийн бүлгүүдэд хувааж, үр дүнгийн талаар хэлэлцээрэй.

(ХЭТТ-ын 19, 25 дугаар зүйл; ХЭТК-ын 6, 27 дугаар зүйл)

Бизнес ба хүний эрх

20-р зууны дунд үеэс эхлэн Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон хөгжиж буй хүний эрхийн тогтолцоо нь засгийн газрууд иргэдтэйгээ хэрхэн харилцах асуудлыг голчлон авч үзсэн. Гэвч дэлхийн эдийн засгийн үр дүнд эдүгээ олон бизнесүүд санхүү, эрх мэдэл, хүмүүсийн амьдралд үзүүлэх нөлөөгөөр засгийн газруудаас хэдийн хол давсан. Засгийн газар иргэдийнхээ өмнө хуулийн дагуу хариуцлага хүлээдэг бол бизнесүүд, ялангуяа дэлхийн өөр өөр улсад үйл ажиллагаа явуулдаг бизнесүүд хувьцаа эзэмшигчдийнхээ өмнө хуулийн дагуу хариуцлага хүлээж, харин хүний эрхийн үүрэг хариуцлага төдийлөн хүлээдэггүй. Үүний үр дүнд эдгээр үндэстэн дамнасан корпорацууд хүний эрхийн асуудлын төвд байх нь улам бүр нэмэгдэж байна.

A Бизнесүүд хариуцлагатай байх ёстой юу?

Эдгээр асуудлыг ярилцаарай:

- Үндэстэн дамнасан томоохон бизнес ажилчдынхаа хүний эрхийг ямар хэлбэрээр зөрчиж болох вэ? Мөн бусад хүмүүсийн эрхийг хэрхэн зөрчдөг вэ?
- Ийм бизнес хүний эрхийг хангахын тулд ямар арга замаар нөлөөгөө ашиглаж болох вэ?
- Хүний эрхийн стандартыг мөрдөх нь бизнест хэрхэн ашигтай байж болох вэ? Энэ нь яагаад сул тал байж болох вэ?

- Бизнес нь хүний эрхийн стандартыг сахин мөрдөх үүрэг хариуцлага хүлээх ёстой юу?
- Иргэд, төрийн бус байгууллагууд (ТББ) аж ахуйн нэгжүүдэд хүний эрхийн стандартыг мөрдүүлэхэд хэрхэн шахалт үзүүлэх вэ?

(ХЭТТ-ын 28 дугаар зүйл; ХЭтК-ын 3, 6 дугаар зүйл)

Б Байгууллагын ёс зүйн дүрэм

Зарим бизнес эрхлэгчид хүний эрхийн хэм хэмжээг дагаж мөрдөх дарамт шахалтад хариу арга хэмжээ авч, бүх компани, бизнесийн түншүүддээ хэрэглэх байгууллагын ёс зүйн дүрмийг бий болгосон.

Таныг үндэстэн дамнасан томоохон корпорацид (жишээ нь, хувцас үйлдвэрлэгч, газрын тосны компани) ёс зүйн дүрмийг боловсруулахад нь туслахаар ажилд авсан гэж төсөөлөөрэй. Жижиг бүлгүүдэд ажиллаж, аж ахуйн нэгжүүд ажлынхаа бүх талаар баримтлах ёстой зарчмуудын жагсаалтыг гаргаарай. Хүний эрх, хөдөлмөрийн үйл ажиллагаа, байгаль орчны асуудлуудыг оруулахаа мартуузай. Гаргасан зүйлсээ харьцуулж, нэгтгэн эцсийн баримт бичгийг боловсруулаарай.

Та жагсаалтаа НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Кофи Аннаны 1999 онд гаргасан «Дэлхийн гэрээ» зарчмуудын жагсаалттай (<http://www.unglobalcompact.org> эсвэл НҮБ-тай холбоо барина уу) харьцуулж үзээрэй.

(ХЭТТ-ын 3, 28 дугаар зүйл; ХЭтК-ын 3, 6 дугаар зүйл)

В Бизнесийн бүлгийн илтгэгчид

Орон нутгийн бизнесийн холбоод (худалдааны танхим, Ротари клуб, банкирууд эсвэл худалдаачдын холбоо гэх мэт) болон шударга/ёс зүйтэй худалдааны санаачилгад оролцдог төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөллийг урьж, орон нутгийн худалдаа дэлхийн эдийн засагт хэрхэн нөлөөлж байгаа талаар ярилцаж, хүний эрхийн төлөөх компаний хариуцлагын талаарх тэдний байр суурийг тайлбарлана. (ХЭТТ-ын 19, 23, 25 дугаар зүйл; ХЭтК-ын 3, 6, 17, 27 дугаар зүйл)

Нэгдсэн Үндэстний Байгууллагын талаарх ойлголт



Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 26 дугаар зүйлд боловсрол нь "... Нэгдсэн Үндэстний Байгууллагаас энх тайвныг сахиулах талаар явуулж буй үйл ажиллагаанд дөхөм үзүүлэх ёстой" хэмээн заасан. Суралцагчид НҮБ-ын гишүүн улс орнуудын "элчин сайд"-ын үүргийг гүйцэтгэдэг НҮБ-ын загвар хуралдаан нь НҮБ-ын хязгаарлагдмал байдал болон боломжийг суралцагч нарт ойлгуулах боловсролын хүчирхэг хэрэгсэл юм.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын ихэнх загвар хуралдааны хөтөлбөр нь гурван үндсэн алхам дээр суурилдаг.

1. **Бэлтгэл:** Суралцагчид үндсэн гурван сэдвээр судалгаа хийнэ.
 - (а) НҮБ ба түүний үйл ажиллагаа;
 - (б) НҮБ-ын гишүүн улсын Засгийн газар, бодлого, ашиг сонирхол;
 - (в) Хэлэлцэх асуудлын жагсаалтад байгаа дэлхийн асуудлууд.

Судалгаа нь томилогдсон гишүүн улсын хувьд «байр суурийн талаарх баримт бичиг» эсвэл тогтоол, хэлэлцээрийн стратегийг боловсруулахад чиглэнэ.
2. **Оролцоо:** Суралцагчид гишүүн орнуудын "элчин сайд" болж, илтгэх, сонсох, цагийг удирдах, хэлэлцээ хийх, зөвлөлдөх чадварыг эзэмшсэнээр судалгааны бодит үр дүнг хэрэгжүүлж эхэлдэг.
3. **Үнэлгээ:** Дасгалыг дуусгахад сайтар дүгнэлт хийж, үнэлгээ хийх нь чухал. Загварчилгаа нь тал тус бүрд (жишээ нь, судалгаа, танилцуулга, хэлэлцээр) амжилтад хүрэхийн тулд зарим шалгуурыг боловсруулсан байх ёстой.

Энэхүү үйл ажиллагаанд багш шинжээчийн үүрэг гүйцэтгэхгүй, харин суралцагч нар судалгаа шинжилгээ хийхэд туслах хөтөч юм. Доорх загвар НҮБ-ын үйл ажиллагааны хялбаршуулсан хувилбар бөгөөд НҮБ-ын Загвар хөтөлбөрүүдийн талаарх нэмэлт мэдээллийг Хавсралт С дахь нөөцийн жагсаалтаас харна уу. НҮБ-ын загвар хөтөлбөрүүдийн талаар нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл НҮБ-ын Холбооны Дэлхийн Холбоотой холбогдоно уу (хавсралт 4-ийг үзнэ үү).

НҮБ-ын загвар хуралдааныг турших нь

Суралцагчид анхаарлаа хандуулах шаардлагатай дэлхийн хэмжээнд чухал хэдэн асуудлыг сонгоно. НҮБ-ын гишүүн орнуудыг төлөөлөх, судлах зорилгоор хувь хүн эсвэл суралцагчдын бүлгийг байгуулна. Судалгааны зорилго нь тухайн улсыг танин мэдэх, гол асуудлуудыг хэрхэн авч үзэхийг ойлгох явдал гэдгийг сайтар тайлбарлана.

Суралцагчид судалгаагаа дуусгасны дараа «элчин сайд» бүрээс улс орон эсвэл бүс нутагтаа чухал ач холбогдолтой нэг чухал асуудлын талаар «Ерөнхий Ассемблей»-д зориулж тогтоол бичихийг хүснэ. Тогтоолд НҮБ ямар үүрэг гүйцэтгэх ёстойг багтаасан асуудлын дэлгэрэнгүй тайлбар, нөхцөл байдлыг сайжруулах төлөвлөгөөг тусгасан байх шаардлагатай. Суралцагчид өөрсдийн шийдвэр нь хүн бүрд ашиг тустай бөгөөд зайлшгүй анхаарал хандуулах ёстой асуудал гэдгийг бусдад итгүүлэх шаардлагатай. Суралцагчдыг шийдвэрээ харьцуулж, дэмжигч болон/эсвэл хамтран ивээн тэтгэгч хайхад дэмжлэг үзүүлнэ. Тогтоолдоо нэмэлт өөрчлөлт оруулахад бэлэн байх, тэдгээрийг батлахын тулд зөвшилцөлд хүрэх хэрэгтэйг тайлбарлана.

НҮБ-ын загвар хуралдааныг зохион байгуулаарй. Суралцагчдыг урд нь улс орныхоо нэрийг бичсэн суудалд тойрог болгон суулгана. Багш эсвэл чадварлаг өөр нэгэн суралцагчаар “Ерөнхий нарийн бичгийн дарга”-ын үүргийг гүйцэтгүүлнэ. Хэлэлцүүлгийн зарим дүрмийг бий болгоно. (жишээ нь, хүн бүрийг “Элчин сайд” гэж нэрлэнэ; “Ерөнхий нарийн бичгийн дарга” хүлээн зөвшөөрөөгүй бол хэн ч үг хэлж болохгүй).

“Ерөнхий нарийн бичгийн дарга” тогтоолуудыг танилцуулах, хэлэлцэх, асуулт асуух, санал хураалт явуулахаар зарлана. Боломжит тогтоолын талаар хэлэлцсэний дараа уг тогтоолыг санал хураалтад оруулахаар хэн ч санаачилж болно. Саналыг батлахын тулд өөр нэгэн улсын “элчин сайд” мөн дэмжсэн байх шаардлагатай. Шийдвэр гаргахын тулд гуравны хоёрын олонхын санал шаардлагатай.

НҮБ-ын загвар хуралдааныг турших үйл явцыг дуусгахдаа суралцагчид өөрийгөө мөн бусад суралцагчдын НҮБ болон түүний дэлхийд гүйцэтгэх үүрэгтэй холбоотойгоор сурч мэдсэн зүйлсээ аман эсвэл бичгэн байдлаар үнэлнэ.

(ХЭТТ-ын 1, 28, 30 дугаар зүйл; ХЭТК-ын 3 дугаар зүйл)

Хүний эрхэд ээлтэй орчныг бий болгох

Хүний эрхийн боловсролын эцсийн зорилго бол хүний эрхийн жинхэнэ соёлыг бий болгох явдал юм. Ингэхийн тулд суралцагчдад өөрсдийнхөө зан үйл болон амьдарч буй ойр тойрны бүлгээс эхлээд хүний эрхийн үүднээс үнэлж сурах ёстой. Тэд өдөр тутмын бодит байдал нь хүний эрхийн зарчимд хэрхэн нийцэж байгаа талаар шударга үнэлэлт дүгнэлт хийж, улмаар хамт олноо сайжруулахын төлөө идэвхтэй хариуцлага хүлээх учиртай.

Сургуулийнхаа хүний эрхийн орчныг хэмжих¹³

Доорх судалгааг бөглөж, сурагчдаас сургуулийнхаа хүний эрхийн уур орчин буюу «температур»-ыг хэмжихийг хүсээрэй. Дараах чиглэлээр үр дүнг үнэлж, ярилцана:

- Танай сургууль хүний эрхийн ямар зарчмуудыг дэмжиж байгаа санагддаг вэ?
- Аль салбарт хүний эрхийн асуудал байгаа гэж үзэж байна вэ?
- Ийм асуудалтай нөхцөл байгааг та хэрхэн тайлбарлах вэ? Тэд ялгаварлан гадуурхалттай холбоотой юу? Шийдвэр гаргахад оролцох уу? Гарч буй хүний эрхийн зөрчил нь хэн нэгэнд ашигтай юу?, хэн хохирох вэ?
- Та болон бусад бүлгийн гишүүд одоо байгаа хүний эрхийн уур амьсгалыг сайжруулах, эсхүл улам дордуулахад хувь нэмрээ оруулсан уу?
- Танай сургуулийн хүний эрхийн орчныг сайжруулахын тулд юу хийх шаардлагатай вэ?

Зорилго, стратеги, үүрэг хариуцлагыг тодорхойлж ангиараа үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулна.

¹³ Adapted from *Social and Economic Justice: A Human Rights Perspective* by David Shiman (University of Minnesota Human Rights Resource Center, 1999).

Сургуулийнхаа хүний эрхийг хэмжих

Чиглэмж: Өгөгдөл нэг бүрийг сайтар уншиж, танай сургуулийн хамт олныг хэр үнэн зөв тодорхойлж байгааг үнэлээрэй. Сургуулийнхаа бүх гишүүд буюу суралцагчид, багш нар, удирдлагууд, ажилтнуудыг бүхэлд нь хамруулна. Сургуулийнхаа ерөнхий үнэлгээг тодорхойлохын тулд онооны нийлбэрийг гаргаарай.

Үнэлгээний түвшин:

				
1	2	3	4	DN
Хэзээ ч үгүй (үгүй/буруу)	Хаяа	Ихэвчлэн	Байнга (тийм/зөв)	мэдэхгүй

1. Сургуулийн хамт олны гишүүдийг арьсны үндэс, хүйс, гэр бүл, хөгжлийн бэрхшээлтэй байдал, шашин шүтлэг, амьдралын хэв маягаар нь ялгаварлан гадуурхдаггүй.
(ХЭТТ-ын 2, 16 дугаар зүйл; ХЭТК-ын 2, 23 дугаар зүйл) ☐
2. Манай сургууль бол миний аюулгүй, аюулгүй газар юм.
(ХЭТТ-ын 3, 5 дугаар зүйл; ХЭТК-ын 6, 37 дугаар зүйл) ☐
3. Бүх суралцагчид сурлага, карьерын боломжуудын талаар ижил мэдээлэл, урам зоригийг авдаг.
(ХЭТТ-ын 2, 26 дугаар зүйл; ХЭТК-ын 2, 29 дүгээр зүйл) ☐
4. Манай сургууль хүн бүрт тэгш хүртээмж, нөөц, үйл ажиллагаа, хэрэгслээр хангадаг.
(ХЭТТ-ын 2, 7 дугаар зүйл; ХЭТК-ын 2 дугаар зүйл) ☐
5. Манай сургуулийн хамт олны гишүүд сургууль доторх ялгаварлан гадуурхсан үйлдэл, материал, үг хэллэгийг эсэргүүцдэг.
(ХЭТТ-ын 2, 3, 7, 28, 29 дугаар зүйл; ХЭТК-ын 2, 3, 6, 30 дугаар зүйл) ☐
6. Хэн нэгэн өөр хүний эрхийг зөрчсөн тохиолдолд буруу зан үйлээ хэрхэн өөрчлөх талаар суралцахад нь тусалдаг.
(ХЭТТ-ын 26 дугаар зүйл; ХЭТК-ын 28, 29 дүгээр зүйл) ☐
7. Манай сургуулийн хамт олны гишүүд миний боловсролын хөгжилд санаа тавьж, шаардлагатай үед надад туслахыг хичээдэг.
(ХЭТТ-ын 3, 22, 26, 29 дугаар зүйл; ХЭТК-ын 3, 6, 27, 28, 29, 31 дугаар зүйл) ☐
8. Зөрчилдөөн үүсэх үед бид асуудлыг хүчирхийлэлгүй, хамтран ажиллах замаар шийдвэрлэхийг хичээдэг.
(ХЭТТ-ын 3, 28 дугаар зүйл; ХЭТК-ын 3, 13, 19, 29, 37 дугаар зүйл) ☐
9. Сургууль нь ялгаварлан гадуурхалттай холбоотой бодлого, журамтай бөгөөд зөрчил гарсан тохиолдолд тэдгээрийг ашигладаг.
(ХЭТТ-ын 3, 7 дугаар зүйл; ХЭТК-ын 3, 29 дүгээр зүйл) ☐
10. Сахилга баттай холбоотой асуудлаар хүн бүр гэм бурууг тогтоох, шийтгэл оногдуулахдаа шударга, хараат бусаар хандах баталгаа хангагдсан
(ХЭТТ-ын 6, 7, 8, 9, 10 дугаар зүйл; ХЭТК-ын 28, 40 дугаар зүйл) ☐
11. Манай сургуульд хэн ч хүний нэр төрийг гутаан доромжилж, шийтгэдэггүй
(ХЭТТ-ын 5 дугаар зүйл; ХЭТК-ын 13, 16, 19, 28 дугаар зүйл) ☐

12. Буруу зүйлд буруутгагдаж байгаа хүн гэм буруутай нь нотлогдох хүртэл гэм буруугүйд тооцогдоно
(ХЭТТ-ын 11 дүгээр зүйл; ХЭТК-ын 16, 28, 40 дүгээр зүйл) ☐
13. Миний хувийн орон зай, эд хөрөнгийг хүндэтгэдэг
(ХЭТТ-ын 12, 17 дугаар зүйл; ХЭТК-ын 16 дугаар зүйл) ☐
14. Манай сургуулийн хамт олон энэ улсад төрөөгүй хүмүүсийг оролцуулаад янз бүрийн үндэс угсаа, соёл бүхий суралцагч, багш нар, удирдлага, ажилтнуудыг угтан авдаг.
(ХЭТТ-ын 2, 6, 13, 14, 15 дугаар зүйл, ХЭТК-ын 2, 29, 30, 31 дүгээр зүйл) ☐
15. Ялгаварлан гадуурхагдана гэх айдасгүйгээр би өөрийн итгэл үнэмшил, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй.
(ХЭТТ-ын 19 дүгээр зүйл; ХЭТК-ын 13, 14 дүгээр зүйл) ☐
16. Манай сургуулийн гишүүд цензур, шийтгэлээс айхгүйгээр нийтлэл бэлтгэж, түгээх боломжтой.
(ХЭТТ-ын 19 дүгээр зүйл; ХЭТК-ын 13 дугаар зүйл) ☐
17. Төрөл бүрийн үзэл хандлагыг (жишээ нь, жендэр, арьс үндэс/үндэс угсаа, үзэл суртал) сурах бичиг, чуулган, номын сан, танхимын зааварчилгаанд тусгасан байдаг.
(ХЭТТ-ын 2, 19, 27 дугаар зүйл; ХЭТК-ын 17, 29, 30 дугаар зүйл) ☐
18. Би сургуулийнхаа соёлын арга хэмжээнд оролцох боломжтой бөгөөд миний соёлын онцлог, хэл, үнэт зүйлийг хүндэтгэдэг.
(ХЭТТ-ын 19, 27, 28 дугаар зүйл; ХЭТК-ын 29, 30, 31 дүгээр зүйл) ☐
19. Манай сургуулийн гишүүд сургуулийн бодлого, дүрмийг боловсруулах ардчилсан шийдвэр гаргахад оролцох боломжтой.
(ХЭТТ-ын 20, 21, 23 дугаар зүйл; ХЭТК-ын 13, 15 дугаар зүйл)
20. 20. Манай сургуулийн гишүүд өөрсдийн болон бусдын эрхийг хамгаалах зорилгоор сургууль дотроо эвлэлдэн нэгдэх эрхтэй.
(ЭЗБНХУ-ын 19, 20, 23 дугаар зүйл; ХХЗХ-ны 15 дугаар зүйл) ☐
21. Манай сургуулийн гишүүд шударга ёс, экологи, ядуурал, энх тайвантай холбоотой нийгэм, дэлхий нийтийн тулгамдсан асуудлын талаар бие биенээ дэмждэг
(ХЭТТ-ын оршил, 26, 29 дугаар зүйл; ХЭТК-ын 29 дүгээр зүйл) ☐
22. Манай сургуулийн гишүүд шударга ёс, экологи, ядуурал, энх тайван зэрэгтэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэхийн тулд бие биенээ зохион байгуулж, арга хэмжээ авахыг уриалдаг
(ХЖЭТТ-ын оршил, 20, 29 дүгээр зүйл; ХЭТК-ийн 29 дүгээр зүйл) ☐
23. Манай сургуулийн хамт олны гишүүд хичээлийн цагаар хангалттай амрах, завсарлага авах, шударга хөдөлмөрийн нөхцөлд боломжийн цагаар ажиллах боломжтой.
(ХЭТТ-ын 23, 24 дугаар зүйл, ХЭТК-ын 31, 32 дугаар зүйл) ☐
24. Манай сургуулийн ажилтнууд өөрсдийн болон гэр бүлийнхээ эрүүл мэнд, сайн сайхан байдалд тохирсон амьжиргааны түвшинтэй байхаар хангалттай цалин авдаг.
(ХЭТТ-ын 22, 25 дугаар зүйл; ХЭТК-ын 27 дугаар зүйл) ☐
25. Би сургуульдаа хүмүүсийг ялгаварлан гадуурхахгүй байх үүрэгтэй.
(ХЭТТ-ын 1, 29 дүгээр зүйл; ХЭТК-ын 29 дүгээр зүйл) ☐

Боломжит температур =

100 хүний эрхийн түвшин

Танай сургуулийн температур =

_____ хүний эрхийн түвшин



ДӨНГӨЖ ЭХЛЭЛ ...

АБВ: Хүний эрхийг заах нь нь эхлэл болохоостөгсгөлбиш. Энэ нь зааварчилгаа биш харин санал юм. Үүний зорилго нь хэлэлцүүлэг, санаа бодлыг өдөөх, улмаар хүүхдүүдэд эрх, хариуцлагын талаар бодитой, үндсэн ойлголтыг төлөвшүүлэх, ингэснээр хүний эрхийн зарчмуудыг хүн төрөлхтөн оршин тогтнох хэмжээнд бүрэн хэрэгжүүлэхэд нь туслах явдал юм.

Энэхүү товхимол нь багш нарыг чадавхжуулах, тэдэнд урам зориг өгөх, тэднийг сургуулийнхаа сургалтын хөтөлбөр, соёлд хүний эрхийг тусгах хамгийн үр дүнтэй заах арга, стратегийг олоход нь дэмжлэг үзүүлэх зорилготой. Багш нар бусад хүний эрхийн сургагчдыг хайх, санаа, туршлагаа хуваалцах сүлжээг бий болгохыг зөвлөж байна.

Гэхдээ хүний эрхийн боловсролын бүхий л хүчин чармайлт нь зарим үндсэн шинж чанарыг илэрхийлдэг:

- Хүний нэр төр, эрх тэгш байдал зэрэг хүний эрхийн түгээмэл зарчмуудын үнэт зүйлсийн үндсэн тогтолцоо;
- Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, Хүүхдийн эрхийн конвенц зэрэг хүний эрхийн үндсэн баримт бичгүүдэд үндэслэсэн агуулга;
- Хүний эрхийн түгээмэл, салшгүй, харилцан хамааралтай байдлыг хүлээн зөвшөөрөх;
- Хүний эрх, хувь хүн, төрийн үүрэг хариуцлагын харилцан хамаарлыг ойлгох;
- Хүний эрхийн тухай ойлголт нь хүний хэрэгцээний талаарх хөгжиж буй ойлголттой уялдан хөгжих, олон улсын тавцанд тулгамдаж буй асуудлаа хүргэхэд иргэд, төрийн бус байгууллагуудын үүрэг оролцооны үйл явц юм. 1948 онд Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал батлагдах үед байгаль орчны бохирдлын талаар санаа зовниж байсан хүн цөөхөн байсан. Харин эдүгээ цэвэр агаар, цэнгэг усыг хүний үндсэн эрх гэж үзэх нь улам бүр нэмэгдэж, байгаль орчны асуудлыг шийдвэрлэх олон улсын эрх зүйн баримт бичгүүдийг хэлэлцэж байна.

Эцэст нь хэлэхэд, хүний эрх гэдэг нь хаа нэгтээ бусад хүмүүст тохиолдох зөрчлийн тухай биш гэдгийг суралцагчид сайтар ойлгох хэрэгтэй. Хүний эрхийн нь «[Түгээмэл] Тунхаглалд заасан эрх, эрх чөлөөг бүрэн хэрэгжүүлэх боломжтой нийгэм, олон улсын дэг журамд» «хүний хувийн шинж чанарыг бүрэн хөгжүүлэхэд» хүрэх бүх хүмүүсийн эрх, түүний олон янз байдлын тухай асуудал юм.



(ХЭТТ, 26, 28 дугаар зүйл).

Суралцаж олсон авсан зүйлээ өөрсдийн нийгмийн орчинд хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалахад хэрхэн хамгийн сайн ашиглаж болох талаар тунгаан бодоход суралцагчдыг дэмжээрэй. Ийм арга хэмжээ нь энэ товхимол дахь хүний эрхийн зарчмуудыг нийгэмд практикт хэрэгжүүлэхэд чиглэсэн олон үйл ажиллагаанд тулгуурлана. Энэ нь эдгээр хичээлүүдийг нэгтгэж, сурагчдыг анги, сургуулиас гадуур одоо болон насанд хүрэгчдийн амьдралд хувь нэмрээ оруулахад шаардлагатай ур чадваруудыг бий болгоход чиглүүлнэ.





ХҮНИЙ ЭРХИЙГ ЗААХ НЬ

Бага, дунд сургуулиудад
зориулсан практик
үйл ажиллагаа

